



4-Р САРЫН 17, 2023
ХҮН ХУДАЛДААЛАХ ХЭРГИЙН
СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ
2017-2022 он

ГАНБАЯСГАХ ГЭЛЭГ
ЗӨВЛӨХ



АГУУЛГА

Товчилсон үгийн жагсаалт

Өмнөх үг

1. ТАНИЛЦУУЛГА
2. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ
 - 2.1. Хүн худалдаалах хэргийн дотоод нөхцөл байдал
 - 2.2. Хүн худалдаалах хэргийн гадаад нөхцөл байдал
3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГО
4. ХОХИРОГЧ ХАМГААЛАЛТ
5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ
6. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЛТ
7. ХАМТЫН АЖИЛЛАГАА

ТОВЧИЛСОН ҮГИЙН ЖАГСААЛТ

ААНБ	Бүгд Найрамдах Хятад Ард Улс
БНХАУ	Боловсрол шинжлэх ухааны яам
БШУЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
БОАЖЯ	Гадаад харилцааны яам
ГХЯ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлын зохицуулах зөвлөл
ГХУСАЗЗ	Гадаад иргэн харьяатын газар
ГИХГ	
ЛГБТ	
НҮБ-ын ОУШХБ	Нэгдсэн Үндэсний Байгууллагын Олон улсын шилжилт хөдөлгөөний байгууллага
ОУБ	Олон улсын байгууллага
ТББ	Төрийн бус байгууллага
ТЕГ	Тагнуулын ерөнхий газар
ХЗДХЯ	Хууль зүй, дотоод хэргийн яам
ХНХЯ	Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХГХ	Хүн худалдаалах гэмт хэрэг
ЦЕГ	Цагдаагийн ерөнхий газар
ШШҮХ	Шүүх шинжилгээний үндэсний хүрээлэн
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЦА	Эрүүгийн цагдаагийн алба

ӨМНӨХ ҮГ

1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсад хүний наймаатай тэмцэх чиглэлээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012), Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2013), Эрүүгийн хууль (2015), Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017) болон хуулийг даган гарсан 20 гаруй журам, Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2017-2021) зэрэгт дурдагдсан хохирогч хамгааллын үйл ажиллагаа хэрхэн хэрэгжиж байгаа бөгөөд эдгээр хуулийн хэрэгжилт, үр дагавар, нийгэмд болон хохирогчид үзүүлж буй нөлөөллийн талаар олон судалгаанууд хийгдсээр ирсэн. Энэ чиглэлээр бодлого, үйл ажиллагааны өнөөгийн байдал, бодлого, хууль эрхзүйн орчин, хохирогч хамгаалал, хэргийн шийдвэрлэлтийн талаар олон судалгаа хийгдэж, бодлого, үйл ажиллагаанд анхаарах асуудлуудын талаар үнэтэй санал зөвлөмжүүд гаргадаг. Асуудлыг олон талаас хөндсөн сайн мэдээллүүд нэгтгэгдэг боловч судалсан ажлын хүрээ нь давхцах, танилцуулга олон нийтэд болон бодлого боловсруулагч, хэрэгжүүлэгчдэд хүртээмжтэй биш байдаг нь судалгааны ажлын зорилго, гол үр дүнгээ алдахад хүргэдэг.

Тиймээс ГХУСАЗЗ-ын захиалгаар судалгаануудын дүгнэлтэд үндэслэн дэвшүүлсэн санал зөвлөмжийг хэрэгжүүлэхэд дэмжлэг болох зорилгоор тоймлон бэлтгэлээ. Судалгааны хүрээнд олон улсын, үндэсний эрх зүйн баримт бичгүүд, сүүлийн гурван жилийн хугацаанд буюу 2019-2021 оны хооронд ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр төр, төрийн бус (ТББ) болон олон улсын байгууллагуудаас гаргасан нийт 20 гаруй судалгаанаас 12 судалгааны тайлангуудад баримт бичгийн шинжилгээ хийж, дүгнэлт зөвлөмжийг хураангуйлан боловсрууллаа. *(Хавсралт 1. Судалгааны үр дүнгийн нэгдсэн хураангуй).*

Судалгаануудын мэдээллийг нэгтгэж, дүн шинжилгээ хийхдээ хууль эрхзүйн, бодлогын асуудал болон ХХГХ-тэй тэмцэх чиглэлд олон улсад нийтлэг ашиглагддаг 4П-ийн хүрээнд буюу хохирогч хамгаалал, урьдчилан сэргийлэх, хэргийн шийдвэрлэлт, хамтын ажиллагаа гэсэн агуулгын хүрээнд, цаашид манай улсад хийх шаардлагатай гэж үзсэн дүгнэлт, зөвлөмжүүдийг нэгтгэн танилцуулж байна.

2. МОНГОЛ УЛС ДАХЬ ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН НӨХЦӨЛ БАЙДАЛ

Монгол Улсын Засгийн газраас хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр тогтвортойгоор хүчин чармайлт гаргаж ирсэн ба хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагаа нь хэдийгээр манайд шинэ тутам сонсогддог ч хэдийнээ 20 гаруй жилийн туршлага хуримтлуулжээ. Монгол Улсын Засгийн газраас ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр тасралтгүйгээр, жилийн жилд ахисан түвшинд ажиллаж буй бөгөөд АНУ-ын Төрийн Департаментаас жил бүр эрхлэн гаргадаг “Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай” тайланд 2006 оноос эхлэн тайлангаа тогтмол илгээдэг ба хүн

худалдаалахтай тэмцэхэд ихээхэн хүчин чармайлт гаргаж байгаа улс орнуудын нэгээр үнэлэгдэж 15 удаа хоёрдугаар шатлалд эрэмбэлэгдэж ирсэн.

Монгол Улс анх 2002 оны Эрүүгийн хуулийн 113 дугаар зүйл буюу Хүн худалдах, худалдан авах гэсэн бие даасан эрүүгийн гэмт хэргийг хуульчилж, 2008 онд НҮБ-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт протокол болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол (Палермогийн протокол)-д нэгдэн орж, дотоодын хууль тогтоомжуудаа олон улсын стандартад нийцүүлэх ажлыг үе шаттайгаар хийсээр ирсэн. Палермогийн протокол нь хүн худалдаалах гэмт хэргийн талаар олон улсын түвшинд харилцан тохиролцсон тодорхойлолт бүхий албан ёсны хууль ёсны хэрэгсэл бөгөөд 2020 оны тавдугаар сарын байдлаар 178 улс энэхүү Протоколд нэгдсэн байна. Эрүүгийн хуульд 2008, 2015 онуудад нэмэлт өөрчлөлт оруулан, Палермогийн протоколын үндсэн зорилгын тодорхойлолтод нийцүүлэх алхмууд хийгдсээр байна.

2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай бие даасан хууль баталж, энэ гэмт хэрэгтэй тэмцэх, хохирогчийг хамгаалахад салбар тус бүрийн үүрэг, оролцоог тодорхойлж өгсөн. Хохирогчийн зөрчигдсөн эрхийг сэргээх тал дээр бодлогын томоохон өөрчлөлтүүд гарсан нь Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг баталж, Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд хохирогчийн эрхийг хамгаалах бүлэг орсон. Түүнчлэн, ХХГХ-тэй тэмцэх бодлого, хэрэгжилтийн хувьд олон ахиц гарч, Хүн худалдаалахтай тэмцэх Үндэсний хөтөлбөр (2005-2011, 2017-2021), Гэрч, хохирогчийг хамгаалах үндэсний хөтөлбөр (2016-2024)-ийг батлан хэрэгжүүлж, үйл ажиллагаа, бодлого, салбар дундын хамтын ажиллагааг удирдан зохицуулах Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлийг байгуулан ажиллаж, тодорхой үр дүнгүүд гарч эхэлж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийг илрүүлэх, мөрдөн шалгах, шийдвэрлэх тал дээр багагүй хүчин чармайлт гарч байгаа хэдий ч цагдаагийн байгууллагаас илрүүлсэн 2 хэрэг тутмын нэг нь шүүхэд шилжиж, шүүхэд шилжсэн 3 хэргийн нэг нь эцэслэн шийдвэрлэгдэж байна.

2.1. ХҮН ХУДАЛДААЛАХ ХЭРГИЙН ДОТООД НӨХЦӨЛ БАЙДАЛ

Улсын хэмжээнд 2017-2021 онд Цагдаагийн байгууллагаас **2017-2021** онд хүн худалдаалах, бэлгийн мөлжлөг, биеэ үнэлэхийг зохион байгуулах **145** хэргийг илрүүлэн шалгаснаас шүүхээр **9** хэрэг эцэслэн шийдвэрлэгдсэн байна. Дотоод дахь хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртүүлж буй ихэнх тохиолдлууд Улаанбаатар хотод бүртгэгджээ. Тодруулбал, 2019-2021 оны хооронд бүртгэгдсэн 65 хэрэгт 131

хохилогч тогтоогдсоны 66%¹ нь Улаанбаатар хотод², Сонгинохайрхан болон Баянзүрх дүүрэгт энэ төрлийн гэмт хэргүүд илүү бүртгэгдсэн. Насанд хүрээгүй хохирогчдын тоо жил тутам нэмэгдэж, орон нутгаас хохирогч болох тохиолдлуудын тоо өсөж байгаа нь анхаарал татсан асуудалд зүй ёсоор орж байна. ЦЕГ-ын ирүүлсэн статистикаас үзвэл Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлд заасан “Биеэ үнэлэхийг зохион байгуулах” гэмт хэрэгт 2020 онд насанд хүрээгүй нэг хүн холбогдсон байна. Харин Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан “Биеэ үнэлэн эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон” зөрчилд 2018 онд 186, 2019 онд 138, 2020 онд 86 хүн буюу сүүлийн 3 жилд насанд хүрээгүй нийт 410 хүн холбогджээ. УИХ-аас 2016 онд баталсан Хүүхдийн эрхийн тухай болон Хүүхэд хамгааллын тухай хууль тогтоомжид хүүхдийн хөдөлмөр эрхлэлттэй холбоотой тусгайлсан зохицуулалт агуулаагүй байна.

ХХГХ-ийн тохиолдол Улаанбаатар хотод өндөр байгаа нь нэг талаас хот, суурин газрын нийгэм, эдийн засгийн хөгжил, хөдөлмөр эрхлэлт, эрэлт, санхүүгийн боломжууд хотод илүү төвлөрч байгаатай холбоотой, хоёрдугаарт уг гэмт хэрэгтэй тэмцэх тогтолцооны чадавх мөн хотод илүү төвлөрч, илрүүлэлт сайн байгаатай холбон тайлбарлагдаж байна. Эрсдэлт хүчин зүйлсийн давхардлыг авч үзвэл Монгол Улсын хэмжээнд Улаанбаатар хотын дараа хилийн бүс нутгууд болох Өмнөговь, Дорноговь аймгууд эрсдэл өндөртөйд тооцогдож байна. Дотоод шилжих хөдөлгөөн нэмэгдэж, ажлын байр, боловсрол, эрүүл мэндийн үйлчилгээ хайсан иргэдийн хот руу чиглэсэн хөдөлгөөн буурахгүй байгаагаас Улаанбаатар хотод оршин суух иргэдийн тоо 2018 онтой харьцуулахад 2020 оны байдлаар 5 хувиар өсжээ. Улирлын чанартай хөдөлмөр эрхлэлтийг хөдөөгөөс хот руу шилжин ирэгсэд, ялангуяа залуучууд бүрдүүлж байна.

Цахим орчны хяналтгүй байдал, интернэтийн зохисгүй хэрэглээ охид, эмэгтэйчүүд бэлгийн мөлжлөг, ХХГХ-ийн хохирогч болоход нөлөөлж байна. Тухайлбал, цахим орчныг ашиглаж биеэ үнэлэхийг зохион байгуулах зорилгоор Facebook групп, инстаграм цахим хуудаснууд олноор нээгдэж энэ төрлийн гэмт хэрэг далд хэлбэрээр үйлдэгдэж байна. Олон нийтийн сүлжээнд тусгайлан нээсэн хуудсуудаар дамжуулан хохирогчдыг элсүүлж, гэмт этгээдүүд гар утас, мөнгө, эд зүйлийг нь дээрэмдэх, тохуурхан даажигнасан дүрс бичлэг хийн, олон нийтийн сүлжээнд байршуулах, ойр дотны хүмүүст нь үзүүлж биеэ үнэлэгч гэдгийг нь илчилнэ гэх зэргээр эмзэг байдлаар нь барьцаалан эрхшээл дарамтад оруулж, хүчээр биеийг нь үнэлүүлэн ХХГХ-ийн хохирогч болгож байна.

Шүүхээр шийдвэрлэгдсэн хүн худалдаалах хэргүүд бүгд хүн худалдаалах хэргийн бэлгийн мөлжлөгийн зорилгоор үйлдэгдсэн бөгөөд бусад зорилгоор хүн

¹ 2019-2021 оны хооронд ЦЕГ-т бүртгэгдсэн 131 хохирогчийн 66% (n=87) нь Улаанбаатар хотод, 6 хэрэг Өмнөговь аймагт, 38 нь хилийн чанадад бүртгэгдсэн байна.

² ОУШХБ, ИРИМ, Монгол Улс дахь хүний наймааны шалтгаан, нөхцөл, хүний наймаанд өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгааны тайлан, УБ, 2022

худалдаалагдсан хэрэг шийдвэрлээгүй байна. Боолчлолын тухай конвенцод (1956) боолчлол, боолчлолтой төсөөтэй ёс заншлыг халах талаар заасан байдаг ба өрийн боолчлол, хамжлагат ёс, зарах чөлөөгүй байдлыг ойлгохоор тодорхойлж, улс орнууд хуулиараа энэ асуудлыг таслан зогсоход анхаарлаа хандуулахаар үүрэг хүлээсэн. Гэвч Хөдөлмөрийн тухай, Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд хүнийг өрийн төлөөс, хамжлага болгох, түүнд хүлээлгэх хариуцлагын талаар тусгагдаагүй байна.

Мөн ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаануудад бэлгийн цөөнх буюу ЛГБТ хүмүүсийн асуудал орхигддог бөгөөд хэдийгээр ЦЕГ-т ХХГХ-ийн ЛГБТ хохирогч бүртгэгдээгүй ч хэлэлцүүлэг³ дурдагдсанаар тэд хөдөлмөрийн мөлжлөг, бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлт бүлгийн нэгд тооцогдож байна.

2.2. ХҮН ХУДАЛДААЛАХ ХЭРГИЙН ГАДААД НӨХЦӨЛ БАЙДАЛ

Хилийн чанадад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсон монгол улсын иргэдийг эх оронд нь аюулгүйгээр авч ирэх үйл ажиллагааг төрийн, төрийн бус, олон улсын байгууллагуудтай хамтран зохион байгуулж байна. Монгол Улсын Засгийн газар, Гадаад харилцааны яам (ГХЯ)-ны мэдээллээр 2018-2020 оны хооронд 61 иргэнийг, цагдаагийн байгууллагын мэдээллээр 42 иргэнийг эх оронд эгүүлэн авчирчээ. Уг тоон мэдээлэл нь тухайн хохирогч аль байгууллагад түрүүлж хандаж, хамтран ажилласнаас хамаарч байна⁴.

Хүснэгтээр үзүүлбэл,

Эх сурвалж	2018	2019	2020
ГХЯ-аас ирүүлсэн мэдээллээр	БНХАУ-28 АНУ-1	Камбож улс-4 Бүгд найрамдах Киргиз улс-1 Филиппин улс-1 БНХАУ-17 Сингапур-4	Малайз улс-5
Эрүүгийн цагдаагийн албанаас ирүүлсэн мэдээллээр	БНХАУ-14 Малайз-2 Мьянмар-3 Камбож-4	Турк-1	Малайз улс-18

Монгол Улс сүүлийн жилүүдэд гадаадад ХХГХ-т өртөж хохирсон иргэдийг эх оронд нь эгүүлэн авчрах асуудалд онцгой анхаарал хандуулж байгаа бөгөөд сүүлийн

³ Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хүрээнд зохион байгуулагдсан “Хүн худалдаалах гэмт хэргийг шийдвэрлэх ажиллагаа: Асуудал, шийдэл хэлэлцүүлэг”-т танилцуулсан ХХГХ-ийн чиг хандлага, түүнтэй тэмцэхэд тулгарч буй асуудал судалгааны үр дүнгийн хэсгээс, 2022., УБ

⁴ Мөн тэнд

гурван жилийн байдлаар Зүүн болон Зүүн өмнөд Азийн орнуудаас хохирогчдыг эх орондоо аюулгүйгээр эгүүлэн авч ирсэн байна. Цар тахлаас үүдэлтэй хилийн хориг, хөл хориотой холбоотойгоор дэлхийн ихэнх улс оронд ХХГХ-ийн гадагшаа чиглэсэн урсгал саармагжиж, эсрэгээр дотоод хөдөлгөөн нэмэгдсэн бол цар тахлын дараа улс орнуудын хилийн хориг суларсантай холбоотойгоор гадагшаа чиглэсэн эрсдэл нэмэгдэх хандлагатай байна. ХХГХ-ийн хохирогчдыг өөр охидыг хуурч мэхлэн, авч ирэх шаардлага тавьж, элсүүлэгч болгож байгаа нь гэмт этгээдүүд баригдахгүй байх, эрүүгийн хариуцлага хүлээхгүй, баригдахгүй байх гол арга болсон нь анхаарал татаж байна. Хилийн чанадад очсоны дараа охид, эмэгтэйчүүдийг өөрсдийн эрхшээлд оруулах зорилгоор гадаад паспортыг нь хураан авч визний хугацааг санаатайгаар хэтрүүлэх, хуурамч штамп дарж өгөх, тодорхой нөхцөлгүйгээр визний хугацаа дуусахын өмнө “багана тойруулах” ХХГХ-ийн хохирогч болгож буй тохиолдлууд нийтлэг байна.

Одоогийн байдлаар гадаадын иргэд Монгол улсад хөдөлмөр болон бэлгийн мөлжлөгт өртөн шүүхээр шийдвэрлэгдсэн тохиолдол гараагүй байна. Гэсэн хэдий ч энэ чиглэлд хийгдсэн олон судалгааны тайланд гадаадын иргэд Монгол Улсад ажиллаж хөдөлмөрлөх явцдаа мөлжлөгт өртөх эрсдэл өндөр байгааг дурджээ. Тодруулбал, гадаад улсын иргэдийг авчирч ажиллуулж байгаа Монгол дахь ажил олгогчид санаатайгаар цалин хөлсийг нь өгөхгүй удааснаар гадаад ажилтнаа хууль бус оршин суугч болгож⁵ гадаад иргэдийн асуудал хариуцсан төрийн захиргааны байгууллага (Гадаадын иргэн харьяатын газар)-д хандан албадан гаргуулах хүсэлтийг гаргаж тухайн иргэний хөдөлмөрийн харилцааг дуусгавар болгох зөрчил гарч байсан. Энэ тохиолдолд гадаадын иргэд хөдөлмөрийн хөлсөө авч чадалгүйгээр Монгол Улсаас албадан гаргуулах буюу хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болох эрсдэлтэй байна. Манай улс цаг агаарын байдлаас шалтгаалан бүтээн байгуулалтын томоохон төслүүд улирлын чанартай байдаг нь гадаадаас ажиллах хүчин авахад ихээхэн нөлөө үзүүлдэг. Ялангуяа барилга, үйлдвэрлэл, газар тариалан, ой мод, загас, ан агнуур, бөөний болон жижиглэнгийн худалдаа, автомашины засвар, уул уурхайн салбарт гэрээгээр ажиллаж буй ажилчид ХХГХ-т өртөх эрсдэл өндөр байгааг олон улсын тайлангуудад дурдаж сануулсан⁶.

Тухайлбал, 2020 оны 09 дүгээр сард Монгол Улсад хөдөлмөр эрхэлж байсан Мьянмар Улсын гурван иргэн хөдөлмөрийн мөлжлөгт өртсөн гэдэг үндэслэлээр хуулийн байгууллагад хандсан бөгөөд тэднийг хамгаалах, туслалцаа үзүүлэх, эх оронд нь аюулгүйгээр буцаах ажиллагааг НҮБ-ын ОУШХБ, Хүйсийн тэгш эрх төв ТББ-ууд хамтран зохион байгуулсан. Гэвч тэдгээр иргэдэд цалин хөлсийг нөхөж

⁵ Гадаад иргэний эрх зүйн байдлын тухай хуулиар визний хугацаа хэтэрснээс хойш 2 сарын хугацаанд албан ёсоор мэдэгдээгүй тохиолдолд албадан гаргах арга хэмжээг авч хэрэгжүүлдэг.

⁶ АНУ-ын Төрийн департамент, 2021 оны Хүн наймаалах асуудлын төлөв байдлын тухай тайлан

олгоогүй бөгөөд нутаг буцсаны дараа хэргийг хэрэгсэхгүй болгож шийдвэрлэсэн байна.

Гадаадын иргэн ажиллуулах ажлын байрны төлбөр хөдөлмөрийн хөлсний доод хэмжээтэй уялдан нэмэгдэж, мөн аж ахуй нэгжүүд цар тахлын дараах эдийн засгийн хямрал, санхүүгийн хүндрэлээс шалтгаалаад гадаадын иргэдийг ажил эрхлэх визээр бус, бизнес болон жуулчлалын визээр гм өөр ангиллын визээр авч ирэн ажиллуулж, эмзэг байдлыг далимдуулах, хохироох, хөдөлмөрийн болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэлтэй тул урьдчилан сэргийлэх, хяналт шалгалтын ажлуудыг өндөр түвшинд зохион байгуулах хэрэгцээ бий болсон.

3. ХУУЛЬ ЭРХ ЗҮЙ, БОДЛОГО

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх эрх зүйн орчин бүрдсэн. Монгол Улс хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын чиглэлээр 12 олон улсын гэрээнд нэгдэж, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байна. Монгол Улс нь 2008 онд Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенцын нэмэлт болох Хүн, ялангуяа эмэгтэйчүүд, хүүхэд худалдаалахаас урьдчилан сэргийлэх, таслан зогсоох, шийтгэх тухай протокол⁷ (цаашид Палермогийн протокол гэх)-д нэгдэн орж, соёрхон баталсан. Үүнээс хойш хүн худалдаалах явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах чиглэлээр нэлээдгүй эрх зүйн актуудыг батлан гаргасан бөгөөд үүний хамгийн тод илрэл нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль⁸ юм.

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх асуудлыг хариуцсан Дэд зөвлөл байгуулагдсан. Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн⁹ 15.3 дахь хэсэгт улсын хэмжээнд тодорхой төрлийн гэмт хэргүүдээс урьдчилан сэргийлэх ажлыг дагнан зохицуулах үүрэг бүхий дэд зөвлөлийг зохицуулах зөвлөлийн дэргэд ажиллуулах тухай заасан. Энэ хүрээнд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах, мэргэжлийн удирдлагаар хангах, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих чиг үүрэг бүхий Дэд зөвлөлийг Монгол Улсад Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах зөвлөлийн дэргэд байгуулсан. Зөвлөлд ХЗДХЯ, ХНХЯ, ЭМЯ, БШУЯ, БОАЖЯ, ГХЯ-ны төрийн нарийн бичгийн дарга нар, ГИХГ, ЦЕГ, ЭЦА, ТЕГ, ХХЕГ, ТББ, ОУБ-ын төлөөллөөс бүрддэг. Энэ бүрэлдэхүүнд **Эс, эд эрхтнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны төлөөллийг**¹⁰ оруулах

Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлөөс жил энэ төрлийн гэмт хэргийн төлөв байдлыг тайланг нэгтгэн гаргаж байх. Хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, эмзэг байршил, урсгал чиглэлийн мэдээллийн жил бүр шинэчлэн боловсруулж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, Дэд зөвлөлд танилцуулан, тодорхой шийдвэр гаргуулан, биелэлт, хэрэгжилтийг хангах ажиллах.

Хүн худалдаалахтай тэмцэх үйл ажиллагааны зарчмыг нарийвчлан боловсруулах шаардлагатай байна. Энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үүрэг хүлээсэн субъектүүд чиг үүргийнхээ талаар нэг мөр ойлголттой, хоорондын үйл

⁷ Нэгдсэн Үндэстний Байгууллага (НҮБ)-ын Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргийн эсрэг конвенц <https://www.unodc.org/unodc/en/organized-crime/intro/UNTOC.html>

⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2012 он, Дугаар 07

⁹ Төрийн мэдээлэл: 2019 он, Дугаар 42

¹⁰ МУ-д ГХУСАЗЗ, Нидерландын Засгийн газар, НҮБ-ын ОУШХБ, IRIM судалгааны хүрээлэн “Монгол Улс дах хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөмтгий болон тэсвэртэй байдлын суурь судалгаа” судалгааны тайлан, 2022 он, хуудас 103

ажиллагааны уялдаа холбоог хангах үүднээс хуулиар тодорхойлсон үйл ажиллагааны зарчмыг нарийвчлах тухайлан **хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг** хуульд тусгах хэрэгцээтэй байна¹¹.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийх хэрэгцээ үүссэн байна. Нэгдүгээрт, Хууль тогтоомжийн тухай хуулийн¹² 51-р зүйлийн 51.3 дах хэсэгт хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хууль тогтоомжийг дагаж мөрдсөнөөс хойш 5 жил тутамд хийж байхыг хуульчилсан¹³. **Хоёрдугаарт,** Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль 2012 онд батлагдсан. Тус хуулийн найман зарчмын хүрээнд үнэлэхэд дотоодын хууль тогтоомж хэрэгжилт хангалттай, хангалттай сайн гэж нийт оролцогчдын 32.6 хувь (118) нь, олон улсын стандарт, гэрээ, конвенцын хэрэгжилт 32 хувь (116) хангалттай, сайн хэрэгждэг гэж үнэлсэн. Харин хохирогчийн нэр төрийг хүндэтгэх асуудал хангалтгүй гэж 72 хувь (260), хохирогчийг үл буруутгах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хувийн нууцыг хамгаалах асуудал хангалттай бус гэж 62.6 хувь (226) нь хариулснаас харахад хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэж дүгнэжээ¹⁴.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч гэсэн тодорхойлолтын агуулга, хийдлийн зөрүүг арилгах шаардлагатай байна. 2012 оны Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч гэдгийг тусгайлан анх удаа хуульчилсан. Энэ нь бусад эрх зүйн баримт бичигт тусгагдсанаас илүү өргөн хүрээнд тодорхойлогдсон. Тус хуульд хохирогчоор тогтоогдсоноос үл хамааран хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандаж үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн нь хохирогчдод ээлтэй зохицуулалт болсон. Гэсэн хэдий ч Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль дахь “хохирогч”-ийн тодорхойлолтыг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн тодорхойлолттой нийцүүлэх¹⁵

¹¹ АНУ-ын Төрийн департамент, Азийн сан, ХТЭТ нар “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх” судалгааны тайлан, 2017 он, хуудас 9-16

¹² Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2015 он, Дугаар 25

¹³ МУ-д ГХУСА33, Азийн сан, Дэлхийн зөн ОУБ, ХТЭТ нар “Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан, 2022 он, хуудас 86

¹⁴ АНУ-ын Төрийн департамент, Азийн сан, ХТЭТ нар “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх” судалгааны тайлан, 2017 он, хуудас 9-16

¹⁵ 2017 оноос хийгдсэн судалгааны бүхий л тайланд ‘хохирогч’ гэсэн нэр томъёог бусад хууль тогтоомжтой нийцүүлэх гэсэн дүгнэлт, санал, зөвлөмжид гарсан байдаг.

Хүснэгтээр харуулбал,

Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017) ¹⁶	Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2013) ¹⁷	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012) ¹⁸
<p>8.1 дүгээр зүйл. Хохирогч</p> <p>1. Гэмт хэргийн улмаас амь нас, эрүүл мэнд, бусад эрх, эрх чөлөө, эд хөрөнгийн болон эд хөрөнгийн бус хохирол хүлээсэн хүн, хуулийн этгээдийг хохирогч гэнэ.</p> <p>2. Шүүх, прокурор, мөрдөгч хохирогчоор тогтоох тухай шийдвэр гаргана.</p>	<p>4 дүгээр зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>4.1.1. “гэрч, хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасан гэрч, хохирогчийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан гэрчийг</p>	<p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёоны тодорхойлолт</p> <p>3.1.2. “хохирогч” гэж Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд заасны дагуу эрүүгийн хэрэг үүсгэсэн, хохирогчоор тогтоосон эсэхээс үл шалтгаан хүн худалдаалахын улмаас эрх, эрх чөлөө, ашиг сонирхол нь зөрчигдсөн хүнийг</p>

Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан ХХГХ-ийн зохицуулалт нь Палермогийн протоколын тодорхойлолттой агуулгын хувьд нийцсэн боловч Эрүүгийн хуулийн хуульд ХХГХ-ийн төрөл хэлбэрүүдийг бие даасан гэмт хэрэг болгон хуульчилсан. Эрүүгийн хуульд ХХГХ-ийн хэлбэр болох бэлгийн мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх, хүний цус, эс, эд эрхтнийг хууль бусаар авах, хүүхдээр гуйлга гуйлгах, хүүхэд худалдах, хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх зэрэг үйлдлийг давхардуулсан зохицуулалт нь мөрдөн шалгах, хэрэг хянан шалгах ажиллагаанд эргэлзээтэй нөхцөл байдлыг үүсгэж, гэмт хэрэг үйлдсэн этгээд ял завших боломжийг бий болгож байна¹⁹.

Хүн худалдаалах онцгойлон хүүхэд худалдаалах гэмт хэргийн эрх зүйн орчинг сайжруулах шаардлагатай байна. Монгол Улс нь олон улсын гэрээ, конвенцод нэгдэн орж, үндэсний хууль тогтоомжийг олон улсын гэрээний хэм хэмжээнд

¹⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2017 он, Дугаар 23

¹⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2013 он, Дугаар 30

¹⁸ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2012 он, Дугаар 07

¹⁹ МУ-д ГХУСА33, Азийн сан, Дэлхийн зөн ОУБ, ХТЭТ нар “Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан, 2022 он, хуудас 82

нийцүүлэх ажил хангалттай хийгдсэн. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогчдод үзүүлэх үйлчилгээг үнэ төлбөргүй байна гэж заасан хэдий ч энэ хэрэгждэггүй. Тус хуулийг даган гаргах “Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам”, “Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам”, “Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох” аргачлалыг өнөөг хүртэл гаргаагүй байна.

Хүүхэд хамгаалал, хүүхдийн эрхийн асуудал нэгдмэл бус байна²⁰. Хүүхдийн эсрэг хүчирхийлэл, хүн худалдаалах гэмт хэрэг, хууль зөрчсөн хүүхдийн асуудал хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагынх, хүүхдийн тэвчишгүй хөдөлмөр, эрсдэлт нөхцөл, эмзэг байдлыг хамгаалах асуудал нийгмийн хамгааллын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэгт хамаардаг. Эдгээр чиг үүргийн хүрээнд хэрэгжүүлж буй ажлыг нэгдсэн удирдлагаар хангах, хэрэгжилтэд хяналт, шинжилгээ, үнэлгээ хийх ажил хангалтгүй байна

Шүүхийн практикт Монгол Улсын нэгдсэн орсон олон улсын гэрээ, конвенцыг хэрэглэж эхэлсэн²¹ байна. Хэдийгээр олон улсын гэрээг хэрэглэж байгаа хэдий ч хэрэгт ач холбогдол бүхий бусад баримт бичгүүд тухайлбал эрүүгийн хэргийн талаар эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг ашиглан хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн, бодитой тогтоох эрх зүйн боломж бүрдсэн байхад түүнийг ашиглан гадаад улсад нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа явуулах байдал хангалтгүй байна.

Улс хооронд байгуулдаг эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг нэмэгдүүлэх шаардлагатай байна. Монгол Улс нь одоогийн байдлаар нийт 17 улстай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа үзүүлэх гэрээ байгуулсан байна. Цаашид Монгол Улсын иргэд ХХГХ-ийн хохирогч болсон Норвеги, Швед, Бельги, Камбож, Герман, Хонгконг, Япон, Малайз, Филиппин, АНУ зэрэг улс оронтой эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах²². Хилийн чанадад хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч илэрсэн тохиолдолд эх орондоо эгүүлэн авчрах ажлыг удирдан зохион байгуулах, салбар дундын уялдааг хангах нь чухал байна. Мөн түүнчлэн гадаад улсад хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт нотлох баримт цуглуулах шаардлагатай байдаг. Тиймээс эрүүгийн хэргийн талаарх эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг бусад улс оронтой байгуулах нэн шаардлагатай байна.

²⁰ Дэлхийн зөн ОУБ, Азийн сан, Ирим судалгааны хүрээлэн “Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт: Хүн худалдаалахаас хүүхдийг хамгаалах нь төслийн суурь судалгаа” судалгааны тайлан, 2021 он, хуудас 75-82

²¹ МУ-д ГХУСА33, Азийн сан, Дэлхийн зөн ОУБ, ХТЭТ нар “Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан, 2022 он, хуудас 84

²² Мөн тэнд, хуудас 86

Биеэ үнэлэхийг зохион байгуулахыг гэмт хэрэгт тооцох болсон. Шинэчлэн найруулсан Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 6.18.4 дэх хэсэгт Биеэ үнэлэн бусадтай бэлгийн харьцаанд орсон, эсхүл бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орсон, 6.18.7 дах хэсэгт өөрийн эзэмшлийн байр, газарт биеэ үнэлэхийг зохион байгуулсан, биеэ үнэлэхэд зуучилсан үйлдлийг тус тус зөрчил гэж хуульчилсан²³. Харин биеэ үнэлэхийг зохион байгуулах, зөрчлийн гаралт, нийгмийн аюулын шинж, байдлыг үндэслэн УИХ-с 2020 оны 01 дүгэр сарын 10-ны өдрийн Зөрчлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулиар 6.18.7 дахь хэсгийг хүчингүй болгож мөн өдөр Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлд Биеэ үнэлэхийг зохион байгуулах гэмт хэргийг хуульчилсан.

Төрийн байгууллага, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэдээлэл солилцох ажиллагааг сайжруулах шаардлагатай байна. Өнөөг хүртэл нэгдсэн мэдээлэл солилцох ажиллагаа дутмаг байгааг судалгааны үр дүнгийн тайлангуудад дурдсан. Тухайлан Гадаадын иргэн харьяатын газар, Цагдаагийн байгууллага, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар, Хөдөлмөрийн асуудал хариуцсан байцаагч зэрэг төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулах, дүн мэдээ, мэдээлэл, судалгаа солилцох, цахим мэдээллийн системтэй холбох, хамтран хянан шалгалт хийх боломжийг бүрдүүлэх нь чухал байна.

Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдын ААНБ, ажлын байранд гэнэтийн хяналт шалгалт хийх эрхийг Хөдөлмөрийн тухай хуулийн²⁴ шинэчилсэн найруулгын 162.2.1 дэх заалттай уялдуулан Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох журамд тусгах.

Боолчлолын шинжтэй нөхцөлүүд хүүхдийн хөдөлмөрийн харилцаанд тулгарч байна. Хүүхдийг хэт олон цагаар эсвэл олон өдрөөр ажиллах, ажлын байранд хийх ажил болон гүйцэтгэх нөхцөл тодорхойгүй байх, цалингүй эсвэл бага цалинтай ажиллах, цалингаа үндэслэлгүй хасуулах, цалин хөлсөө эцэг, эх, асран хамгаалагч болон зуучлагч зэрэг бусад этгээдэд суутгуулах эсвэл шууд өгөх, нийгмийн хамгаалалд хамрагдах боломжгүй байх, боловсролын үйлчилгээнд хамрагдахгүй, нийгмийн амьдралаас тусгаарлагдсан нөхцөлд ажил хөдөлмөр эрхлэх зэрэг боолчлолын шинжтэй нөхцөлүүд хүүхдийн хөдөлмөрийн харилцаанд тулгарах нь элбэг байна.

Хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг батлах. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заагдсан хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг боловсруулан батлуулах. Одоогийн мөрдөж буй Эрүүгийн хуульд хохирогчид учирсан хохирлыг дан ганц **бие махбодод учирсан гэмтлийг зэргээр биш** хөнгөн, хүндэвтэр, хүнд хохирол гэж тодорхойлон

²³ МУ-д ГХУСА33, Азийн сан, Дэлхийн зөн ОУБ, ХТЭТ нар “Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан, 2022 он, хуудас 83

²⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2021 он, Дугаар 31

зааж өгсөн. Энэ нь тодорхойлсон сэтгэл зүйн гэмтэл (учирсан хохирол)-ийн сэргээгдэх хугацаа, хохирогчийн нас зэргээс хамаарсан байдлаар нь биед нь хөнгөн, хүндэвтэр, хүн хохирол учирсан болохыг тогтоосон аргачлалыг бий болгох.

4. ХОХИРОГЧ ХАМГААЛАЛТ

ХХГХ-ийн “хохилогч” гэх тодорхойлолтыг 2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулиар анх хуульчилсан. Уг тодорхойлолт нь бусад эрүүгийн холбогдох хуулиуд дахь хохирогчийн тодорхойлолтоос илүү өргөн хүрээнд хохирогчийг авч үзсэнээрээ хохирогчид илүү ээлтэй заалт болсон гэж үздэг. Тодруулбал, Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд цагдаа, шүүхийн байгууллагаар хохирогчоор тогтоогдсон эсэхээс үл хамааран ХХГХ-ийн хохирогч нь үйлчилгээ үзүүлэгч байгууллагад хандан тусламж, үйлчилгээ авах боломжийг бүрдүүлсэн. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд зааснаар хохирогчид таван төрлийн нөхөн сэргээх үйлчилгээг үнэ төлбөргүй үзүүлэхээр заасан. Үүнд хохирогчдод нэн тэргүүнд шаардлагатай тусламж дэмжлэг болох хамгаалах байр, хоол, хүнс, эрүүл мэндийн яаралтай тусламж үйлчилгээ зэрэг анхан шатны үйлчилгээ багтсан бөгөөд тусгайлсан журмуудаар зохицуулахаар болсон.

Хүн худалдаалахтай тэмцэх эрх зүйн орчин тодорхой болсон ч нэгдсэн аргачлал, удирдамжгүй байна. Төрийн болон ТББ-ын аль алинд нь хохирогчийг илрүүлэх, тогтоох, тодорхойлох нэгдсэн аргачлал, удирдамж байхгүй, байгууллага тус бүр өөр өөр бичиг баримтын хүрээнд хохирогчоо тогтоож байна. Иймд үндэсний хэмжээнд ХХГХ-ийн хохирогчийг таньж мэдэх, илрүүлэх, тогтоох нэгдсэн, хүлээн зөвшөөрөгдсөн удирдамжийг боловсруулах, батлуулах хэрэгцээ бий болсон байна.

Хохирогчдод үйлчилгээ үзүүлэх эрх зүйн орчин бий болсон байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчдод үзүүлэх таван төрлийн үйлчилгээг²⁵ (Эрүүл мэндийн нөхөн сэргээх эмчилгээ, сэтгэцийн нөхөн сэргээх эмчилгээ, ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах, хууль зүйн туслалцаа үзүүлэх, гадаад улсад МУ-ыг төлөөлөн суугаа дипломат төлөөлөгчийн болон консулын газраас хохирогчийг түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан

²⁵ Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйл буюу Хохирогчид үзүүлэх халамж, үйлчилгээ

авчрах) хуульчилж, төрөөс бүрэн санхүүжүүлэхээр тусгасан бөгөөд хохирогчдод үйлчилгээ үзүүлэх найман журмаас тав нь батлагдсан байна. Журмуудаас гадна ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх нийгмийн үйлчилгээ үзүүлэх стандартыг баталж, ТББ-ууд мөрдөж ажиллахаар зохицуулсан нь хүний эрх, хохирогч төвтэй хандлагыг бүх түвшинд төлөвшүүлж ажиллахад дөхөм болсон байна.

ХХГХ-ийн хохирогчид үзүүлэх үйлчилгээг тодорхойлсон боловч хэн хэрхэн, ямар санхүүжилтээр үзүүлэх талаарх нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчдод үзүүлэх таван төрлийн үйлчилгээг хуульчилж, төрөөс бүрэн санхүүжүүлэхээр тусгасан бөгөөд үйлчилгээ үзүүлэх найман журмаас тав нь батлагдсан байна.

Хүснэгтээр харуулбал,

Д/Д	Нэр	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	Батлагдсан он, сар, өдөр	Агуулга
1	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлэх	5-р зүйл: 5.3.2. 12-р зүйл: 12.1.5. 12.2. Дахь заалт	Гадаад харилцааны сайдын тушаал 2013.11.15 Дугаар А/91	Хилийн чанадад хүн худалдаалах болон бусад төрлийн хүнд, онц хүнд гэмт хэргийн хохирогч болсон Монгол Улсын иргэний аюулгүй байдлыг хангах, эрх ашгийг хамгаалах, эх оронд нь буцаах хүртэлх хугацаанд Дипломат төлөөлөгчийн газраас түр хугацаагаар орон байр, хоол хүнсээр хангах, гадаад паспорт, түүнтэй адилтгах баримт бичиг олгох, эх оронд нь буцаан авчрах зэрэг хуульд заасан бусад үйлчилгээг үзүүлэхээр зохицуулсан.
2	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид сэтгэцийн	5-р зүйл: 5.5.1. 5.5.2. 12-р зүйл: 12.1.1. 12.1.2. 12.2. Дахь заалт	Эрүүл мэндийн сайдын тушаал	ХХГХ-ийн хохирогч болсон, сэтгэлзүйн цочмог болон архаг хариу урвалууд илэрсэн, сэтгэц, зан үйлийн эмгэг, сэтгэл түгших, нойрны, биеийн хэлбэрийн, сэтгэл гутрах ба

	нөхөн сэргээх тусламж, үйлчилгээ үзүүлэх		2013.12.09 Дугаар А\462	сэтгэл хөөрөх эмгэг, гэмтлийн дараах стрессийн эмгэг, дасан зохицохуйн эмгэг, хувирах болон хуваагдах эмгэг, солиорох эмгэгт өртсөн өвчтөнүүдэд сэтгэцийн эрүүл мэндийн нөхөн сэргээх тусламж үйлчилгээг хэрхэн үзүүлэхийг зохицуулсан.
3	Хохирогчийг ажлын байраар хангах, мэргэжлийн сургалтад хамруулах үйлчилгээ үзүүлэх	12-р зүйл: 12.1.3. 12.2. Дахь заалт	Хөдөлмөрийн сайдын тушаал 2015.07.09 Дугаар А/135	Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хуульд заасны дагуу хамгаалалтад байгаа ХХГХ-ийн хохирогчийг, онцгой тохиолдолд хохирогчийн хамт амьдардаг гэр бүлийн гишүүдийг мэргэжлийн сургалтад хамруулах, эсхүл ажлын байраар хангах ажлыг Тахарын албатай хамтран зохион байгуулахаар журамласан.
4	Урамшуулал олгох журам	16-р зүйл: 16.3.4. 16.5. Дахь заалт	Хууль зүйн сайдын 2016.01.11 А/08	ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр идэвхтэй, үр дүнтэй ажиллаж байгаа байгууллага, хувь хүнийг урамшуулах талаар зохицуулсан.
5	Хүүхдийг Монгол улсын хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих журам	5-р зүйл: 5.8. 5.8.1. 5.8.2. 5.8.3. Дахь заалт	Хууль зүйн сайдын 2017.03.03 А/49 (2020 оны А/96 тушаалаар өөрчлөн найруулсан)	Монгол Улсын иргэн 18 нас хүртэлх хүүхдийг хилээр нэвтрүүлэхэд хяналт тавих үйл ажиллагаатай холбогдсон харилцаа, итгэмжлэлийн үндсэн дээр бусдын хүүхдийг харгалзан гадаадад зорчиж буй иргэний холбогдох мэдээллийг нягтлан шалгах асуудлыг зохицуулсан. 2020 онд журамд нэмэлт өөрчлөлт оруулан

				найруулж, холбогдох маягтуудыг баталсан.
--	--	--	--	--

Эдгээр үйлчилгээг үзүүлэхтэй холбоотой санхүүжилтийн эх үүсвэр болон хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих хуульд нарийвчлан заагаагүйгээс хэрэгжилтийг үнэлэх боломжгүй байна. Мөн ХХГХ-ийн хохирогчдод үзүүлэх нийгмийн үйлчилгээ үзүүлэх стандартыг баталж, ТББ-ууд мөрдөж ажиллахаар зохицуулсан нь хүний эрх, хохирогч төвтэй хандлагыг бүх түвшинд төлөвшүүлж ажиллахад дөхөм болсон байна.

Хүснэгтээр харуулбал,

Стандартын нэр, дугаар	Зорилго	Агуулга
2009 онд Стандартчилал, хэмжил зүйн газраас “Хохирогчийг хамгаалах байрны үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS6040:2009) баталсан. Энэ стандартыг 2019 онд “Гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилттэй холбоотойгоор нэмэлт өөрчлөлт оруулан шинэчлэн баталсан (MNS 6040:2019) шинэчилсэн стандартыг дагаж мөрдөж байна.	Стандартын зорилго нь Монгол Улсын нутаг дэвсгэр дээр хохирогчийг хамгаалах байр ажиллуулах, тэдэнд үзүүлэх үйлчилгээний жишиг тогтоох зорилготой.	Шинэчлэгдэн батлагдсан хамгаалах байрны стандартад ХХГ-ийн хохирогчийг хамгаалах асуудал тусгагдаагүй. Үйлчлэх хүрээ нь
2013 онд Стандартчилал, хэмжил зүйн газраас	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх олон нийтэд түшиглэсэн	Стандартыг хэрэгжүүлэгч нь ТББ-ууд бөгөөд хохирогч хамгааллын

<p>“Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага” (MNS 6418:2013)</p>	<p>халамжийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага, уг үйлчилгээний орчныг тодорхойлох, улмаар үйлчилгээний чанарыг дээшлүүлэх явдал юм.</p>	<p>үйлчилгээний тодорхойлолт тусгагдаагүй. ХХГХ-ийн хохирогчийг тогтоох маягт, хохирогчид үзүүлэх үйлчилгээний төрөл, хэлбэр, үйлчилгээний үе шатуудад тавигдах шаардлагыг тогтоож өгсөн. Мөн хэн хяналт тавих нь тодорхойгүйгээс хэрэгжилт хангалттай биш байна.</p>
--	--	---

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн ажлын нийтлэг стандартыг шинэчлэн сайжруулах шаардлага бий болжээ. 2013 онд батлагдсан стандарт нь хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх үйлчилгээний орчин,чанарыг тогтоосон хэдий ч стандартыг хамрах хүрээ нь зөвхөн төрийн бус үйлчилгээ үзүүлэгч байгууллагад үйлчлэх хязгаарлагдмал хүрээнд зохицуулагджээ. Тиймээс стандартын хамрах хүрээг өргөтгөх, мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг хамгаалах, түүнд үзүүлэх үйлчилгээг олон улсын жишигт нийцүүлэн стандартыг сайжруулах хэрэгцээ үүссэн байна.

ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа, үйлчилгээ үзүүлэх зарим журмууд батлагдаагүй байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль батлагдаад 10 гаруй жил болж байгаа ч хуулийг дагаж гарах журмууд бүрэн батлагдаагүй байгаа нь хохирогч хуульд заасан үйлчилгээгээ төрөөс бүрэн, үнэ төлбөргүй авахад сөргөөр нөлөөлж байна.

Хүснэгтээр харуулбал,

Д/Д	Нэр	Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль	Батлагдсан он, сар, өдөр	Хариуцах байгууллага
-----	-----	---------------------------------------	--------------------------	----------------------

1	Хамгаалах байрны журам	9-р зүйл: 9.4. дахь заалт	Батлагдаагүй	Хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, ажиллах журмыг Засгийн газар батална.
2	Хууль зүйн туслалцаа үзүүлэх журам	12-р зүйл: 12.1.4. 12.2. дахь заалт	Батлагдаагүй	Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.
3	Хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хангах журам	5-р зүйл: 5.2.3. дахь заалт	Батлагдаагүй	Улсын ерөнхий прокурортой хамтран Хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батална.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод үзүүлэх үйлчилгээний тогтолцоо бүрдээгүй байна. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гарах ёстой хохирогчдод үзүүлэх үйлчилгээний журмууд бүрэн гараагүй байхын зэрэгцээ батлагдсан журмууд нь салангид, хоорондоо уялдаа холбоогүй, хэрэгжилт туйлын сул байна. Хохирогчид төрөөс хуульд тусгагдсан үйлчилгээг өнөөг хүртэл бүрэн авч чадахгүй зөвхөн ТББ-аас үзүүлж буй үйлчилгээнд хамрагдаж байна. Өөрөөр хэлбэл төрийн байгууллагуудад хохирогчид руу чиглэсэн нийгмийн ажил үйлчилгээ болон нөхөн сэргээх, эргэн нийгэмшүүлэх цогц үйлчилгээг бий болж чадаагүй байна.

Хохирогч хуулийн байгууллагад өөрөө шууд хандах талаар нөлөөллийн ажил хэрэгтэй байна. Хохирогчийг олон арга замаар илрүүлж, туслалцаа үзүүлж байгаа ч хохирогч өөрөө цагдаа, хуулийн байгууллагад хандаж туслалцаа авахдаа асуудалд болгоомжтой хандаж байна. Гэмт хэрэгтнүүд “цагдаа найзтай, танилтай, эсвэл цагдаад хэлж баривчлуулна, хориулна, торгуулна” гэх мэт сэтгэл зүйн дайралт, заналхийллийн арга хэрэглэдгээс цагдаагаас айх, болгоомжлох явдал байсаар байна.

Эрсдэлд өртсөн хохирогчид шуурхай тусламж, үйлчилгээ авах боломж бүрдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. ХХГХ-т өртөх эрсдэлтэй тулгарсан хохирогч хаана, хэнд хандаж үйлчилгээ авах талаарх мэдээлэл дутмаг. ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх талаарх мэдээлэл, сурталчилгааг мэдээллийн хэрэгслээр дамжуулан (цахим болон нийгмийн сүлжээ, зөвлөгөө өгөх утас, телевиз, радио, тараах материал гэх мэт) түгээж байгаа ч тогтмол биш байгаа нь хангалттай үр дүн үзүүлэхгүй байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлсэн туслалцаа, үйлчилгээний талаар нэгдсэн мэдээлэл, судалгаа байхгүй байна. Өнөөг хүртэл төрийн болон ТББ-ын зүгээс хохирогчдод үзүүлсэн туслалцааны талаарх тоо мэдээ зөрүүтэй байгаа бөгөөд ТББ-ууд илүү олон үйлчлүүлэгчдэд үйлчилгээ, туслалцаа үзүүлсэн байна.

Хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тогтворжуулж хамгаалах үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг нь түүнд шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй, ойлгомжтой, тодорхой хэлбэрээр өгөх явдал юм. Гэвч хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчид мэдээлэл өгөхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй. Иймд шинээр боловсруулах журамд хохирогчид өгөх мэдээллийн жагсаалтыг тусгаж болох юм. Үүнд:

- ▣ Төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлдэг тусламж, үйлчилгээ
- ▣ Эрүүгийн болон захиргааны шинжтэй процессын үе шат, үйл явц
- ▣ Хууль зүйн үнэ төлбөргүй эсхүл бага хэмжээтэй туслалцаа авах боломж
- ▣ Хохирогчийг болон гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга
- ▣ Хувийн нууцлалаа хангуулах эрх
- ▣ Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдээлэл авах эрх - Хохирол нөхөн төлүүлэх асуудал

Хохирогчийг таньж тогтоох ажиллагааны нэгдсэн аргачлал гаргах шаардлагатай байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг аль болох эрт таньж тогтоох нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээний урьдач нөхцөл болдог. Гэвч хохирогчийг таньж тогтоох нэгдсэн аргачлалгүй, хууль сахиулах тусгайлсан чиг үүргийн байгууллагаас өөр салбарын ажилтан, албан хаагчид хохирогчтой тааралдсан ч таньж мэдэх, тогтоох мэдлэг, мэдээлэлгүй байгаа юм. Иймд боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах байгууллагын зэрэг алба хаагчдын гүйцэтгэх үүргийг тусгасан нэгдсэн аргачлал гаргах шаардлагатай байна.

Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд заасан хохирогчийн тодорхойлолтыг нэг мөр хэрэглэх шаардлагатай байна. Эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх ажиллагаа нь тодорхой цаг хугацаа, баримт нотолгоо шаарддаг бөгөөд энэ хооронд хохирогч хамгааллын үйл ажиллагаа алдагдах, хохирогч дахин аюултай байдалд орох эрсдэлтэй тул “хохирогч байж болзошгүй” гэж таньж тогтоон хамгаалалтын арга хэмжээг авах шаардлагатай байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээ хэрэгцээтэй байна. Хохирогчдод үзүүлж байгаа үйлчилгээ нь дийлэнх тохиолдолд анхан шатны хэрэгцээнд суурилсан үйлчилгээгээр хязгаарлагдаж буй бөгөөд энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хохирогчийг эргэн хэвийн амьдралд нь ороход удаан хугацааны, тогтвортой үйлчилгээ хэрэгтэй юм. Нөгөө талаас нэг

үйлчлүүлэгчид ногдох үйлчилгээний зардал өндөр учир нэг хүнийг удаан хугацаанд үйлчилгээнд хамруулахад ТББ-дад хүндрэлтэй байдаг.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид зөвхөн Улаанбаатар хотод үйл ажиллагаа явуулж буй байгууллагын үйлчилгээнд хамрагдаж байна. Хохирогч амьдарч буй орон нутагтаа шууд туслалцаа, урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээнд хамрагдах нөхцөл, боломж хязгаарлагдмал. Өөрөөр хэлбэл орон нутагт энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн байгууллага одоогоор байхгүй.

Хохирогчийн хэрэгцээнд суурилсан үйлчилгээг үзүүлэх боломж хязгаарлагдмал байна. Хохирогчид төрийн болон ТББ-ын туслалцаанд хамрагдаж эхэлсэн цагаасаа эхлэн анхан шатны хэрэгцээгээ хангах бэлэн мөнгөний дэмжлэг, туслалцаа хүсдэг боловч энэ нь бүрэн хангагдах боломжгүй байна. ТББ-ууд хүний анхан шатны хэрэгцээг хангахад тусалдаг ч тогтмол, удаан хугацаанд үзүүлэх боломжгүй байдаг.

Хохирогчийн хувийн мэдээллийн нууцлалыг ханган ажиллахад анхаарах шаардлагатай байна. Үйлчилгээ үзүүлэх явцдаа төрийн болон ТББ-ууд хувь хүний нууцыг хамгаалж, хохирогч, түүний гэр бүлийг дахин эрсдэлд өртөхгүй байх баталгааг хангах шаардлагатай байна. Төрийн болон ТББ-ууд холбон зуучлах, бусад үйлчилгээ үзүүлэх явцдаа хохирогчийн хувийн нууцыг хадгалж хамгаалах талаар гэрээ байгуулах зэрэг ажил хангалттай түвшинд хийгдэхгүй байна.

Хохирогчид үзүүлэх үйлчилгээний дийлэнх нь ОУБ-ын санхүүгийн дэмжлэгээр явагдаж байна. Өнөөдрийн байдлаар үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын дийлэнх нь ОУБ-ын дэмжлэгтэйгээр ХХГХ-ийн хохирогчдод хууль зүйн зөвлөгөө, өмгөөллийн туслалцаа үзүүлж байгаа хэдий ч энэ тогтвортой үргэлжлэх нөхцөл хангагдахгүй байгаагаас үзвэл журмуудад үйлчилгээний зардлыг хэрхэн олгох талаар оруулж өгөх нь зүйтэй байна.

Үйлчилгээний чанар хүртээмжийг дээшлүүлэхийн тулд үйлчилгээний стандартын хэрэгжилтэд хяналт тавих, үйлчилгээ үзүүлэгч мэргэшсэн байгууллагын тогтвортой байдлыг хангаж өгөх шаардлагатай байна. Хохирогчид үзүүлэх үйлчилгээний тогтолцоог сайжруулах, хохирогч хамгааллын суурь үйлчилгээний стандартыг бий болгох, үйлчилгээний чанар, хүртээмжийг үнэлэх, улмаар хохирогч хамгааллын анхан болон нөхөн сэргээх үйлчилгээний тогтвортой санхүүжилтийг шийдвэрлэх, нийгмийн бүх бүлгүүд, ялангуяа тусламж үйлчилгээ авах боломж нөхцөл нь хангагдаагүй эрэгтэй хохирогчдын хэрэгцээг харгалзах замаар үйлчилгээний тогтвортой байдлыг хангах зохицуулалт нэн тэргүүнд шаардагдаж байна.

Эрсдэл өндөртэй гэрч, хохирогчийн аюулгүй байдлыг хамгаалах тусгайлсан байр байхгүй. Гэрч, хохирогчийг хамгаалах тухай хууль, Аюулгүй байдлыг хангах

журмаар эрсдэлийн гурван түвшинг тогтоож, эрсдэлийн түвшин өндөр гэрч, хохирогчийг төрөөс тусгай хамгаалах байраар хангах үүрэг хүлээсэн боловч хэрэгжээгүй. Эрсдэлийн өндөр түвшинд байгаа гэрч, хохирогчийг байрлуулах тусгай хамгаалах байр байхгүй учир эрсдэлийн түвшингээр үнэлж, хамгаалан байрлуулах боломжгүй ТББ-ын хамгаалах байруудад байрлуулж байгаа нь хохирогчдод болон тухайн байгууллагад учрах эрсдэлийг нэмэгдүүлэх боломжтой тул яаралтай анхаарал хандуулах шаардлага бий болжээ.

Хамгаалалтын арга хэмжээ авах журам. Юуны өмнө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж, хохирогчоор албан ёсоор тогтоосон эсэхээс үл хамаарч хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирсон байж болзошгүй гэж үзсэн бол шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй авах талаар журамд тусгах хэрэгтэй.

Аливаа арга хэмжээг заавал хохирогчийн өгсөн зөвшөөрлийн дагуу явуулах талаар журамд тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Учир нь хамгаалалтын ажиллагаа өөрөө албадлагын арга хэмжээ биш тул сайн дурын оролцоонд тулгуурлах хэрэгтэй. Мөн хохирогчийн аюулгүй байдалд үүсэж болох эрсдэлийг тогтмол үнэлэх үүргийг тухайн хэргийг шалгаж буй мөрдөгч, прокурорт өгөх шаардлагатай. Ингэснээр хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цаг алдалгүй авах, хохирогчийн бодит нөхцөл байдлын талаар мөрдөгч, прокурор мэдээлэлтэй болох ач холбогдолтой. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ өөрөө зардал өндөртэй. Харин Тайванд аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд гарсан зардлыг буруутай этгээдээр төлүүлдэг механизм байгаа бөгөөд үүнийг судалж нэвтрүүлэх боломжтой.

Насанд хүрээгүй хохирогчдод онцгойлон анхаарал хандуулан, дагнасан үйлчилгээ үзүүлэх шаардлагатай байна. Хохирогч хүүхэд нь насанд хүрсэн хохирогчтой харьцуулахад бие махбод, сэтгэлзүйн хувьд бүрэн хөгжөөгүй, шийдвэр гаргах чадваргүй, насанд хүрэгчдээс хараат зэргээс шалтгаалан түүнд үзүүлэх үйлчилгээ нь ялгаатай гэдгийн хүлээн зөвшөөрч ажиллах, тусгайлан үйлчилгээг үзүүлэх шаардлагатай байна. Хохирогч эргэн хэвийн амьдралдаа ортол нэгээс гурван жилийн хугацаа шаардлагатай ба ар гэрийн нөхцөл байдлаас шалтгаалан хэвийн амьдралдаа орох хугацаа харилцан адилгүй. Олонх хохирогч бүх шатны шүүхээр хэрэг эцэслэн шийдвэрлэгдэх хүртэл гэмт хэрэгтнүүдтэй огт харьцахгүй байх боломжтой тусгай байранд байрлуулж, нууцлалыг хангаж өгөхийг хүсдэг ч хэрэгжих боломжгүй байна.

Хохирогч хамгааллын арга хэмжээ дотор насанд хүрээгүй хохирогчийн онцлогт тохирсон арга хэмжээ чухал ач холбогдолтой байна. Эдгээрт аюулгүй байдлыг нэн даруй хангах, гэмт хэрэг үйлдэгчээс тусгаарлах (гэр бүлийн гишүүн нь уг гэмт хэрэгт оролцсон бол мөн адил тусгаарлах), нас, бие хөгжлийн онцлогт тохирсон хамгаалах байранд байрлуулах, мэдүүлгийг мэргэшсэн, адил хүйсийн

ажилтнаар, аль болох тайван орчинд авхуулах, нас, гэр бүл зэрэг нөхцөл байдлыг нь харгалзан үзэх, өөрөө сайн дураар ярих боломжийг бүрдүүлэх, аль болох цөөн удаа мэдүүлэг авах, хамгийн итгэлтэй гэсэн хүнийг байлцуулах зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй байна. Түүнчлэн хохирогчийг насанд хүрсэн эсэхийг шууд тодорхойлох боломжгүй байгаа бол насанд хүрээгүй хүнтэй адилтган авч үзэх, албан ёсоор нас тодорхойлох хүртэл хамгаалалтын арга хэмжээ авах хэрэгтэй талаар олон улсын баримт бичгүүдэд зөвлөмж болгосныг журамд тусгах нь зүйтэй.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч, хохирогч хүүхдэд үзүүлж буй үйлчилгээний өнөөгийн нөхцөл байдал нь хүүхдэд ээлтэй бус байна. ХХГХ-ийн улмаас бэлгийн мөлжлөг, ХХГХ-т өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээ, хохирогч хамгааллын тогтолцоо хангалтгүй байна. Хүүхэд хамгааллын тогтолцооны хүрээнд хүүхэд хамгааллын үйлчилгээ хэрэгжиж байгаа хэдий ч энэ төрлийн гэмт хэрэгт өртсөн хүүхэд хамгаалал, үйлчилгээ байхгүйн зэрэгцээ түүнд үйлчилгээ үзүүлж буй мэргэжилтнүүд мэргэжлийн бус байна. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхдийг эрүүл мэндийн байгууллагад хандуулах тохиолдолд нарийн мэргэжлийн үйлчилгээ хэрэгцээтэй тул тэдгээр нь бүгд үнэ төлбөртэй байдаг байна. Тухайлбал, дотуур үзлэг, оношилгоо, сэтгэл зүйн заслын үйлчилгээ гэх мэт.

Хохирогч хүүхдийн хамгаалах байрыг онцлог байдлаас шалтгаалан удаан хугацааны болон төрөлжсөн хэлбэрээр зохион байгуулах шаардлагатай байна. Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдэд шаардлагатай, дэмжлэг тусалцаанд үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын төлөөлөл тусгай бие даасан хүүхдийн төрөлжсөн хамгаалах байрыг санал болгохын зэрэгцээ урт хугацааны нөхөн сэргээх үйлчилгээг хөгжүүлэх хэрэгцээ үүссэн байна. Бэлгийн хүчирхийлэл, мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхэдтэй ажиллахад урт хугацаа буюу гурваас дээш жил шаардлагатай байдаг. Урт хугацааны үйлчилгээ үзүүлж байгаа байгууллага байхгүйтэй адил байна.

Хохирогчийг хамгаалах талаарх хууль тогтоомж иргэд олон нийт, хуульчдын хувьд нэг мөр болоогүй, мэдээлэл ил тод биш байгаа нь байгууллага хоорондын хамтын ажиллагаанд сөргөөр нөлөөлж байна. Хүн худалдаалахтай тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хамгааллын чухал хэсэг нь хууль сахиулах болон бусад байгууллага, албан хаагчдын хандлага, арга барилтай холбоотой асуудал тул энэ чиглэлээр аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ хохирогчийн эрх, нэр төрийг хүндэтгэн үзэх ёстой.

Хохирогч төвтэй, жендэрийн мэдрэмжтэй, хохирогчид учирсан сэтгэцийн гэмтэл, эмгэг зэргийг харгалзан үзсэн хандлагыг үйл ажиллагааны үндэс суурь болгох хэрэгтэй байна. Эдгээр хандлагыг алба хаагчдын түвшинд нэг мөр ойлгох, сургалтад заавал хамруулах, хэрэгжүүлэх, хэрэгжилтэд хэрхэн хяналт тавих

зэрэг асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Ерөнхий прокурорын газраас хамтран батлах журамд тусгах боломжтой.

Хохирогчид хохирол нөхөн төлөгдөхгүй байна. ХХГХ болон түүнтэй төстэй хэргийн хохирогчид өөрт учирсан хохирлоо тодорхойлох, түүнтэй холбоотой баримтыг хэрхэн гаргах, ямар байдлаар нөхөн төлүүлж болох талаар мэдлэг, ойлголтуугийн улмаас хохирлоо нэхэмжилж чадахгүй байна.

Үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж буй мэргэжилтнүүдийг тогтвортойгоор сургах, чадавхжуулах хэрэгцээтэй байна. Үйлчилгээ үзүүлж буй төрийн болон ТББ-ын мэргэжилтнүүдийг хохирогч төвтэй хандлага, аргачлалд тогтмол сургах, мэргэшүүлэх ажлыг хамтран тогтвортойгоор хэрэгжүүлэх чухал. Мэдээллийн хүртээмж, үйл ажиллагаандаа нэвтрүүлэн хэрэглэж буй байдлаасаа шалтгаалан үйлчилгээ үзүүлэгчид харилцан адилгүй түвшинд ажиллаж байна. Төрийн болон ТББ-д мэргэшсэн ажилтнуудыг тогтвортойгоор ажиллуулах бодлогын шийдэл үгүйлэгдэж байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таньж тогтоох, илрүүлэх ажиллагаанд үйлчилгээ үзүүлж буй байгууллагын хүний нөөц бэлтгэгдээгүй байна. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудтай уулзахад дийлэнх нь бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх, таньж тогтооход хүндрэлтэй байдаг ба хохирогчийг илрүүлэх чиглэлээр тусгайлсан сургалтад хамрагдаж байгаагүй байна. Улсын хэмжээнд үйл ажиллагаа явуулж буй 34 нэг цэгийн үйлчилгээний төв, түр хамгаалах байр нь журмын дагуу гэр бүлийн болон бэлгийн хүчирхийллийн хохирогчийг хүлээн авдаг. Гэвч эдгээр хохирогчоос ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх, таньж тогтоох хэрэгцээ бий болсон тул арга зүйн сургалтад хамруулах шаардлагатай байлаа.

Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ажиллах хүний нөөцийг нэмэгдүүлэх, тэднийг чадавхжуулах хэрэгцээ үүссэн байна. Үйлчилгээ үзүүлж буй байгууллагын ажилтнууд мэргэжлийн бус, нийгмийн ажилтан, сэтгэл зүйчгүй байгууллага байсаар байна. Орон нутагт ажиллаж буй үйлчилгээ үзүүлэгч байгууллагын ажилтнууд мэргэжлийн бус учраас хүүхэд хамгаалал тэр дундаа үйлчилгээний асуудал орхигдох, мэргэжлийн бус үйлчилгээ үзүүлэх, үйлчилгээний чанарт тавих хяналтгүй байна. Үйлчилгээ үзүүлэгч ТББ-аас төрийн байгууллага руу шилжүүлсэн кейсийн шийдвэрлэлт, эргэх холбоо байдаггүй тул үүнийг шийдвэрлэх шаардлагатай байна.

Төрөөс хохирогчийн үйлчилгээнд зориулан олгох тогтмол төсөв, санхүүжилт хангалтгүй байна. Сүүлийн гурван жилд Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх Дэд зөвлөлөөс хохирогчид шууд туслалцаа үзүүлэх үйл ажиллагаанд тодорхой санхүүжилтийг хуваарилж буй боловч бизнесийн байгууллагуудын нэгэн адил шалгуураар тендерээр авах болдог нь ТББ-д хүндрэлтэй байна. Хохирогчдод

үзүүлж буй үйлчилгээ нь өнөөг хүртэл олон улсын санхүүжүүлэгч байгууллагын тусламж, дэмжлэгээр хэрэгжиж байна. Тиймээс хохирогчдод зориулсан үйлчилгээний зардлыг хүндрэл, чирэгдэлгүй зохих мэргэшсэн үйлчилгээ үзүүлдэг байгууллагуудад зүй зохистойгоор олгож, хяналт үнэлгээ хийж явах шаардлагатай.

Төрөөс Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн²⁶ дагуу авч буй санхүүжилтэд зайлшгүй байх ёстой зардлууд тусгагдаж чадахгүй байна. Хохирогчид туслалцаа үзүүлэх ажлын гол бүрэлдэхүүн хэсэг болох үйлчилгээ үзүүлэх ажилтнуудын цалин, байрны түрээс, байгууллагын урсгал зардал зэрэгт мөнгө хуваарилдаггүй нь ТББ-ууд үйлчилгээний чиглэлээр ажиллах идэвх сонирхлыг бууруулж байна. Цаашид төрөөс хохирогч хамгаалал, ялангуяа үйлчилгээнд батлагдсан журам, стандартын хэрэгжилтийг бодитоор хангах тусгайлсан төсөв хуваарилах, батлуулах хэрэгцээ бий болсон байна.

Хүүхэд нь эрх зүйн этгээд мөн боловч хөдөлмөрийн харилцаанд оролцохдоо эрх зүйн бүрэн чадамжгүй буюу бие даан гэрээ, хэлцэл байгуулах эрхгүй учир ихэвчлэн албан ёсны гэрээ, хэлцэлгүйгээр ажилд орж, хөдөлмөрийн харилцаанд эрхээ хамгаалж чадахгүй болдог нөхцөл байдал нийтлэг байна. Ялангуяа өмнө нь ажил, хөдөлмөр эрхэлж байсан туршлагагүйн улмаас гэрээ, хэлцэл байгуулсан ч учирч болох эрсдэлийг тооцоолон өөрт ашигтай байдлаар тохиролцох, учирсан хохирол, гэм хорыг нөхөн төлүүлэхээр шаардах чадваргүйн улмаас ажил олгогчийн хууль, гэрээ зөрчсөн үйлдлийг эсэргүүцэхгүйгээр хүнд, хортой, аюултай нөхцөлд дуулгавартайгаар ажиллаж эрхээ зөрчүүлэх, санхүүгээр хохирох, биеийн болон сэтгэл санааны хүчирхийлэлд өртөх, гэмтэж бэртэх, ёс зүйн доройтолд орох, цаашилбал боолчлол, гэмт хэрэг, зөрчилд өртөх, хохирох тохиолдол гарч байна.

Хүүхэд бэлгийн мөлжлөг болон бусад гэмт хэргийн хохирогч болж байна. Хэдийгээр маш нийтлэг гэж үзэхээргүй боловч охид садар самуун, биеэ үнэлэлтэд уруу татагдах, бэлгийн мөлжлөгт өртөх, эрт жирэмслэх, бэлгийн болон нөхөн үржихүйн эрх нь хангагдахгүй байх, бэлгийн хүчирхийлэлд өртөх, гэмт хэрэгт хохирох тохиолдол цөөнгүй, хөвгүүдийн хувьд архидалт, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, яллагдах, шийтгүүлэх, ажил, хөдөлмөр хийх явцдаа гэмтэж бэртэх, хүнд гэмтэл авах, хүнд, хортой нөхцөлд ажиллаж эрүүл мэнд, ёс суртахуунаараа хохирох нь тулгамдсан асуудал болоод байна.

Хурдан морь унаач хүүхдэд хөдөлмөрийн харилцааны аюултай бүх шинж илэрч байна. Унаач хүүхдүүд насандаа тохирохгүй хэт олон цагаар ажилладаг, ямар ч зав чөлөөгүй морины ажил хийдэг боловч уяачид цалин хөлсийг нь эцэг, эх, асран хамгаалагчид шууд өгдөг, цалингаа өөрөө авсан ч гэрийнхэндээ зарцуулдаг,

²⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2005 он, Дугаар 48

хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнд хүрэхгүй цалингаар ажилладаг, нийгмийн хамгаалал, боловсролын үйлчилгээнд хамрагдах боломжгүй болдог. Мөн хурдан морь унаач хүүхдүүдийн хийдэг ажилд мориноос унан бэртэж гэмтдэг, загнуулах, зодуулах, бусад байдлаар шийтгүүлэх зэргээр бие бялдар, сэтгэл санааны хүчирхийлэлд өртдөг, архи, тамхи зэрэг хот зуршилд автах эрсдэлтэй, хараалын үг хэлэх, нийгмээс тусгаарлагдан найз нөхөдгүй болох зэргээр ёс суртахууны доголдолтой болдог зэрэг хүүхдийн хөдөлмөрийн аюултай бүх шинж илэрч байна.

5. УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭЛТ

Монгол Улсад хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хамрах хүрээний хувьд Улаанбаатар хот болон эрсдэлт орон нутгуудад бүлгээр нь авч үзвэл олон нийт, зорилтот болон мэргэжлийн бүлгүүдэд чиглэсэн байдлаар зорилгын хувьд тэдний ойлголт, мэдлэг хандлагыг нэмэгдүүлэх, чадавхжуулах, хохирогчийг олж, илрүүлэх, туслалцаа үйлчилгээнд холбон зуучлах, хууль тогтоомжийг боловсронгуй болгоход нөлөөлөх, хамтын ажиллагааг сайжруулах зорилгоор зохион байгуулж ирсэн байна. Гэхдээ сүүлийн жилүүдэд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр хийгдсэн үйл ажиллагаа нь олон нийт, эрсдэлт бүлгүүдэд рүү хандсан байдлаар тэдний ойлголт, мэдлэгийг дээшлүүлэхэд илүү анхаарсан байна. Мөн хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ажилладаг төрийн байгууллагын ажилтнуудыг чадавхжуулахад чиглэсэн мэргэшүүлэх сургалтыг УБ хот болон үндэсний хэмжээнд хэрэгжүүлж иржээ. Эдгээр сургалт нь хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын болон нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудад зориулагдсан байсан байна. Урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь дийлэнхдээ төсөл, хөтөлбөрийн хүрээнд хэрэгжсэн гэжээ.

Төрийн байгууллага нь хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, тэмцэх талаар цогц бодлого, хөтөлбөр боловсруулж шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх хэрэгтэй байна. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг төрийн бодлого, оролцоотойгоор хэрэгжүүлэхгүй бол хангалттай үр дүн гарахгүй юм. ОУБ, ТББ-уудын хувьд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тодорхой хугацааг хамарсан төсөл, хөтөлбөрүүдийн хүрээнд тогтвортойгоор зохион байгуулж ирсэн байна. Тиймээс эдгээр байгууллагуудын нөөц боломж, туршлага дээр тулгуурлан амжилттай хэрэгжсэн төсөл, хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх боломжийг бүрдүүлэх, хамрах хүрээг нэмэгдүүлэх ажлыг төрийн бодлого, хөтөлбөртэй уялдуулах, дэмжих замаар тогтвортой байдлыг нь хангахад анхаарах шаардлагатай байна.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд ОУБ, төрийн бус байгууллага, хувийн хэвшлийн оролцоог нэмэгдүүлэхэд анхаарах хэрэгтэй байна. Судалгааны тайлангуудад урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд төрийн болон төрийн бус байгууллага, ОУБ-ын оролцоо, хамтын ажиллагааг цаашид нэмэгдүүлэх хэрэгцээ, шаардлага байгааг дурдсан байна. Мөн МУ-д хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулж ирсэн туршлагад ч дээрх байгууллагууд гол үүрэг гүйцэтгэж ирсэн гэжээ. Харин дээрх гэмт хэрэгтэй тэмцэхэд, ялангуяа урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг үндэсний хэмжээнд хэрэгжүүлэхэд хувийн хэвшлийн байгууллагын оролцоог хангах талаар санал, зөвлөмж тайлангуудад тусгагдаагүй байна. Тиймээс төр өөрөө гүйцэтгэх шаардлагагүй бусад байгууллагын тусламжтайгаар хэрэгжүүлэх боломжтой үйл ажиллагааг гэрээний үндсэн дээр хэрэгжүүлэхдээ хувийн хэвшлийн

байгууллагыг татан оролцуулах шаардлагатай байна. Үүний тулд хувийн хэвшлийн байгууллагын удирдлага болон ажилтнуудыг энэ асуудлаар сургах, чадавхжуулах үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар цаашид энэ салбарын байгууллагуудтай хамтран ажиллах боломж нэмэгдэх юм.

Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахад хохирогчтой ажилладаг мэргэжлийн бүлгийн оролцоо чухал учир ажиллах хүчний нөөцийг нэмэгдүүлэх, тэднийг сургах, чадавхжуулах, мэргэшүүлэх үйл ажиллагааг тогтвортой, үе шаттайгаар хэрэгжүүлэх шаардлагатай байна. Ялангуяа хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагуудын албан хаагчдыг сургах, чадавхжуулах тухай дурдсан байна.

Үүнд;

- Хуулийн салбарын мэргэжилтэн бэлтгэдэг их, дээд сургуулийн сургалтын хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын асуудлыг багтаасан биеэ даасан хичээлийг оруулах, тогтмолжуулах, энэ төрлийн хичээлийг заах багш нарыг бэлтгэх, сургах
- Шүүх эрх мэдэл, хууль сахиулах байгууллагын ажилтнуудыг энэ асуудлаар мэргэшүүлэн сургах сургалтын хөтөлбөр, гарын авлагатай болгох. Дээрх сургалтын хөтөлбөрт ХХГХ-ийг нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, энэ гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөн шалгах, таслан зогсоох тухай болон байгууллагуудын оролцоо, хамтын ажиллагааны талаар агуулгыг тусгах. Мөн энэ гарын авлагыг боловсруулахдаа хууль сахиулах, шүүх, прокурор, хил хамгаалах, ГИХГ-ын албан хаагчдын төлөөллийг оролцуулах, хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх. Цаашид хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагын албан хаагчдыг тогтмол сургаж, чадавхжуулах сургалтын тогтолцоог бүрдүүлэх шаардлагатай байна.
- Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг таних, тогтоох аргазүйд сургах, тусгайлсан удирдамж, зааврыг хууль сахиулах, хил хамгаалах, ГИХГ-ын албан хаагчдад зориулан боловсруулах, хэрэгжүүлж эхлэх. Үүний үр дүнд хохирогчийг олж илрүүлэн, туслалцаа үйлчилгээнд холбон зуучлах боломж бүрдэнэ.
- Мөн хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хохирогч хүүхэдтэй ажиллах чиглэлээр хууль сахиулах, шүүх эрх мэдлийн болон нийгмийн хамгааллын салбарын ажилтнуудыг сургах, чадавхжуулах ажлыг тогтвортой зохион байгуулах
- Бусад орны туршлагаас суралцах боломжийг бүрдүүлэх.

Хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах нэгдсэн хөтөлбөр, аргазүйтэй болох хэрэгтэй байна. Судалгааны тайланд хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа нь одоогийн нөхцөл байдалд нийцэх аргачлал, аргазүйгээр тогтвортой зохион байгуулагдаж ирээгүй байна гэж дүгнэжээ. Мөн хүн худалдаалах гэмт хэрэг нь зохион байгуулалттайгаар үйлдэгддэг, улс дотроо төдийгүй улс дамнан үйлдэгддэг

гэдэг утгаараа бусад гэмт хэргээс ялгагддаг учир урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд дээрх нөхцөл байдлын аль аль нь багтсан байх хэрэгтэй байна.

Цаашид хүн худалдаалах гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулахдаа:

- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тогтвортой, үе шаттайгаар олон нийт, зорилтот бүлгийн соёл, нас, сэтгэлзүйн онцлогт тохирсон байдлаар олон арга хэлбэрээр зохион байгуулах.
- Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны агуулга нь олон нийтийн сэтгэлзүйг айлгаж, цочроосон биш, хүн худалдах гэмт хэрэгт өртөхөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлд өртсөн тохиолдолд өөрийгөө болон бусдыг хамгаалахад туслах агуулгыг багтаасан байх. Мөн хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэл бүхий зорилтот бүлгүүдэд илүү анхаарах
- Эрсдэлт бүлэгт болон хүн худалдаалах гэмт хэрэг ихээр үйлдэгддэг газар, орон нутгууд, алслагдсан дүүрэг, сум, баг, хороонд хүрч очиж урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах. Энэ нь хохирогчийг олж илрүүлэх, туслалцаа үйлчилгээнд хамруулахад илүү тустай.
- Ялангуяа Хүн худалдаалах гэмт хэрэг ихээр үйлдэгддэг үйлчилгээний газруудын ажилтнууд түүгээр үйлчлүүлж буй хүмүүст зориулсан урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа зохион байгуулах.
- Хүүхдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа насанд хүрэгчдийнхээс ялгаатай, өвөрмөц онцлогтой байх учир тусгайлсан үйл ажиллагааг зохион байгуулах. Сүүлийн үед цахим орчинд хүн худалдаалах гэмт хэрэг үйлдэгдэх эрсдэл бий болсон учир цахим орчинд аюулгүй байх, эрсдэлд өртөхгүй байх чиглэлээр хүүхдүүдийг сургах, ойлголт мэдээлэлтэй болгох, өөрийгөө болон бусдыг хамгаалах чадварт суралцуулах үйл ажиллагааг сургуультай хамтран зохион байгуулах
- Хүн худалдаалах гэмт хэрэг, бэлгийн мөлжлөгөөс гадна бусад төрөл, хэлбэрүүдээс урьдчилан сэргийлэх агуулгыг урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд багтаасан байх. Тухайлбал: албадан хөдөлмөрийн тухай

Урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг зохион байгуулах төрөл, хэлбэрүүдийг нэмэгдүүлэх. Нэгдүгээрт, Сүүлийн үед түгээмэл хийгдэж байгаа олон нийт, зорилтот бүлэгт зориулсан хэвлэл мэдээллийн аянаас гадна олон нийт, зорилтот бүлэг хүрч очиж мэдээлэл өгөх үйл ажиллагааг зохион байгуулах аргазүйд суралцах, хөгжүүлэх. **Хоёрдугаарт,** Мэдээлэл өгөх зорилго бүхий цэгүүдийг эрсдэл өндөртэй томоохон хот, хилийн боомт хот, үйлчилгээний газруудыг түшиглэн бий болгох

Төрөөс хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай зардлыг улсын төсөвт суулгах, батлуулах. МУ-д хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа нь дийлэнхдээ донор, ОУБ-ын байгууллагуудын дэмжлэгтэйгээр төсөл, хөтөлбөрийн

хүрээнд хэрэгжиж ирсэн байна. Тиймээс улсаас энэ гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай тодорхой зардлыг жил бүрийн улсын төсөвт суулгах, батлуулах шаардлагатай байгаа юм. Үүний үр дүнд хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тогтвортой явагдах боломж бүрдэнэ.

Холбогдох хууль тогтоомж, бодлогыг хэрэгжүүлэх, боловсронгуй болгоход нөлөөлөх талаар. Хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл байдал, олон нийтийн ойлголт, мэдлэг, хандлагыг тандсан судалгааг тодорхой хугацаанд тогтвортой хийх замаар энэ гэмт төрлийн хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг тухайн нөхцөл байдалтай уялдуулан зохион байгуулах, цаашдын бодлого, хөтөлбөрт тусгах

6. ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭЛТ

Монгол Улс нь 2008 онд Палермогийн протоколд нэгдэн орсон. Тус протоколд нэгдэн орсноос хойш хүн худалдаалах явдалтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогчийг хамгаалах зорилгоор 2012 онд бие даасан Хүн худалдаалахтай тэмцэх тухай²⁷ хуулийг баталсан. Палермогийн протоколтой нийцүүлж боловсруулсан Эрүүгийн хуульд заасан зарим зохицуулалт хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа явуулахад төвөгтэй байдлыг үүсгэж байгаа нь гэмт хэрэг үйлдэгсэд хөнгөн ялтай гэмт хэрэгт эрүүгийн хариуцлага хүлээх нөхцөлд хүргэж байна. Тухайлбал,

1. Палермогийн Протокол, Эрүүгийн хуулийн зорилтыг хангахуйцаар хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн нийгмийн хор аюулын шинж чанарт тохирсон хэмжээгээр оногдуулах ялын хэмжээг тодорхойлох юм. Эрүүгийн хуульд оногдуулах хорих ялын ялын интервал хэт хол байгаа нь шүүхээс хууль хэрэглэхэд ойлгомжгүй, эргэлзээтэй байдлыг бий болгож байна. Мөн хүн худалдаалах гэмт хэрэгтэй өрсөлдөх хэмжээ бүхий зүйлүүдийг Эрүүгийн уулийн тусгай ангид зааж, ялын хэмжээг хөнгөн заасан нь хууль хэрэглээний практикт хөнгөн гэмт хэргээр зүйлчлэх боломжийг бий болгож байгааг анхаарах.
2. Эрүүгийн хуулийн тусгай ангийн 12.3 дугаар зүйлд заасан “Бэлгийн мөлжлөг” гэмт хэргийн 12.3.2, 12.3.4 дэх хэсэгт заасан хүндрүүлэх шинжид ‘энэ төрлийн гэмт хэргийг хохирогчийн биеийг үнэлүүлж, ашиг олох зорилгоор’ гэж заасан. Энэ нь Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд заасан “Хүн худалдаалах” гэмт хэрэгтэй өрсөлдүүлсэн хэм хэмжээ бий болсон.
3. Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд албадан хөдөлмөрлүүлэх явдлыг гэмт хэрэгт тооцохдоо мөн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэргийн албадан хөдөлмөрлүүлж мөлжих үйлдлийн шинжийг давхардуулсан.
4. Эрүүгийн хуулийн 16 дугаар бүлэгт Хүүхдийн эсрэг гэмт хэргийг хуульчилсан нь нэг талаасаа хүүхдийн хууль ёсны эрх, ашиг сонирхлыг хамгаалахад чиглэсэн. Гэвч хуулийн

²⁷ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2012 он, Дугаар 07

- ❖ 16.4 дүгээр зүйл Хүүхдээр гуйлга гуйлгах;
 - ❖ 16.6 дугаар зүйл Хүүхэд худалдах;
 - ❖ 16.8 дугаар зүйл Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах
 - ❖ 16.9 дугаар зүйл Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах
 - ❖ 16.10 дугаар зүйл Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийн шинжүүд нь хүн худалдаалах гэмт хэргийн шинжүүдтэй давхцаж байна. Өөрөөр хэлбэл, Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлийн тайлбарт хүүхдийн эсрэг энэ гэмт хэргийг үйлдсэн бол ямар аргаар хэрхэн үйлдсэн эсэхийг үл харгалзаж хүн худалдаалах гэмт хэрэг гэж үзэхээр тайлбарласан.
5. Эрүүгийн хуулийн 15.3 дугаар зүйлд Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах гэмт хэргийг заахдаа ‘хууран мэхэлж, эсхүл хүч хэрэглэж, эсхүл хүч хэрэглэхээр заналхийлж, хохирогчийн хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдал, биеэ хамгаалж чадахгүй байдлыг далимдуулж хүний цусыг, эсийг, эд, эрхтнийг авсан’ бол гэж заасан нь мөн хуулийн **13.1 дүгээр зүйл дэх Хүн худалдаалах гэмт хэргийн агуулга нь “... хүний эд, эрхтнийг авах...” үйлдэлтэй давхцаж байна.**

Хүн худалдаалах түүнтэй төстэй гэмт хэргийг хэрэг бүртгэлтийн үе шатад хаасан, хэрэгсэхгүй болгосон тохиолдолд дүн шинжилгээ хийх. 2017-2021 онд цагдаагийн байгууллагад хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэг нийт 241 бүртгэгдэж, 3 хэрэг хэрэгсэхгүй болж, 137 хэргийн хэрэг бүртгэлтийг хаасан нь нийт гэмт хэргийн 58%-ийг нь мөрдөн байцаалтын болон прокурорын хяналтын шатад дуусгавар болж байна²⁸. Иймд хэрэг бүртгэлтийг хаасан, хэрэгсэхгүй болгосон хэргийн үндэслэл бүрэн нотлогдсон эсэх, шаардлагатай мөрдөн шалгах ажиллагаа явагдсан эсэх талаар судлах байдал чухал байгааг харуулж байна.

Эрүүгийн хэргийн хавтаст хэрэгт авагдсан нотлох баримт нь мэдүүлгэн нотлох баримтаар бэхжүүлсэн байна. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд нотлох баримтыг төрлийг ... мэдүүлэг, эд мөрийн баримт, баримт бичиг, шинжээчийн дүгнэлт, мөрдөгчийн магадалгаа, гэрэл зураг, зураглал, дуу-дүрсний бичлэг, ул мөрөөс авсан хэв, мөрдөн шалгах ажиллагааны болон шүүх хуралдааны тэмдэглэл гэх зэргээр зааж өгсөн²⁹. Гэтэл хавтаст хэргийн материалтай танилцах явцад мэдүүлгэн нотлох баримтыг голчлон ашигласан байлаа.

Энэ төрлийн гэмт хэрэгт өртөж хохирсон насанд хүрээгүй хохирогчийн хууль ёсны төлөөлөгчийг чадавхжуулах шаардлагатай байна. Хохирогчдод томилон өгч байгаа хууль ёсны төлөөлөгч гэмт хэрэг хэрэгтний нөлөөнд автах, нэгэнт

²⁸ МУ-д ГХУСА33, Азийн сан, Дэлхийн зөн ОУБ, ХТЭТ нар “Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ” судалгааны тайлан, 2022 он

²⁹ Мөн тэнд, хуудас 84

хохирсон хохирогчийг буруутгах, хайхрахгүй орхих үзэгдэл түгээмэл ажиглагдсан³⁰. Тиймээс хууль ёсны төлөөлөгчийг хариуцлагыг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.

Зөрчил шалган шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй эрх бүхий албан хаагч болон Прокурорын хяналтыг сайжруулах шаардлагатай байна. Цагдаагийн байгууллагад шалгагдсан зөрчлийн материалтай танилцах явцад Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 6.18.4 дэх хэсэгт заасан зөрчилд ихэнхдээ биеэ үнэлж бусадтай бэлгийн харьцаанд орсон хүнд л хариуцлага тооцож байна³¹. Түүнчлэн түгээмэл үйлдэгддэг биеэ үнэлэхийг зохион байгуулж буй үйлдэл нь хүн худалдаалах гэмт хэргийн шинжтэй эсэхийг заавал тогтоох шаардлагатай байна.

Эрүүгийн хэргийн анхан, давж заалдах, хяналтын шатны шүүгчдэд хүн худалдаалах түүнтэй төстэй гэмт хэргийг талаар нэгдсэн ойлголт мэдээлэл өгөх, мэдлэгийн дээшлүүлэх, ойлголтын зөрүүг арилгах хэрэгтэй байна. Эрүүгийн хэргийн шүүгчдэд хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийн хохирогчдын мэдүүлгийг ямар байдлаар үнэлэх, ялангуяа олон улсын практикт энэ төрлийн гэмт хэргийн хохирогчдод явуулах шүүн таслах ажиллагаанд юуг анхаардаг, насанд хүрээгүй хохирогчийг хэрхэн хамгаалдаг зэрэг хохирогч хамгааллын үйл ажиллагааг шүүхийн үе шатнаас хэрхэн явуулдаг, ял шийтгэлийг оногдуулахдаа юуг голчлон харгалзан үздэг зэрэг сургалтаар олгох.

Хохирогч төвтэй хэрэг бүртгэлт, мөрдөн байцаалт, түүнд тавих прокурорын хянан шалгах ажиллагааны механизмыг бүрдүүлэх журам стандартыг боловсруулах³².

Хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх тусгай сантай болох. Хохирогчдод учирсан хохирлыг тухайн хэрэг шалгагдаж эхэлсэн цагаас эхлэн барагдуулж байх, гэмт хэрэгтнээс хураасан хөрөнгө, гэмт хэргийн нөхөн төлбөрөөс сандаа төвлөрүүлж ажиллах

Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт өртөж хохирсон төлбөрийн чадваргүй хохирогч (насанд хүрсэн хүн болон насанд хүрээгүй хүн) хууль зүйн туслалцаа, өмгөөллийн үйлчилгээ авах замаар хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах эрх зүйн боломж байхгүй байна. Энэ нь хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дах хэсэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар зохицуулсан ч өнөөдрийг хүртэл батлагдаагүй байна³³.

³⁰ Мөн тэнд, хуудас 85

³¹ Мөн тэнд, хуудас 83

³² АНУ-ын Төрийн департамент, Азийн сан, ХТЭТ нар “Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагыг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх” судалгааны тайлан, 2017 он, хуудас 9-16

³³ Судалгааны тайлангуудад Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг даган гаргах ялангуяа үйлчилгээтэй холбоотой 6 төрлийн журмаас 3 журам батлагдан гаргаагүй байна гэсэн дүгнэлт гарсан. Түүний нэг нь хууль зүйн туслалцаа үзүүлэх журам юм.

Цагдаагийн байгууллагад хүн худалдаалах түүнтэй төстэй гэмт хэргийн дагнасан мөрдөгчийг нэмэгдүүлэх, бий болгох. Цагдаагийн байгууллагын эрүүгийн болон мөрдөн байцаах албаны бүтцэд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөх нэгж байгуулагдсан ч нутаг дэвсгэр хариуцсан цагдаагийн байгууллагуудад хариуцсан албан тушаалтан байхгүй байна.

Хүн худалдаалах гэмт хэргийн бусад төрөл, хэлбэрүүдийг илрүүлэх, тогтоох, хянан шалгах ажиллагааг нэмэгдүүлэх. Хөдөлмөр мөлжлөгийн гэмт хэрэг МУ-д үйлдэгдэж байгааг илтгэх баримтууд байгаа хэдий ч тус гэмт хэргийг илрүүлэх, хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй байна. Хөдөлмөр мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг илрүүлэх, хянан шийдвэрлэх, ял шийтгэл онооход тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулах хууль зүйн дүн шинжилгээ хийх.

Зөрчлийн хэрэг тухайлан Зөрчлийн тухай хуулийн 6.18 дугаар зүйлийн 6.18.4 дэх хэсэгт заасан зөрчилд ихэнхдээ биеэ үнэлж бусадтай бэлгийн харьцаанд орсон хүнд л хариуцлага тооцож байна. Зөрчил шалгаж шийдвэрлэх ажиллагаанд оролцож буй эрх бүхий албан хаагч болон Прокурорын хяналтыг сайжруулах, мөн биеэ үнэлэхийг зохион байгуулж буй үйлдэл нь хүн худалдаалах гэмт хэргийн шинжтэй эсэхийг заавал тогтоох шаардлага байна.

Судалгааны ажлын даалгаварт тусгагдсан нийт 12 төрлийн судалгааны тайлангаас хүн худалдаалахтай холбоотой хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаатай холбоотой дүгнэлт, санал, зөвлөмжийг нэгтгэн дүгнэхэд дараах хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлтийг оруулах саналыг дэвшүүлсэн. Үүнд;

1. Эрүүгийн хууль тогтоомжид өөрчлөлт оруулах.

- 1.1. Хүн худалдаалах гэмт хэргийн төрөл, хэлбэрийг бие даасан гэмт хэрэг болгож хуульчилсан байдлыг залруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй байдлыг бий болгохгүй байхын тулд хуулийн зүйл заалтуудыг тодорхой болгох
- 1.2. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль дах “хохирогч” гэсэн тодорхойлолтыг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн тодорхойлолттой нийцүүлэх
- 1.3. Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2018 оны 01-р сарын 19-д батлагдсантай холбоотойгоор Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд “эд, эрхтнийг авах...” гэсний өмнө “эс” гэж нэмэх
- 1.4. Хүн худалдаалах гэмт хэрэгт шалгагдаж буй этгээдэд хорих, гадаадад зорчих эрхийг хязгаарлах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч дахин гэмт хэрэг үйлдэхээс сэргийлэх арга хэмжээ авах

2. Зөрчлийн тухай хуульд өөрчлөлт оруулах.

- 2.1. Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт “Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль зөрчих” бие даасан зөрчлийг нэмж, хуулиар үүрэг хүлээсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг тусгах
3. **Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах**
 - 3.1. Хохирогчдод анхан шатны туслалцааг хэн, хэрхэн үзүүлэх асуудлыг тодорхой зааж оруулах, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох
 - 3.2. Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйлд тус хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай заасан хэдий ч Зөрчлийн тухай хуульд энэ талаар огт тусгаагүй байна.
 - 3.3. Хуулийн 15 дугаар зүйлд заагдсан хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг боловсруулан батлуулах
 - 3.4. Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагчдыг ААНБ, ажлын байранд гэнэтийн хяналт шалгалт хийх эрхийг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 162.2.1 дэх заалттай уялдуулан Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох журамд тусгах
 - 3.5. Албадан хөдөлмөрийн тодорхойлолтыг хүн худалдаалах гэмт хэргийн хөдөлмөрийн мөлжлөгийн ойлголт, тодорхойлолттой уялдуулах
 - 3.6. Хохирогчдод үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийг зохицуулсан журмыг боловсруулах, батлах
 - 3.7. Хохирогчдод мэдээлэл өгөхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалтыг хууль болон хуулийг даган гарах журамд дараах агуулгыг тусгах. Үүнд
 - 3.7.1. Төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлдэг тусламж, үйлчилгээ
 - 3.7.2. Эрүүгийн болон захиргааны шинжтэй процессын үе шат, үйл явц
 - 3.7.3. Хууль зүйн үнэ төлбөргүй эсхүл бага хэмжээний туслалцаа авах боломж
 - 3.7.4. Хохирогчийг болон гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга хэмжээ
 - 3.7.5. Хувийн нууцлалаа хангуулах эрх
 - 3.7.6. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдээлэл авах эрх
 - 3.7.7. Хохирол нөхөн төлүүлэх асуудал
 - 3.7.8. Гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд оршин суух зөвшөөрөл, орогнол, оршин суух эрх хүсэхтэй холбоотой зохицуулалт гэх мэт.

4. Хөдөлмөрийн тухай хуулийг бусад хууль тогтоомжтой нийцүүлэх.

- 4.1. Хөдөлмөрийн тухай хууль (1999)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалтад заасан “албадан хөдөлмөр”-ийн тодорхойлолт болон шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.13 дэх “албадан хөдөлмөрлүүлэх” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоосон зохицуулалтыг тус тус албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцтой бүрэн нийцүүлэх шаардлагатай. Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлийг: “Тухайн хүн өөрөө сайн дураараа эсхүл сайн дурын үндсэн дээр гэдгээ илэрхийлээгүй тохиолдолд аливаа торгууль, шийтгэл, хүлээлгэх, хуурах, айлгах, сүрдүүлэх, зүй бусаар нөлөөлөх эсхүл хүч хэрэглэх байдлаар аливаа ажил, үйлчилгээг гүйцэтгүүлсэн бол ... ” гэх байдлаар өөрчлөх.

Хүснэгтээр үзүүлбэл,

Хөдөлмөрийн тухай хууль (шинэчилсэн найруулга) (2021)³⁴	Хөдөлмөрийн тухай хууль Хуучин хууль (1999)
<p>8 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэхийг хориглох 8.2. Албадан хөдөлмөрлүүлэх гэж аливаа торгууль, шийтгэл ногдуулахаар айлган сүрдүүлэх, хүч хэрэглэх, хүч хэрэглэхээр заналхийлэх замаар хүнийг хүсэл зоригийнх нь эсрэг ажил, үйлчилгээ эрхлүүлэхийг ойлгоно.</p>	<p>3 дугаар зүйл. Хуулийн нэр томьёо 3.1.14. ‘албадан хөдөлмөр’ гэж хөдөлмөрийн сахилгыг сахиулах, ажил хаялтад оролцсоныг болон улс төр, эдийн засаг, нийгмийн тогтолцооны талаарх өөрийн үзэл бодлоо илэрхийлснийг цээрлүүлэх, нийгмийн гарал үүсэл, яс үндэс, арьсны өнгө, шашин шүтлэгээр нь ялгаварлах зорилгоор, эсхүл ажилтны амь нас, эрүүл мэндэд аюултай байдал үүссэн зэргийг үл харгалзан ажилтнаас гүйцэтгэхийг шаардсан ажил үүргийг</p>
<p>Албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенц 1930 оны 6 дугаар сарын 28-ны өдөр баталж, 1932 оны 5 дугаар сарын 1-ний өдөр хүчин төгөлдөр болсон.</p>	

³⁴ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2021 он, Дугаар 31

Монгол Улс 2005 оны 02 дугаар сарын 24-ний өдөр соёрхон баталсан.³⁵
2 дугаар зүйл. 1. Энэхүү конвенцын зорилгоор ‘албадан буюу заавал хийлгэх хөдөлмөр’ гэж ямар нэг шийтгэл хүлээлгэхээр айлган сүрдүүлж аливаа этгээдээр гүйцэтгүүлэх, чингэхдээ уг этгээд нь өөрийн сайн дугаар гүйцэтгэхийг санал болгоогүй бүх ажил буюу үйлчилгээг хэлнэ.
Эрүүгийн хууль (шинэчилсэн найруулга) (2015)³⁶
13.13 дугаар зүйл. Албадан хөдөлмөрлүүлэх 1. Бусдад хүч хэрэглэж, хүч хэрэглэхээр заналхийлж, илт хохиролтой болзол, нөхцөл тулгаж, эсхүл хөрөнгө чинээ, эрүүл мэнд, хөгжлийн бэрхшээлтэй байдал, гэр бүлийн таагүй орчин, амьдрал ахуйн бусад хүнд байдлыг далимдуулан эрхшээлдээ оруулж цалин хөлсгүй хөдөлмөр эрхлүүлсэн бол таван мянга дөрвөн зуун нэгжээс хорин долоон мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр зуун дөчин цагаас долоон зуун хорин цаг хүртэл хугацаагаар нийтэд тустай ажил хийлгэх, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл нэг жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

³⁵ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2005 он, Дугаар 9

³⁶ Төрийн мэдээлэл эмхэтгэл: 2016 он, Дугаар 07

7. ХАМТЫН АЖИЛЛАГАА

Засгийн газар хүний эрх, хохирогч хамгаалал, жендэрийн тэгш эрхийн бодлогод суурилсан сайн бодлого, хууль эрхзүйн орчинг хэрэгжүүлснээр хүн худалдаалахтай тэмцэх хариу арга хэмжээг сайжруулдаг ба үүнийг хэрэгжүүлэхийн тулд олон талт хамтын ажиллагааг хөгжүүлэх нь чухал байдаг.

Оролцогч талуудын мэдлэг, мэдээлэл дутмаг, нэгдсэн ойлголт сул байна. ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ажиллаж буй байгууллага хоорондын ил тод мэдээллийн урсгал хангалтгүй буюу хаана ямар байгууллага ямар үйл ажиллагаа хэрэгжүүлсэн, төрөөс тухайн чиглэлд ямар бодлого барьж ажиллаж байгаа талаар тогтолцооны оролцогч талуудын мэдлэг, мэдээлэл дутмаг, нэгдсэн ойлголт сул байна. Нэгдмэл, цогц байдал, олон талын оролцоо хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын үйл ажиллагаа нэгдмэл, цогц шинжтэй олон салбарын огтлолцол дээр явагддаг үйл ажиллагаа болохыг харгалзан үзэх хэрэгтэй.

Хүн худалдаалахтай тэмцэх үүрэг хүлээсэн субъектүүд чиг үүргийнхээ талаар нэг мөр ойлголттой, хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах үүднээс хуулиар тодорхойлсон үйл ажиллагааны зарчмыг нарийвчилж гаргах хэрэгтэй байна. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг түлхүү авч хохирогчийн бие махбод, сэтгэл зүйн эмзэг байдлыг эс хайхарвал бүрэн үр дүнд хүрэхгүй бөгөөд эсрэгээрээ хохирогчийг хууль хяналтын байгууллагаас зугтах, зайлсхийх байдалд хүргэх, мөрдөн шалгах ажиллагааны дүнд нөлөөлөх эрсдэлтэйг тооцож үйл ажиллагааны журам, зарчимд тусгах шаардлагатай байна. Түүнчлэн хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг хуульд тусгах шаардлагатай байна.

Хохирогч хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны уялдаа холбоог хангаж ажиллах шаардлага бий болсон байна. Хохирогч хамгаалалтай холбоотой эрх бүхий байгууллагын хүлээх үүрэг, уг ажиллагаанд оролцох оролцооны талаарх Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим зохицуулалт тунхаглалын шинжтэй байгааг өөрчилж, үйл ажиллагаа, дэс дараалал, журам хэлбэртэй болгох шаардлагатай. Энэ хүрээнд хохирогчийг таньж тогтоох, тусламж, үйлчилгээнд холбон зуучлах, хамгаалах, тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэг одоогийн хуульд заасан үйл ажиллагаанд хууль сахиулах, хил хамгаалах, прокурор, боловсрол, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд хэрхэн оролцох талаар журамласан зохицуулалт бий болгох хэрэгтэй. Түүнчлэн эдгээр байгууллага хооронд мэдээлэл, статистик, бусад шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй солилцож байх зарчмыг тогтоох шаардлагатай байна.

Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагааг сайжруулахад шинэ техник, технологи, бусад улсын сайн туршлагыг нэвтрүүлэх хэрэгцээ бий

болсон байна. Бусад улс орнууд төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг цахимаар мэдээлэл солилцож, шийдвэр гаргах талаар амжилттай ажилладаг сайн туршлагууд бий болсон тул эдгээр хувилбарыг өөрийн эх орондоо нэвтрүүлэх боломжтой. Ийм сувгийг ашиглан хохирогчийг таньж тогтоох, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх, хамгаалалтын арга хэмжээ авах ажиллагааг тасралтгүй явуулж, ажиллагааг хөнгөвчилж болно. Үүний тулд цахим платформ хөгжүүлэх бөгөөд хохирогчийг таньж тогтоох, байгууллага хооронд шуурхай холбоо тогтоох, ажиллагааны бүртгэл-хяналт хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээ, хамгаалалтын арга хэмжээнд холбон зуучлах, тайлан мэдээлэл гаргах зэрэг функцийг эхний ээлжид хөгжүүлэх ёстой. Ингэснээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага хоорондын харилцаа сайжрахаас гадна уялдаа холбоо нь хангагдах, нэгдсэн бүртгэл статистик хийх, улмаар шаардлагатай тусламж, үйлчилгээг нэг ч хохирогч үлдээлгүй жигд хүргэх нөхцөл бүрдэнэ.

Төр, төрийн бус, олон улсын байгууллагуудын хувьд хамтын ажиллагааны зарим тогтсон хэлбэрүүд хэдийнээ бий болсон ч хангалттай хэмжээнд биш байна. Нийт судалгаанд хамрагдсан байгууллагын 36% нь хамтран ажиллахдаа харилцан ойлголцлын санамж бичгийн үндсэн дээр хоорондоо хамтарч ажилладаг бол 60% нь ямар нэг гэрээ, санамж бичиг үйлддэггүй, зөвхөн тодорхой үйл ажиллагаанууд дээр хамтрах хэлбэрээр ажиллаж байна. Тиймээс хамтын ажиллагааг бэхжүүлэх, өргөжүүлэх, талууд хамтын ажиллагааны чиглэлийг тодорхой болгох, уялдаа холбоог тогтоох, үр дүнг тооцдог механизмтай болгох тал дээр анхаарч ажиллах хэрэгцээ бий болсон байна.

Хүүхэд худалдаалахтай тэмцэх чиглэлээр бүх талуудын оролцоо, хамтын ажиллагаа сайн байна. Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлд бүх талуудын хамтран ажиллах сонирхол, санаачилга сайн бөгөөд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх болон нөлөөллийн ажил зохион байгуулах чиглэлд талуудын хамтын ажиллагаа харьцангуй сайн байна. Төр, төрийн бус, ОУБ-ын төлөөллөөс ХХГХ-тэй тэмцэхэд чиглэсэн ажлуудаас ямар төрлийн ажлуудад хамтын ажиллагаа илүү идэвхтэй явагддаг талаар тодруулахад бүх талуудын хувьд урьдчилан сэргийлэх чиглэлийн хамтын ажиллагааг эергээр үнэлсэн байна. ХХГХ-тэй тэмцэх бусад үйл ажиллагааг энэ загвараар явуулбал илүү үр дүнд хүрэх боломжтой юм.

Гэвч эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд болон хохирогч байж болзошгүй хүүхдийг эрт илрүүлэх, хохирогчдод туслалцаа үзүүлэх чиглэлд талуудын хамтын ажиллагаа хангалтгүй байна. Төр, ТББ хоорондын хамтын ажиллагааны хувьд байгууллагуудын мэдээллээ солилцох, харилцан уялдаатай ажиллах байдал сул байна. ОУБ-ын хувьд хохирогчийг хамгаалах болон хохирогчид нийгмийн хамгааллын үйлчилгээ үзүүлэх хамтын ажиллагааны өнөөгийн байдлыг бусад төр,

ТББ-аас доогуур үнэлгээ өгсөн байна. Энэ нь хамтын ажиллагааны механизм бүрдээгүй, хууль тогтоомж болон хэрэг илрүүлэлт хянан шийдвэрлэх ажиллагааны талаар мэдээлэл хангалтгүй зэрэгтэй холбоотой байна. Түүнчлэн хамтран ажиллахад төрийн бус байгууллага бэрхшээл багатай байхад төрийн байгууллагатай ажиллахад олон талын хүндрэл учирдаг болохыг тэмдэглэсэн ба төрийн институтийн шаталсан бүтэц болох процесстой холбон тайлбарлаж байна. Хохирогчийг илрүүлэх, хамгаалах чиглэлд бүх талын хамтын ажиллагаа, оролцоог тогтсон практикт тулгуурлан хөгжүүлж, сайжруулах шаардлагатай байна.

Хавсралт 1. Судалгааны үр дүнгийн нэгдсэн хураангуй

ХҮН ХУДАЛДААЛАХ ГЭМТ ХЭРГИЙН СУДЛАГДСАН БАЙДЛЫН ТОЙМ, ЗӨВЛӨМЖ

СУДАЛГААНЫ НЭР	ХУУЛЬ ЭРХЗҮЙН ОРЧИН	ХОХИРОГЧ ХАМГААЛАЛ	УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ	ХЭРГИЙН ШИЙДВЭРЛЭЛТ	ХАМТЫН АЖИЛЛАГАА
<p>1 "Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хохирогч төвтэй аргачлалыг хэрэгжүүлэхтэй холбоотой Монгол Улсын хууль тогтоомж болон сургалтын гарын авлагаг харьцуулах, албан хаагчдын чадавхыг үнэлэх судалгааны тайлан", 2017, Азийн сан, Хүйсийн тэгш эрхийн төв</p> <p>Санхүүжүүлэгч: АНУ-ын Төрийн Департамент</p>	<p>Эрүүгийн хууль тогтоомжийн шинэчлэлийн хүрээнд хүн худалдаалах, мансууруулах, сэтгэцэд нөлөөлөх эм, бэлдмэлийн хууль бус эргэлт, мөнгө угаах зэрэг улс дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэхэд шинээр батлагдсан хуулиудын тодорхой хугацааны хэрэгжилтийн явцад уялдаа холбоог хангах, коллиз, хийдэл, алдааг холбогдох судалгааг үндэслэн Хууль тогтоомжийн тухай хуулийн дагуу боловсронгуй болгох шаардлага бий болжээ.</p> <p>Дотоодын бүтээлд ХХГХ-т шинжилгээ хийхтэй холбоотой зүйл дурдагдаагүй байна. ХХГХ үйлдэгдсэн тохиолдолд илрүүлж бэхжүүлсэн мөр, эд мөрийн баримтад</p>	<p>ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа болон хууль сахиулах байгууллагуудын /Цагдаа, Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, Хил хамгаалах алба, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллага, ГИХГ, Хууль зүйн туслалцааны төв, ХСИС/ ажлын уялдаа холбоог сайжруулах, тусгайлан зориулсан гарын авлага боловсруулах нь зүйтэй.</p> <p>Судалгаанд хамрагдсан Цагдаагийн газар, хэлтсүүдэд хохирогчоос мэдүүлэг авах тусгай өрөө байгаа эсэх талаар тодруулахад 52% (104) нь байгаа гэсэн боловч тэдний 47% (49) нь л тогтмол ашигладаг гэж хариулсан нь өрөөний ашиглалт хангалтгүй байгааг харуулж байна. Ашигладаггүй шалтгааныг тодруулахад шалтгааныг нь сайн мэдэхгүй байна, үүнийг хариуцдаг эрх бүхий хүн биш гэсэн хариултаудыг өгсөн. ХХГХ-ийн хохирогч, гэрчийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад мэдүүлэг авах тусгай өрөө нь чухал ач холбогдолтой учраас энэхүү өрөөний ашиглалтыг сайжруулах шаардлагатай байна.</p>	<p>ХХГХ-ийн түүхийг илүү дэлгэрэнгүй авч үзэх шаардлагатай байна. Бие даасан сурах бичиг гаргах шаардлагатай гэж бид үзэж байна. Өөрөөр хэлбэл ХХГХ-ийн түүхийг бичсэнээр хойч үеийнхэндээ уг гэмт хэргийн хор хөнөөл, аюул, заналхийллийг ойлгуулах онцгой ач холбогдолтой. Түүхэн үзэгдлийнхээ хувьд ямар хэлбэр, төрлөөр улам бүр баяжиж байгааг зурагт тайлбар толь гаргах замаар нийтэд мэдээлэх нь энэ гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх механизмыг улам бүр боловсронгуй болгоно.</p> <p>Цаашид сургалтыг бодит кейсүүд дээр ажиллах байдлаар зохион байгуулбал илүү үр дүнтэй гэж 68% (136) нь хариулсан</p>	<p>Шүүгчдээс ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр нэн чухал, чухал гэж ХХГХ-ийн хохирогч, гэрчийг хамгаалах, харилцах, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх үйл ажиллагаа урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, таслан зогсоох, нотлох баримт цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, ХХГХ-тэй тэмцэх байгууллагуудын хамтын ажиллагаа гэсэн чиглэлээр мэдээлэл авах гэж үзэж, эдгээр чиглэлээр сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илэрхийлсэн.</p> <p>Прокурор нараас эрүүгийн хэрэгт хяналт тавих, шүүх хуралдаанд улсын яллагчаар оролцож байхдаа хохирогчтой ажиллахдаа хэрэглэдэг тусгай арга, техник, журам,</p>	<p>ХХГХ-тэй тэмцэх хууль тогтоомжийн мөн чанар нь нэгэнт үйлдэгдсэн ХХГХ-ийг нотлоход бус урьдчилан сэргийлэхэд хууль зүйн учир холбогдол нь оршиж байгаа бөгөөд тэдгээрийн хэрэгжилт нь нийгэм, эдийн засгийн байдалтай холбоотой боловч төрийн байгууллагуудын хамтын ажиллагаа, алба хаагчдын хууль дээдлэх, хүний эрх, эрх чөлөөг хангах хамгаалах хандлага, мэдлэг, мэргэшлийн ур чадвараас ихээхэн шалтгаалдаг байна.</p> <p>Хохирогчдын үзэж байгаагаар хуулийн байгууллагын ажилтнуудын харьцаа, хандлага эерэг байсан боловч, зарим ажилтан албан хаагчдын зүгээс олон</p>

<p>шинжилгээ хийх арга зүйн талаар тусгаж өгөх нь мөрдөх ажиллагаанд чухал нөлөөтэй. Хэрвээ шинжилгээ зүйн асуудал орхигдвол бид асуудалд иж бүрэн хандахгүй байгааг илтгэх хэрэг болно. Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн, ХСИС-ийн Шинжлэн магадлахуйн тэнхимтэй хамтран энэ агуулгыг судлах нь илүү оновчтой гэж үзсэн. Шинээр батлагдсан Эрүүгийн болон ЭХХШТХийн агуулгаар бид ХХГХ-ийн талаар шинэлэг тодорхойлолт гаргах болсон байна. ХХГХ-ийг эрүүгийн эрх зүйн үүднээс тайлбарлах, хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагааг оновчтой, зөв зохион байгуулах, ингэхдээ ил болон нууц мөрдөн шалгах ажиллагааг оновчтой хослуулан явуулах, прокурор, шүүх, хилийн шалган нэвтрүүлэх алба (ХШНА), ГИХГ-ын алба хаагчдад энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд шаардлагатай</p>	<p>Судалгаанд оролцогчдын 22.2% (4) нь хохирогчтой харьцахдаа баримтлах тусгай тогтсон стандарт арга техник, журам, асуумж байхгүй, 66.7% (12) нь мэдэхгүй гэж хариулсан байгаа тул холбогдох стандарт арга техник, журам, асуумжийг боловсруулах, сайжруулах, гарын авлага болгон алба хаагч бүрд хүртээмжтэй тараах, хохирогчийг таньж илрүүлэх, холбогдох арга хэмжээ авах сургалтыг зохион байгуулах хэрэгцээ байна.</p> <p>ХШНА-ны судалгаанд оролцсон алба хаагчдын 54% (29) нь эмэгтэйчүүдийг хүүхэд тээлгэх зорилгоор худалдаалдаг талаар сонсож байгаагүй байна. Хүүхэд тээлгэх зорилго нь сайн дурын үндсэн дээр харилцан тохиролцсон байвал танин мэдэх, таслан зогсооход хүндрэлтэй, эх, хүүхэд хоёрын амь насанд эрсдэлтэй, жирэмсэн эсэхийг нь мэдэх боломжгүй, тээгч эх гэдгийг нотлоход хүндрэлтэй зэрэг олон хүндрэл бэрхшээл байдгийг алба хаагчид дурдсан байна. Хүүхэд тээлгэх зорилготой ХХГХ-ийг илрүүлэхэд учирч болох хүндрэл бэрхшээлийг “мэдэхгүй” гэж судалгаанд оролцогчдын тал хувь нь хариулсан байна</p> <ul style="list-style-type: none"> • ХХГХ-т өртөж буй хамгийн гол шалтгааныг дурдахдаа бусад бүлгүүдээс ялгаатай хариулт өгсөн нь анхаарал татсан юм. Гэр бүлийн таагүй орчин буюу эцэг эхийн таарамжгүй байдал, хойд 	<p>бол 88% (176) нь багш лекц уншдаг уламжлалт аргыг халахыг санал болгосон.</p> <p>Хохирогчдын 90% (18) нь тухайн газарт очиж, хүчээр биеэ үнэлэх нөхцөл, байдалд орсныхоо дараа л ХХГХ-ийн хохирогч болсноо мэдсэн байгаа нь хохирогчид мэдээлэл муутай, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа хангалтгүй байгаатай холбоотой гэж үзэж болохоор байна.</p> <p>Цагдаагийн байгууллагаас судалгаанд оролцогчдын 80% (160) нь шинээр боловсруулах гарын авлагад ХХГХ-ийг нотлох баримтыг цуглуулах, бэхжүүлэх ажиллагаа, энэ гэмт хэрэгтэй тэмцэх урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах, таслан зогсоох ажиллагаа, байгууллагуудын хамтын ажиллагааны талаарх мэдээлэл авах сургалтад хамрагдах хүсэлтэй байгаагаа илүүтэй</p>	<p>асуумж байдаг гэж 5 хүн буюу 9.9% нь хариулсан ба дэлгэрэнгүй лавлахад “хууль, прокурорын аргачилсан заавар байдаг”, “хохирогчтой уулзах, түүний сэтгэл зүйн байдалд тохируулан харилцаж мэдээлэл авдаг” гэсэн байна. • Хохирогчтой ажиллах тусгай журам заавар байдаггүй гэж 84.3% (43) нь үзсэн нь цаашид хууль хэрэгжүүлэгч байгууллагад хохирогчтой ажиллах заавар, стандарт, журмыг боловсруулах, алба хаагчдыг энэ чиглэлээр мэргэшүүлэх, үйл ажиллагаанд хэрэгжүүлэх хэрэгцээтэй байгааг харуулж байна.</p> <p>Прокурорын байгууллагад ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр мэргэшсэн албан тушаалтан бэлтгэх шаардлагатай гэж 92.2% (47) нь хариулснаас үзэхэд энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэхэд тусгай прокурор, илүү мэргэшсэн түвшинд ажиллах хэрэгцээ</p>	<p>таагүй харьцаа гаргаж байсан тухай өгүүлсэн байна. Ихэнхдээ тэднийг өөрсдийг нь буруутгах, хэргийг сунжруулах, олон дахин явуулахаас гадна гаднын өөр хүмүүсийн дэргэд байцаалт авдаг нь тэдэнд сөрөг сэтгэгдэл төрүүлж байсан байна.</p>
--	--	--	--	--

<p>мэдээлэл өгөхүйц иж бүрэн сургалтын гарын авлагыг боловсруулах зайлшгүй шаардлагатай байна. Шүүгчид Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарчмуудын хэрэгжилтийг үнэлэхэд нийт оролцогчдын 46.3% (17) нь “хангалтгүй” гэж үнэлсэн байна.</p> <p>холбогдох хуулийн хүрээнд ажилладаг гэж хариулсан нь онцгой, зохион байгуулалттай гэмт хэргийн хохирогчидтой ажиллах нэгдсэн зохицуулалт дутмаг байна гэж дүгнэж болохоор байна. Харин үйл ажиллагаанд хохирогчтой ажиллахдаа хэрэглэдэг стандарт, журмыг дурдахдаа “хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны журам”, “ЭХХШТХ”, “насанд хүрээгүй хохирогчоос тусгайлан мэдүүлэг авах журам”, “хууль, прокурорын аргачилсан заавар”, байдаг гэж хариулсан нь ХХГХ-ийн</p>	<p>эцэг, эх, гэр бүл салалт, гэр оронгүй амьдарч байгаа, гэр бүлийн хүчирхийлэл зэрэг нөхцөлүүдийг оролцогчдын 85% (17) нь дурдсан байгаагаас харвал ажилгүйдэл, ядуурлаас гадна гэр бүл рүү чиглэсэн үйл ажиллагаа дутмаг байгаатай холбоотой байна. Ажилгүйдэл (45%-9), ядуурал (40%-8) ХХГХ-т өртөх хоёр дахь болон гурав дахь хүчин зүйлс болсон байна. Гэр бүлийн таагүй байдлаас зугтаасан охид, эмэгтэйчүүд энэ гэмт хэрэгт өртөх эрсдэл өндөр байгааг энэхүү судалгааны дүн харуулж байна.</p> <p>Хохирогчид ХХГХ-ийн нөхцөл байдлаас аврагдах, зугтаж гарах нийтлэг арга зам, төгс жишээ байдаггүй гэдгийг 20 хохирогч тус бүр 14 өөр аргаар аврагдаж, зугтсанаас харж болно. Тэд боломжтой хугацааг байнга хүлээж, тооцож, судалж байдаг бөгөөд үүнд зөвхөн хохирогчийн тооцоолол, төлөвлөгөөнөөс гадна бусад хүчин зүйлүүд нөлөөлж биеллээ олдог гэж үзэж болно.</p> <p>Хохирогчдын 10 хүний 9 нь ТББ-аас дөрвөөс дээш төрлийн туслалцаа авсан нь ТББ-ын үзүүлж буй үйлчилгээ цогц байгааг харуулж байгаа хэдий ч санхүүгийн тогтворгүй байдлаас шалтгаалан хүн бүрд шаардлагатай үйлчилгээг тэгш хүргэж чадахгүй байна.</p> <p>Бүх хохирогчид эдийн засаг, сэтгэл санаа, эрүүл мэнд сэтгэлзүйн</p>	<p>илэрхийлсэн нь гарын авлагад</p> <p>руулах, сургалт зохион байгуулах чиглэлээр</p> <p>1. Мэргэшүүлэх гарын авлагыг боловсруулахдаа судалгаанд хамрагдсан алба хаагчдаас гаргасан саналыг тусгах, ялангуяа үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэргүүдтэй хамт үйлдэгдэж буй тохиолдлууд, хамаарлыг хэрхэн илрүүлж, мөрдөн шалгах талаар тусгах, 2017 оны шинэчилсэн Эрүүгийн болон ЭХХШТХ-ийн ХХГХ-тэй холбоотой зүйлчлэлийн хэрэгжилтээр хэлэлцүүлгийг зохион байгуулах, кейс судалгаа хийх, төсөөтэй хэргүүдийг хэрхэн зүйлчлэх талаар сургалтын гарын авлагад оруулах;</p> <p>Гарын авлагыг боловсруулахад хууль сахиулах, шүүгч, прокурор, хил хамгаалах, ГИХГ-ын</p>	<p>шаардлага байгааг харуулж байна.</p> <p>Прокурор нарын хувьд учирч буй бэрхшээлд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа олон үе шаттай болсон, прокурорын ажлын ачаалал ихэссэн, ХХГХ-ийн зүйл анги нь 2002 оны зохицуулалтаас дордсон, биеэ үнэлэх, зохион байгуулах явцад ашиг олж, хүнийг мөлжсөн бол хэрхэн шийдвэрлэх нь тодорхой бус, гэмт хэрэгт тооцохгүй, зөрчил гэж үзэх болсон зэрэг хүндрэлүүд байгааг онцлон илэрхийлж байлаа.</p> <p>Хохирогчдын 5 хүн тутмын 4 нь хуулийн аль нэг шатны байгууллагад гомдол гаргаж, эдгээр гомдлын 4 хэрэг тутмын 3-т шүүхээс гэмт буруутай этгээдүүдэд ял шийтгэл оногдуулсан байна. Энэ тооноос харвал ямар нэг байдлаар шүүхийн шат хүртлээ явсан хэрэг шийдвэрлэгдэх</p>
--	--	--	--

<p>хохилогчтой ажиллах тусгайлан техник, журам, стандарт гэж үзэж болохооргүй байна.</p> <p>2012 онд Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль батлагдан гарсан. Уг хууль батлагдаад даруй зургаа дахь жилийн нүүрийг үзэж байгаа бөгөөд хуулийн хэрэгжилтийг Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн найман зарчмын хүрээнд үнэлэхэд дотоодын хууль тогтоомжийн хэрэгжилт хангалттай, хангалттай сайн гэж нийт оролцогчдын 32.6% (118) нь, олон улсын стандарт, гэрээ конвенцийн хэрэгжилт 32% (116) хангалттай, сайн хэрэгждэг гэж үнэлсэн. Харин хохирогчийн нэр төрийг хүндэтгэх асуудал хангалтгүй гэж 72% (260), хохирогчийг үл буруутгах, хохирогчийн аюулгүй байдлыг хангах, хувийн нууцыг хамгаалах асуудал хангалттай бус гэж 62.6% (226) нь хариулснаас харахад</p>	<p>өвчлөл учирснаас гадна нэр төрөө алдаж, гэр бүлийн гишүүдийн зүгээс харьцах харьцаа нь өөрчлөгдөж, зарим ах дүүстэйгээ холбоогоо тасалсан. Мөн нэг тохиолдолд хар тамхи хүчээр хэрэглүүлж байснаас одоо хамаарлаасаа салж, эрүүл мэндээ эмчлүүлэх гэж асар их цаг, хөрөнгө мөнгө шаардлагатай болсон тухайгаа ярьсан нь хохирогчийг нөхөн сэргээх удаан хугацааны тогтвортой туслалцаа шаардлагатай байдгийг харуулж байна.</p> <p>ХХГХ-ийн хохирогчийг илрүүлэх, мөрдөн шалгах, нотлох, гэрч хохирогчийг хамгаалах тусгай тогтсон стандарт арга техник, журам, асуумжийг сайжруулах, боловсруулах, хэрэгжүүлэх;</p> <p>ХХГХ-ийн хохирогчийн хамгааллыг сайжруулах, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль (2014), Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012), ЭХ (2017), ЭХХШТХ-ийн (2017) нийцлийг хангаж, бодитоор хэрэгжүүлэх;</p> <p>“Хохирогчоос мэдүүлэг авах өрөө”-ний ашиглалтыг сайжруулах, зориулалтын дагуу тогтмол ашиглах, үйл ажиллагааны нэгдсэн стандарттай болох;</p> <p>Хохирогчийн хохирлыг нөхөн төлүүлэх тусгай сантай болох, учирсан хохирлыг тухайн хэрэг</p>	<p>албан хаагчдын төлөөллийг оролцуулах;</p> <p>Сургалтыг судалгаанд оролцогчдын хүсэж буй ялангуяа “бодит кейс дээр ажиллах”, “багаар ажиллах”, “оролцоонд суурилсан” арга зүй, аргачлалаар зохион байгуулах, мэргэжлийн мэргэшсэн сургагч багш нараар хичээл заалгах; 4. Боловсруулагдан гарсан гарын авлагаар салбар тус бүрд сургалт зохион байгуулах улмаар мэргэшсэн алба хаагчдыг бэлтгэх;</p> <p>Сургалтын чанар, үр дүнг хянах шалгуур үзүүлэлт бий болгох.</p>	<p>боломжтой гэж үзэж болохоор байна.</p> <p>Хохирогчдын хохирол барагдуулалт хангалтгүй, зарим тохиолдолд Иргэний хэрэг шүүхэд хянан шийдвэрлэх ажиллагааны журмаар гаргуулахаар шийдвэрлэдэг боловч амжилттай шийдвэрлүүлсэн тохиолдол байхгүй байгаа нь хүндрэл учруулдаг. Хохирогчид энэ гэмт хэргийн хохирлыг барагдуулж өгөх, хэт удаан хуулийн байгууллагаар явдаг процессыг халж өгөхийг хууль, хяналтын болон төрийн байгууллагуудаас хүсэж байна.</p> <p>мэргэшсэн ажилтнуудын тогтвортой байдлыг хангах асуудлыг чухалчлан тавьсан</p> <p>бүхий л салбарт ялангуяа алба хаагчид нь ХХГХ-ийн талаар нэгдсэн ойлголттой болох, илүү мэргэшин ажиллах, шаталсан</p>
--	--	--	---

<p>хуулийн хэрэгжилт хангалтгүй байна гэж үзэж болохоор байна.</p> <p>эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг сайжруулах, нэмэлтээр бусад улс оронтой байгуулах, тухайн гэрээг энэ төрлийн гэмт хэргийг илрүүлэхэд хэрхэн хэрэгжүүлэх талаарх онолын болон практик ойлголтыг өгөх асуудлыг гарын авлагад тусгахыг илэрхийлж байсан.</p> <p>Хохирогчид энэ гэмт хэргийн хохирлыг барагдуулж өгөх, хуулийн байгууллагын урт удаан процессыг халж өгөхийг хууль, хяналтын болон төрийн байгууллагуудаас хүсэж байлаа. Мөн хохирогчдод хуулийн байгууллагын ажилтнууд өөрсдийг нь буруутгах, байцаалт өгөхөөр хоёроос дээш удаа байнга давтан дуудах, байцаалт авахдаа олон хүмүүсийн дэргэд байцаадаг зэрэг нь тэдэнд сөрөг сэтгэгдэл төрүүлж, дахин хуулийн байгууллагад</p>	<p>шалгагдаж эхэлсэн цагаас эхлэн барагдуулж байх, гэмт хэрэгтнээс хураасан хөрөнгө, гэмт хэргийн нөхөн төлбөрөөс сандаа төвлөрүүлж ажиллах;</p> <p>ХХГХ-ийн хохирогчид туслалцаа үзүүлэх, хүндрэл чирэгдэлгүй төрийн цогц үйлчилгээг бий болгох, хэрэгжүүлэх;</p> <p>ХХГХ-ийн хохирогчдод туслалцаа, үйлчилгээ үзүүлдэг мэргэшсэн ТББ-ын үйл ажиллагааг төрөөс дэмжиж ажиллах, хуульд заасны дагуу гэрээгээр зарим чиг үүргийг гүйцэтгүүлж, хохирогчдод зориулсан үйлчилгээг санхүүжүүлж, үйл ажиллагааны тогтвортой байдлыг хангах, ажиллагсдын аюулгүй байдлын хамгаалалт зэрэгт анхаарлаа хандуулах.</p>		<p>сургалтуудад хамрагдах, байгууллагын хоорондын үйл ажиллагааг сайжруулах болон хохирогч төвтэй ажиллах олон улсын туршлага судлахыг хүсэж байгаа 99 ба тэдэнд бодитоор бий болсон хэрэгцээ, шаардлага байна гэж дүгнэгдэж байна.</p> <p>ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр бусад орны сайн туршлагаас суралцах, судлах; 2. Хилийн чанадад үйлдэгдсэн гэмт хэргийн нотлох баримтыг бэхжүүлэх, цуглуулах үйл ажиллагаанд холбогдох байгууллагуудтай хамтран ажиллах; 3. Гадаад улс орны туршлагыг судлах, сайн туршлагыг нэвтрүүлэх, түүнчлэн алба хаагчдыг мэргэшүүлэн сургах чиглэлээр хамтын ажиллагааг өргөжүүлэх.</p>	
---	--	--	--	--

<p>хандах сонирхолгүй болгодог талаар илэрхийлж байсан.</p> <p>2017 онд шинэчилсэн ЭХ, ЭХХШТХ хэрэгжиж эхлээд удаагүй ч бэрхшээлүүд учирч эхэлсэн байна гэж хууль сахиулах, шүүх эрх мэдлийн байгууллагууд үзсэн байна. Учир нь тэдний хувьд хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа олон үе шаттай болсон, прокурорын ажлын ачаалал ихэссэн, ХХГХийн зүйл анги нь 2002 оны зохицуулалтаас дордсон, биеэ үнэлэх, зохион байгуулах явцад ашиг олж, хүнийг мөлжсөн бол хэрхэн шийдвэрлэх нь тодорхой бус, гэмт хэрэгт тооцохгүй, зөрчил гэж үзэх болсон зэрэг хүндрэлүүдийг онцлон илэрхийлж байсныг анхааралдаа авч, эрх зүйн орчны өнөөгийн нөхцөл байдлын судалгааг хийх улмаар, холбогдох хууль тогтоомжийг засан сайжруулах хэрэгцээ шаардлага бий</p>				
--	--	--	--	--

<p>болсныг харуулж байлаа.</p> <p>2012 онд батлагдсан “Хүн худалдаалахтай тэмцэх тухай” хуулийг 2017 онд шинэчлэн батлагдсан хууль тогтоомжтой нийцүүлэх, сайжруулах, боловсронгуй болгох;</p> <p>Үндэстэн дамнасан, зохион байгуулалттай гэмт хэрэг, ялангуяа ХХГХ-тэй тэмцэхийн тулд гадаад улс оронтой эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээг байгуулах, сайжруулах;</p> <p>ХХГХ-ийн хэргийг мөрдөн шалгах, хянах, шийдвэрлэх хугацааг богиносгох, хохирогчид дахин түвэг, чирэгдэл үүсгэхээс хамгаалах, урьдчилан сэргийлэх;</p> <p>Байгууллага тус бүр алба хаагчдад зориулсан сургалтын төлөвлөгөөндөө ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, мөрдөн шалгах талаар тусгах</p>				
--	--	--	--	--

<p>2 Хууль зүйн дүн шинжилгээ – Жэндерт суурилсан хүчирхийлтэй холбоотой эрүүгийн хэрэг, Хүйсийн тэгш эрх төв, Азийн Эмэгтэйчүүдийн Сан, 2018</p> <p>Санхүүжүүлэгч: Азийн эмэгтэйчүүдийн сан (WFA)</p>					
<p>3 Биеэ үнэлэлт болон бэлгийн мөлжлөгт өртөх эрсдэл, суурь судалгаа, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яам, Хүйсийн тэгш эрхийн төв, Эмэгтэйчүүдийн хүний эрхийн хүрээлэн, 2019</p> <p>Санхүүжүүлэгч: БНСУ-ын Гэр бүл жөндөрийн тэгш эрхийн яам (MOGEF)</p>	<p>Бэлгийн хүчирхийллийн хэргийг таслан зогсоох, шийтгэх, хохирогчдыг нэн даруй нөхөн сэргээхэд холбогдох эрх зүйн орчинг боловсронгуй болгох, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх хэрэгтэй байна.</p>	<p>Төрөөс хохирогчдод зориулсан нийгмийн ажлын цогц үйлчилгээг сайжруулах, энэ чиглэлээр ажиллаж буй байгууллагуудад санхүүжилт төсвөөс хуваарилан олгох, хохирогч, гэрч хамгааллын тогтолцоог боловсронгуй болгох шаардлагатай байна.</p>	<p>Судалгаанд хамрагдагчид энэ гэмт хэргээс урьдчилан сэргийлэх талаар олон нийтэд зориулсан мэдээлэл, нэвтрүүлэг, хэвлэл мэдээллийн хэрэгслээр хангалттай гардаггүй гэсэн бол энэ чиглэлээр ажилладаг ажиллагаанд хамрагдах замаар мэдээлэл ойлголт авдаг гэжээ. Цаашид төрийн болон төрийн бус байгууллагууд хамтран олон нийтэд хэвлэл мэдээллийн хэрэгслээр дамжуулан бодит мэдээлэл өгөх үйл ажиллагааг тогтвортой явуулах хэрэгтэй. Гэхдээ мэдээллийн агуулга</p>		

			<p>олон нийтэд айдас төрүүлэхээсээ илүү мэдлэг олгоход чиглэсэн байвал илүү үр дүнтэй байх болно гэж санал бодлоо илэрхийллээ</p> <p>Олон нийтэд болон хохирогчдод мэдээлэл, зөвлөгөө өгдөг цэгүүдийг эрсдэл өндөртэй орон нутагт байгуулах;</p> <ul style="list-style-type: none">• Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй төрийн болон төрийн бус байгууллагууд энэ асуудлаар хамтран ажиллах;• Хэвлэл мэдээллийн хэрэгслээр тогтвортой мэдээлэл, ойлголт өгөхөд чиглэсэн ярилцлага, нэвтрүүлэг, шторк цацах;• ЕБС, их, дээд сургууль, МСҮТ-д суралцагчдад тогтмол мэдээлэл өгөх үйл ажиллагаа зохион байгуулах;• Энэ чиглэлээр ажилладаг мэргэжилтнүүдийг тогтвор суурьшилтай ажиллуулж, чадавхижуулах;		
--	--	--	---	--	--

			<ul style="list-style-type: none"> • Алслагдсан сум, баг, гэр хорооллын иргэдийн дунд хүрч очин явууллын мэдээлэл өгөх үйлчилгээг нэвтрүүлэх, энэ чиглэлээр ажиллах ажилтнуудыг бэлтгэх, чадавхижуулах; • Олон нийтэд сургалт, сурталчилгаа байнга зохион байгуулж мэдлэг боловсрол олгож байх; • Биеэ үнэлэгчид болон худалдан авагчдад хуулийн хариуцлага тооцох гэх мэтээр урьдчилан сэргийлэх болон хамгаалах үйл ажиллагааг өргөн хүрээнд явуулах хэрэгтэй байна. Урьдчилан сэргийлэх чиглэлээр эрсдэлт бүлгийнхэнд чиглэсэн сургалт хийх; • Хилээр гарахаас өмнө эрсдэлт бүлгийг мэдээллээр хангах, ярилцлага хийх; • Тодорхой цэгүүдэд компанит ажлыг тогтмол зохион байгуулах; 		
--	--	--	---	--	--

			<ul style="list-style-type: none"> • Хэвлэл мэдээллийн хэрэгслээр энэ гэмт хэргийн талаар ойлголт, мэдээлэл өгөхөд чиглэсэн ярилцлага, нэвтрүүлэг, шторк цацах; • Эрэгтэйчүүдэд мэдээлэл өгөх, ялангуяа хилийн бүс орчимд байгаа хүн болон бараа тээвэрлэж буй жолооч нарт чиглэсэн үйл ажиллагаа; • Үйлчилгээ авахаар ирж буй хохирогчтой ажиллах ажилтнуудыг чадавхижуулах; • Хамгийн гол нь тухайн орон нутагт хийгдэж буй урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа тогтвортой байх хэрэгтэй гэсэн байна 			
4	“Олон улсын Хөдөлмөрийн байгууллагын “Албадан хөдөлмөрийн тухай” 29 дүгээр протоколд Монгол Улс нэгдэн орсноор гарах үр дагавар хэрэгцээ шаардлагын судалгаа, Монголын Хуульчдын холбооны	Хөдөлмөрийн тухай хууль (1999)-ийн 3 дугаар зүйлийн 3.1.14 дэх заалтад заасан “албадан хөдөлмөр”-ийн тодорхойлолт болон шинэчлэн найруулсан Эрүүгийн хуулийн 13 дугаар зүйлийн 13.13 дэх “албадан хөдөлмөрлүүлэх” гэмт хэргийн бүрэлдэхүүнийг тогтоосон	Албадан хөдөлмөрийн хохирогчийг илрүүлэх, олж тогтооход үнэ төлбөргүй, мэдээлэгчийг нууцалсан тусгай утас, мэдээлэл авах сувгийг 24 цагийн турш авдаг цахим орчныг бий болгох нь чухал. Үүнийг цагдаа, мэргэжлийн хяналтын байгууллага, ТББ-ын тусламжтайгаар хэрэгжүүлж, иргэдэд зөвлөгөө, мэдээлэл өгөх, туслалцаа, дэмжлэг үзүүлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж болох юм.	Албадан хөдөлмөрийн талаарх олон нийтийн ойлголт сул, энэ асуудлаар ажиллах төрийн албан хаагчдын, тэр дундаа хууль сахиулах болон шүүх, прокурорын байгууллагын алба хаагчид, хуульч, өмгөөлөгчдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэхэд чигэлсэн системтэй сургалт, хөтөлбөрийг	Иргэний хууль (2002), Иргэний хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хууль (2002)-иар хууль бус аливаа үйлдэл, эс үйлдэхүйн улмаас учирсан хохирлыг нэхэмжлэх материаллаг болон процессын эрх зүйн орчин бүрдсэн ч хэрэгжилт муу байгаа тул практик тогтоох үүнд төрийн болон	Хүн худалдаалахтай тэмцэх үндэсний хөтөлбөр (2017)-т болон бусад холбогдох эрх зүйн актуудад нэмэлтээр - хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалахтай, албадан хөдөлмөртэй тэмцэх тодорхой, системтэй, цогц арга хэмжээг тусгах,

<p>Хөдөлмөрийн эрх зүйн дэд хороо, Олон улсын хөдөлмөрийн байгууллага (ILO) 2019</p> <p>Санхүүжүүлэгч: Европын холбоо (EU)</p>	<p>зохицуулалтыг тус тус албадан хөдөлмөрийн тухай 29 дүгээр конвенцтэй бүрэн нийцүүлэх шаардлагатай. Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлийг: “Тухайн хүн өөрөө сайн дураараа эсхүл сайн дурын үндсэн дээр гэдгээ илэрхийлээгүй тохиолдолд аливаа торгууль, шийтгэл, хүлээлгэх, хуурах, айлгах, сүрдүүлэх, зүй бусаар нөлөөлөх эсхүл хүч хэрэглэх байдлаар аливаа ажил, үйлчилгээг гүйцэтгүүлсэн бол ... “ гэх байдлаар өөрчлөхийг зөвлөж байна.</p> <p>2. Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэгт хүндрүүлэх нөхцөл байдлыг нэмж оруулах буюу гэмт хэргийг удаа дараа, удаан хугацаагаар, зохион байгуулалттайгаар, жирэмсэн эмэгтэй, хүүхэд, хөгжлийн бэрхшээлтэй, эрх зүйн бүрэн чадамжгүй хүнийг албадан хөдөлмөрлүүлэх зэрэг хэлбэрээр үйлдсэн</p>	<p>Үүнээс гадна хөдөлмөрийн хяналтын байцаагчаас гэнэтийн шалгалт хийх эрх зүйн орчин болон бусад холбогдох зохицуулалтыг бүрдүүлсэн Хөдөлмөрийн хяналтын тухай (Худалдаа, аж үйлдвэр) 81 дүгээр конвенц, Хөдөлмөрийн хяналтын (Хөдөө аж ахуй) тухай 129 дүгээр конвенцид нэгдэн орох нь хяналтын механизмыг бэхжүүлэх, чанарын түвшин ахиулахад чухал нөлөөлтэй байна.</p> <p>Хүн худалдаалах, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн хохирогч бусдын эрхшээлд албадан хөдөлмөр эрхлэх үйлдлээрээ хууль бус үйл ажиллагаанд оролцсонд нь буруутгахгүй байх хууль эрх зүйн орчныг бүрдүүлэх нь зайлшгүй чухал байна. Жишээ нь Хүн худалдаалахтай тэмцэх тухай хууль (2012)-ийн 11 дүгээр зүйлийн 11.1-д “... оршин суух, хөдөлмөр эрхлэх, цагаачлах журам зөрчсөн гэсэн үндэслэлээр албадан гаргах арга хэмжээ авахыг хориглоно” гэж өөрчлөх замаар илүү тодорхой зохицуулах боломжтой гэж үзэж байна. Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (2010)-ийн 37 дугаар зүйлийн 37.1.7-г “Албадан хөдөлмөрлүүлэх, хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч болсноос бусад тохиолдолд эрх бүхий байгууллагын зөвшөөрөлгүйгээр хөдөлмөр эрхэлсэн, ...” нэмж өөрчилснөөр хохирогчийг буруутгах болон албадан гаргахаас хамгаалж, буруутай</p>	<p>нэвтрүүлэх, мэргэшсэн төрийн албан хаагчийг тогтвортой ажиллуулахад анхаарах шаардлагатай.</p> <p>Албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг огт бүртгэгдээгүй, МХЕГ-т энэ төрлийн гэмт хэрэг байж болзошгүй тохиолдол ч илрээгүй байгаа нь ойлголт, мэдлэг дутмаг байгаатай холбоотой тул 37 эрсдэлт бүлэгт, тухайлбал албан бус секторт ажиллагсад, малчид, хүүхдүүдэд хандсан энгийн ойлгомжтой үзүүлэн таниулах мэдээллийг боловсруулан, тэдгээрийг анхан шатны нэгжид ажиллаж буй баг, хорооны нийгмийн ажилтан, засаг дарга, сургуулийн багш, нийгмийн ажилтан, эмч, хүүхдийн сэтгэл зүйч, хэсгийн байцаагч, цагдаа, Элчин сайдын яам, Консулын газрын ажилтнуудаар дамжуулан хүргэн ажиллах нь үр дүнтэй. Иймд эдгээр</p>	<p>хууль хяналт, шүүх эрх мэдлийн байгууллага албан хаагчид, хуульчдыг сургах, чадварыг нэмэгдүүлэх, хохирлоо барагдуулахаад гомдол гаргах боломжийн талаар олон нийтэд энгийн ойлгомжтой байдлаар байнга хүргэх, сурталчлах шаардлагатай.</p> <p>Шинэчлэн найруулсан Эрүүгийн хууль (2015)-д эрүүгийн хэргийг шийдвэрлэхэд хохирлыг хамтад нь шийдвэрлэх буюу гэмт хэрэгтний хөрөнгө, орлогоос албадан гаргуулж хохирлыг нөхөн төлүүлэх зэрэг зохицуулалтыг хэрэгжүүлдэг механизмыг бэхжүүлэх, боловсронгуй болгох шаардлагатай. Засгийн газрын тусгай сангийн тухай хууль дахь зөвхөн эмчилгээний зардлыг нөхөн төлөх зохицуулалтыг өргөжүүлэн хүн худалдаалах гэмт хэргийн улмаас учирсан хохирол</p>	<p>ХХГХУСДЗ-ийн чиг үүрэгт албадан хөдөлмөрлүүлэхтэй тэмцэх чиг үүргийг нэмэх эсхүл ХНХЯ нь энэхүү чиг үүргийг хариуцан ажиллахаар хөтөлбөрт тусгах нь чухал байна.</p> <p>Үндэсний бодлого, хөтөлбөр, үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжүүлэхдээ ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллага болон бусад ТББ-ууд, ялангуяа хүн худалдаалахтай тэмцэх чиглэлд ажиллаж буй ТББ-уудын саналыг авах, тусгах, тэдгээрийн үйл ажиллагааны төлөвлөгөөтэй уялдуулах, үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг зохион байгуулахад татан оролцуулах, чадавхийг нь бэхжүүлэх чиглэлд дэмжлэг үзүүлэх шаардлагатай</p> <p>Албадан хөдөлмөрлүүлэхтэй тэмцэх, урьдчилан</p>
--	---	--	--	--	---

	<p>тохиолдол илүү хүнд ял шийтгэх нь зүйтэй. Албадан хөдөлмөрлүүлэх болон хүн худалдаалах гэмт хэргийн ялыг чангатгах шаардлагатай.</p> <p>3. Хөдөлмөрийн тухай хуульд заасан албадан хөдөлмөрлүүлэхийг хориглосон заалтыг зөрчсөн тохиолдол нь гэмт хэрэгт хараахан тооцогдохгүй бол хүлээх захиргааны хариуцлага нь тодорхойгүй байгааг тодорхой болгох шаардлагатай. Хөдөлмөрийн хөлс олгоогүй эсхүл дутуу олгосон, бичиг баримтыг нь барьцаалсан, ажлаа орхиж явах эрхийг хязгаарласан гэх мэт үйлдэл, эс үйлдэхүйд захиргааны хариуцлагыг хүлээлгэх асуудлыг Зөрчлийн тухай хуулиар шийдвэрлэж болох юм.</p> <p>4. Хүн худалдаалах гэмт хэрэгт шалгагдаж буй этгээдэд хорих, гадаадад зорчих эрхийг хязгаарлах зэрэг таслан сэргийлэх арга хэмжээг нэн даруй авч дахин гэмт</p>	<p>этгээдийг шийтгэх боломжийг бүрдүүлнэ.</p> <p>Эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хууль (2015) дахь хохирогчоор тооцож эхлэх заалт нь Хүн худалдаалахтай тэмцэх хууль (2012)-ийн заалттай нийцэхгүй байгаа тул Эрүүгийн хэрэг шүүхээр хянан шийдвэрлэх тухай хууль (2015)-д зохих өөрчлөлт оруулж, хэрэгжилтийг хангах шаардлагатай</p>	<p>ажилтнуудыг албадан хөдөлмөрийн тохиолдлыг хэрхэн таних, МХЕГ, хуулийн байгууллагад гомдол, мэдээлэл гаргах, хохирогчийг хамгаалах байгууллагад мэдээлэх, хохирогчийг хамгаалах, буруутай этгээдийг таслан зогсоох талаар анхан шатны арга хэмжээг авах, харилцан мэдээлэх, хамтран ажиллахад сургаж, эдгээр албадан хөдөлмөрийн тохиолдлыг илрүүлэх анхан шатны нэгжүүдийг хамтран ажиллах журмыг Засгийн газраас шинээр батлан гаргаж, хэрэгжүүлэхэд дэмжлэг тусламж авч, журмын хэрэгжилтийг олон нийтэд нээлттэй тайлагнаж ажиллахаар зохион байгуулах нь үр дүнтэй байхаар байна.</p> <p>Монгол Улс дахь албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэрэг, хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалах гэмт хэргийн нөхцөл</p>	<p>болох цалин хөлс, сэтгэл санааны хохирлыг нөхөн төлүүлэх боломжийг судлан шийдвэрлэх нь шаардлагатай байна.</p>	<p>сэргийлэх, хохирогчийг хамгаалах талаар аливаа эрх зүйн акт, бодлого хөтөлбөр боловсруулахад ажил олгогч, ажилтны төлөөллийн байгууллага, холбогдох төрийн бус байгууллагын саналыг авах практикыг бий болгох, хөтөлбөр, бодлогод энэ талаар тусгах шаардлагатай.</p> <p>Түүнчлэн албан бус эдийн засагт ажиллагчид нь эрхээ хамгаалах, Үйлдвэрчний эвлэлийг байгуулахад Монголын Үйлдвэрчний Эвлэлийн Холбооноос хүчин чармайлт гаргах шаардлагатай. Ялангуяа албан бус хөдөлмөр эрхлэгчдийг хамгаалах тэдгээрийг албадан хөдөлмөрийн хохирогч болохоос сэргийлэхэд Төрийн бус байгууллагуудыг идэвхижүүлэх, дэмжин ажиллах шаардлагатай.</p>
--	--	--	--	--	---

	<p>хэрэг үйлдэхээс сэргийлэх шаардлагатай. Гадаад харилцааны яам (ГХЯ), Консулын газар, Мэргэжлийн Хяналтын Ерөнхий Газар (МХЕГ) зэрэг хууль хяналтын байгууллагын нэгдсэн сүлжээ, харилцан мэдээлэл солилцдог, хамтран ажилладаг механизмыг бий болгож, үр дүнтэй ажиллах эрх зүйн орчин, санхүү, хүний нөөцийн асуудлыг шийдвэрлэх шаардлагатай.</p>		<p>байдал, шалтгаан, үр дагавар, хэрэгжүүлж буй арга хэмжээг багтаасан тайланг жил бүр монгол, англи хэл дээр дотоод, гадаадад нээлттэй танилцаж болохоор гаргах нь урьдчилан сэргийлэх төдийгүй хэрэгжүүлж буй арга хэмжээг эргэн хянаж байхад тустай. Тайлангийн үндсэн загвар, тоо баримтыг гаргах, хийж буй ажлыг үнэлэн дүгнэх арга зүй зэрэгт олон улсын жишиг хандлагыг судлан, олон улсын байгууллагын зөвлөгөө, тусалцааг энэ чиглэлд авч хэрэгжүүлж болох юм.</p>	<p>Монголын Ажил Олгогч Эздийн Нэгдсэн Холбоо, Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхим зэрэг эзэд, бизнесийн төлөөллийн байгууллагаар дамжуулан жижиг дунд бизнес эрхлэгч, ажил олгогч хувь хүн, хувиараа хөдөлмөр эрхлэгч улмаар нийт ажил олгогчийг албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийн талаар сургалтад хамруулах, энэ талын мэдээлийг өгөх ажлыг зохион байгуулах, албан бус секторын ажил олгогч, хувиараа хөдөлмөр эрхлэгчийн нэгдсэн бүртгэлийг бий болгох, тэднийг чадавхижуулах чиглэлд ажиллах шаардлагатай. Ажил олгогч малчид буюу хөлсний малчдад мэдээлэл хүргэх, албадан хөдөлмөрийн талаар зөв ойлголт мэдээлэл өгч, хамтран ажиллахад тусгайлан төрөөс дэмжлэг үзүүлэх нь чухал байна.</p>
--	--	--	---	---

					<p>Монгол Улсад 3 хүн тутмын 1 ядуу, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээ нь амьжиргаанд хүрэлцэхгүй байгаа тохиолдолд хууль бусаар ажиллахаар гадаад улсыг зорих монголчуудын тоо буурахгүй нь тодорхой байгаа тул монгол иргэд олноор хөдөлмөр эрхэлдэг гадаадын улстай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ, хэлэлцээр байгуулах, түүнд албадан хөдөлмөрлүүлэх болон хөдөлмөрийн мөлжлөгийн зорилгоор хүн худалдаалахтай тэмцэх, хохирогчийг хамгаалах, нөхөн төлбөр, хохирлыг барагдуулахад хамтран шуурхай арга хэмжээг авах талаар тодорхой зохицуулалт оруулах зэргээр хамтран ажиллах нь чухал байна.</p>
5	“Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн үр	Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тухай хуульд нэмэлт, өөрчлөлтийг оруулахын зэрэгцээ	Хохирогчид нөхөн төлбөр олгох асуудлыг хуульчилсан хуулиудад заасан хохирогч хүнд гэмтэл, амь насаа алдсанаас бусад тохиолдолд нөхөн төлбөр авах	ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх, таслан зогсоох, хохирогчийг хамгаалах,	

<p>дагаврын үнэлгээ, 2017, ОУШХБ</p> <p>Санхүүжүүлэгч: Европын холбоо</p>	<p>холбогдох бусад хууль хоорондын зөрчилдөөнийг арилгах. Энэ хүрээнд хохирогчийг хамгаалах, дэмжлэг үзүүлэх чиглэлээр Эрүүгийн эрх зүйн шинэчлэлийн хүрээнд бусад хуулийн зохицуулалтаар давхар хангагдах боломжийг бүрдүүлэх, журмуудыг бүрэн батлах, нийгмийн халамж, эрүүл мэндийн үйлчилгээтэй холбоотой хуулиудад нэмэлт, өөрчлөлт оруулах;</p> <p>2. ХХГХ-тэй тэмцэхэд мэргэшсэн мөрдөн байцаагч, прокурор, шүүгч ажиллуулахад анхаарах; 3. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Дэд зөвлөл нь жил тутам ХХГХийн нөхцөл байдлын талаар илтгэл гаргаж байх засгийн газар, УИХ-аар хэлэлцүүлж, цаашид хэрэгжилтийг сайжруулах чиглэлд зөвлөмж гаргуулах;</p> <p>4. Гадаад улсуудтай байгуулсан гэрээ, хэлэлцээрийг дүгнэн нөхцөл байдлыг зөв тодорхойлж цаашид хамтран ажиллах</p>	<p>боломжгүй байдлыг өөрчилж, сэтгэл санааны дарамт, өөрчлөлтөд орох, бэлгийн замын халдварт өвчин халдах, ажил хөдөлмөрөө хэвийн үргэлжүүлэх боломжгүй болох, гэрлэлтээ цуцлуулахад хүрэх, сургуульд сурах зэрэг боломжоо алдсан гэх мэт нөхцөлийг хамруулан өргөжүүлж, улмаар шүүхийн шийдвэр гарсан тохиолдолд бус ХХГХ-ийн хохирогчоор тогтоогдсон үеэс буюу мөрдөн байцаалтын шатнаас авах боломжтой болгон хуульчлах; Төрөөс ХХГХ-ийн хохирогчийг хамгаалах байр байгуулах, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх нэгдсэн стандартыг хэрэгжүүлэхэд анхаарах; ХХГХ-тэй тэмцэх тухай хууль, Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулиудыг даган гарсан журмуудын хэрэгжилтийг дүгнэх, тус журмуудын хэрэгжилт болон санхүүжилтийн тайланг гаргаж, олон нийтэд мэдээлэх.</p>	<p>хүчирхийлэл үйлдэгчдэд хариуцлага хүлээлгэх үүрэг хүлээсэн байгууллагуудын дунд мэдээллийн нэгдсэн сүлжээг бий болгож, мэдээлэл, дүн шинжилгээнд үндэслэн шийдвэр гаргах боломжийг бүрдүүлэх;</p> <p>2. ХХГХ-тэй тэмцэх Үндэсний хөтөлбөрийн хэрэгжилтийг хангах ажлыг бодитой төлөвлөн тусгах. Арга хэмжээг хэрэгжүүлэх зардлыг улсын болон орон нутгийн төсөвт суулгах;</p> <p>3. Хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрээр үйлдэгдэх ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, илрүүлэх чиглэлд анхаарал хандуулж, тусгай арга хэмжээ авах;</p> <p>4. ХХГХ-ийн улмаас аюул занал тулгарсан хохирогчдыг байрлуулах зорилго бүхий хамгаалах байруудын үйлчилгээ үзүүлэхтэй холбогдсон зардлыг Нийгмийн халамжийн</p>		
---	---	--	---	--	--

	<p>гарцаа тогтмол шинэчилэх, Монгол Улсын иргэд ихээр зорчих болсон, мөн хил дамжуулан худалдаалах гэмт хэрэг ихээр гардаг Малайз, Сингапур, Хонконг, Тайланд, Филиппин, Макао зэрэг улс орнуудтай эрх зүйн харилцан туслалцаа үзүүлэх гэрээ байгуулах талаар Засгийн газар санаачлага гарган ажиллах;</p> <p>5. Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх Дэд зөвлөл нь НҮБ-ын зөвлөмжүүд болон ОУ-ын тайлан, илтгэлүүдийн зөвлөмжид заасан хүн худалдаалахтай тэмцэх чиглэлийн арга хэмжээний төлөвлөгөөний бодит хэрэгжилтэд анхаарч, салбар хоорондын уялдааг хангах, зохион байгуулалтыг хангаж ажиллах</p>		<p>сангаас тусгайлан санхүүжүүлэх;</p> <p>5. Хуулиар үүрэг хүлээсэн хуульчдыг бэлтгэх, давтан сургах хөтөлбөрт хүн худалдаалах гэмт хэргийг хэргийг шийдвэрлэх мэдлэг олгох агуулга оруулах. Хуульчдыг бэлтгэх сургалтын хөтөлбөрийг дан ганц энэ төрлийн гэмт хэргийг хэрхэн зүйлчлэхэд бус хохирогчийг таньж мэдэх, тэдний онцлогийг ойлгох, хуульд заасан үйлчилгээ дэмжлэгтэй холбох чадварыг олгоход анхаарах;</p> <p>6. Мэдээлэл авч чадахгүй хүн амын бүлэг буюу ядуу, орлого багатай болон орон нутгаас шилжин суурьшигчид, бичиг үсэг тайлагдаагүй болон хүүхэд, залуучуудад зориулагдсан урвдчилан сэргийлэх үйл ажиллагааг төрөлжүүлэн зохион байгуулах, арга хэмжээг тогтмолжуулах;</p>		
<p>6 ДХИС “Монгол Улс дахь хүн худалдаалах гэмт</p>					

<p>хэргийн төлөв байдал, чиг хандлага” судалгаа, 2020</p>					
<p>7 "Цахим орчин дахь хүүхдийн эсрэг гэмт явдлын шалтгаан, нөхцөл, урьдчилан сэргийлэх арга зам” судалгаа, ЭмЭмСиЖи, 2020</p> <p>Санхүүжүүлэгч: Харилцаа холбооны зохицуулах хороо</p>	<p>Монгол улсын хүчин төгөлдөр мөрдөгдөж буй эрх зүйн баримт бичигт дүн шинжилгээ хийж, цахим орчинд хүүхэд хамгаалах талаар шаардлагатай нэмэлт, өөрчлөлтийг оруулах. о Цахим орчинд үйлдэгдэж буй гэмт хэргийн нэр томъёог олон нийтэд ойлгомжтой болгох, Монгол хэлэнд хөрвүүлэх. о Интернэтийн үйлчилгээ үзүүлэгч хуулийн этгээдийн шүүлтүүрийн программ, эцэг эхийн хянах хэрэгсэл (parental control) программыг заавал ашигладаг байх нөхцөлийг бүрдүүлэх. Энэ талаарх мэдээллийг эцэг эхчүүдэд хүргэдэг байх. о Хүүхдийн цахим орчны зохистой хэрэглээ, дэлгэцийн өмнө өнгөрүүлэх цагийн хязгаарыг хүүхдийн насны ангилалд тулгуурлан боловсруулж, стандарт гаргах. Олон улсын цахилгаан холбооны</p>		<p>Эцэг, эхийн оролцоог нэмэгдүүлэх. Эцэг, эхчүүд өөрсдийн интернэтийн хэрэглээндээ цензур тавьж, хүүхдэдээ үлгэр дуурайл үзүүлэх соёлыг эзэмшиж, хүүхэдтэйгээ өнгөрүүлэх цагаа уртасгах нь цахим донтолтоос сэргийлж, хүүхдээ эрсдэлд өртөхөөс хамгаалах эхний алхам байхаар байна. Дараах чиглэлээр мэдлэгийг олгох нь зүйтэй. о Сүүлийн жилүүдэд монголчуудын гадаадад ажиллаж, амьдрах хандлага нэмэгдэхийн хэрээр өвөө, эмээгийн хяналтад байдаг хүүхэд олширсон. Энэ нь хараа хяналтгүй цахим хэрэглээ, түүнээс үүдсэн донтолтыг нэмэгдүүлж байна. Тэгэхээр ах, эгч, эмээ, өвөө нарын оролцоог нэмэгдүүлж, мэдлэг олгох. о Эцэг эхийн эзгүйд хяналтгүй интернэт ашиглах хандлага өндөр байна. Нөгөө</p>		<p>Багш, сурган хүмүүжүүлэгчийн оролцоог нэмэгдүүлэх. Цахим орчноос өсвөр насныхныг хамгаалах үр дүнтэй аргуудын нэг нь сургуулийн орчинд хамгаалалтыг хийх явдал юм. Энэ хүрээнд дараах ажлуудыг хийж болно. Үүнд: о ЕБС-ийн сургуулийн иргэний боловсрол, эрүүл мэнд гэх мэт хичээлүүдэд цахим эрсдэлээс хамгаалах чиглэлийн агуулга оруулж өгөх. о Багшийн хувьд цахим орчны талаар сурагчдаасаа давах мэдлэгтэй байх нь эргэлзээтэй. Тиймээс багш, сурган хүмүүжүүлэгч нарын цахим орчин дахь хүүхэд хамгааллын талаарх мэддэг, энэ чиглэлийн мэдлэгийг хүүхдүүдэд заах чадвар, олгох анхаарах. о ЕБС бүрд цахим орчинд хүүхэд эрсдэлд өртөхөөс урьдчилан</p>

<p>байгууллага (ITU) нь хүүхдийг насны ангиллаар хувааж, 0-4 насны хүүхдэд цахим хэрэглээг хориглох, 5-10 насны хүүхдэд өдөрт 1 цагаас бага, 11-18 насны хүүхдэд өдөрт 2-оос бага цагийг дэлгэцийн өмнө өнгөрүүлэх стандартыг гаргасан.</p> <p>Интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниудын оролцоог нэмэгдүүлэх. Цахим гэмт хэрэгтэй тэмцэх ажилд интернэтийн үйлчилгээ үзүүлэгч компаниудын оролцоо чухал. Юнивишн, Скаймедиа гэх мэт мэдээлэл технологийн компаниуд +18 контентыг хязгаарлаж чаддаг байх хэрэгтэй. Жишээ нь, кино багцуудаас эротик киног хүүхдүүдэд үзэж болдоггүй байх. Хэрэв үзэх шаардлагатай бол баталгаажуулалт заавал хийдэг болох. Мөн эцэг, эхчүүдэд parental control-ийн хяналтыг ашиглахыг зөвлөдөг байх нь чухал байна. о Гар утасны оператор компанийн дугаарын бүртгэлийг сайжруулах. Үнэгүй</p>		<p>талаас эцэг, эхчүүд хяналтын арга техникийг ашигладаггүй болох нь судалгаагаар гарсан. Тиймээс эцэг, эхчүүдэд болон олон нийтэд чиглэсэн удирдамж, зөвлөмжийг бэлтгэн хүргэх. о Эцэг, эхчүүдийн үүрэг оролцоо маш чухал гэж үзэж байгаа боловч бодит байдал дээр эцэг, эхчүүд энэ үүргээ гүйцэт биелүүлэхгүй байгаа нь ажиглагдсан. Тиймээс эцэг эхчүүд өөрсдөө хүүхдэдээ үлгэрлэл үзүүлж орон цагаар хүүхэдтэйгээ хамт байхдаа сошиал медиа ашиглахгүй байх, тэдэнтэй найз нь мэт ярилцах, өөрсдийнхөө хэрэгцээнд тохирсон гэрийн дүрэм зохиож, дагаж мөрдөх дадлыг бий болгох. Жишээ нь, өдөрт гурваас илүү цаг интернэт ашиглахгүй. Ашиглахдаа алаан хядаантай тоглоом тоглохгүй, насныхаа хязгаараас давсан зүйлийг үзэхгүй зэргийг ойлгуулах. о 13 нас хүрээгүй</p>	<p>сэргийлэх, энэ чиглэлийн мэдлэг мэдээллээр хангаж, цахим орчны аюулгүй хэрэглээний талаар сурталчилдаг “Хүүхэд хамгааллын баг”-тай болгох. о Эцэг эхчүүдэд хандан цахим орчинд хүүхдээ эрсдэлээс хэрхэн хамгаалах талаар зөвлөгөө өгч, танин мэдэхүйн чиглэлийн арга хэмжээ зохион байгуулах. о Сургуулийн орчинд ухаалаг гар утсыг нь хурааж авах буюу түүнтэй адилтгах эд зүйлсийг хэрэглэхгүй байхад анхаарах. Шаардлагатай нөхцөлд товчлууртай утас хэрэглүүлэх. о Анги удирдсан багш нь 13 нас хүрээгүй сурагчдадаа фейсбүүк хаяг нээж өгөхгүй байх. Дийлэнх багш нар ангийн группт нэгдээд мэдээллээс хоцрохгүй яваарай гэж хэлэх хандлага нэмэгдсэн ба хүүхдийг зөвхөн ангийн группт бүртгүүлэхийн тулд цахим хаяг нээж өгөх</p>
---	--	---	--

	<p>тараадаг эсвэл маш хямд үнээр борлуулдаг үүрэн холбооны дугаарын ард маш олон гэмт хэрэг холбогддог. Дугаарын бүртгэлийг сайжруулснаар фейсбүүкийг и-мэйл хаягаар нээдэггүй зөвхөн гар утасны хаягаар нээдэг болгох боломжийг судлах. Ингэснээр хүнийг гутаан доромжлон гүтгэх, хүүхдийг садар самуунд уруу татах үйлдлүүд тодорхой хэмжээнд хязгаарлагдана гэж таамаглаж байна. о Үүрэн холбоо болон интернэтийн үйлчилгээ үзүүлдэг компаниуд хамтран шүүлтүүрийн программ ашиглан сөрөг агуулгатай аливаа контентыг хүүхдүүдэд хүрэхээс өмнө арга хэмжээ авах боломжийг бүрдүүлэх. Өөрөөр хэлбэл тухайн мэдээлэл рүү нэвтэрч орох үйлдэл хийхэд дэлгэцэн дээр нь хориглосон утга бүхий сануулга гарч ирнэ.</p> <p>Бусадтай чатлах, эцэг эхийн хараа хяналтгүй сошиал медиа ашиглах зорилгоор</p>		<p>хүүхдэдээ фейсбүүк хаяг нээж өгөхгүй байхад анхаарах. о Эцэг эхчүүд завгүй, харин хүүхэд завтай байгаа байна. Улмаар цахим орчинд хэн нэгний тансаг хэрэглээ, чамин ганган эдлэлийг харж, бусдын найз нөхөдтэйгөө наргин баясаж буй дүр зургийг харан өөртэйгөө жиших хандлагатай байна. Бусдаас шалтгаалж амьдрах, хэрэв тэдэн шиг байж чадахгүй бол өөртөө гутрах, амьдралын буруу хэв маягт автах нь цахим орчинтой холбоотой. Иймд хүүхдээ завгүй байлгахад анхаарч, хичээлээс гадуур чөлөөт цагийг үр бүтээлтэй, сонирхолтой өнгөрүүлэхэд анхаарч, төрөл бүрийн сургалт, спортын клубүүдэд хүүхдээ тогтмол хамруулах. о Бага насны хүүхдээ саатуулах зорилгоор гар утсаа өгөхгүй байх. Хэрэв өгөх шаардлагатай бол хамгаалалтын программыг суулгах.</p>	<p>тохиолдол байдаг. Уг хандлагыг өөрчлөх.</p> <p>Бусад талуудын оролцоог нэмэгдүүлэх. о Цахим орчин дах хүүхэд хамгааллын чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллагуудтай хамтран мэдлэг олгох сургалт зохион байгуулах. о Цахим орчныг зөв болгоё, Unfriend зэрэг кампанит ажлуудыг дахин идэвхжүүлэх. о Урьдчилан мэдээ сэргийлэх, мэдээ мэдээлэл өгөхөд тусламжийн үнэ төлбөргүй утас чухал үүрэгтэй. Тиймээс хүүхдийн эрх зөрчигдсөн талаарх мэдээллийг хүлээн авах, хүүхдэд буруу үлгэр дуурайлал өгч байгаа мэдээллийн сайт, цахим хуудас, фейсбүүк группийн талаар гомдол гаргах, шууд мэдэгдэх боломжийг бүрдүүлэх. о Сэтгүүлчдийн ёс зүйн хэм хэмжээг нэмэгдүүлэх, энэ талаарх сургалтыг зохион байгуулах. Хүүхдийн эрхийн</p>
--	---	--	---	--

<p>фейсбүүкийн олон хаяг ашиглаж байна. Тиймээс фейсбүүкийн хаяг нээхэд иргэний үнэмлэхийн зураг оруулдаг байх зэргээр шаардлагыг нэмэгдүүлэх боломжийг судлах. о Хүүхдийг садар самуунд уруу татах чиглэлийн мэдээ мэдээлэл явуулдаг веб сайтууд, фейсбүүкийн пост зэрийг зогсоох зорилгоор Black list буюу хар жагсаалт гэсэн веб сайт нээж ажиллуулах. Эцэг эх, асран хамгаалагч, багш сурган хүмүүжүүлэгчид хар жагсаалтад багтах веб сайтуудыг репорт хийх боломжийг бүрдүүлэх. о Ерөнхий боловсролын сургууль, их дээд сургууль болон нийтийн номын сан зэрэгт шүүлтүүрийн программыг суурилуулах. о CU, Circle K зэрэг конвениенс дэлгүүр, кофе шоп болон үнэгүй Wi-Fi-тай газруудад хүүхдүүд олноороо цуглардаг. Тиймээс тэдний тогтмол ордог газруудад шүүлтүүрийн</p>				<p>зөрчлийг дуулиан шуугиан болгох, хүүхдийг ичээх, дарамтлах асуудал байдаг. Энэ нь хүүхдүүдийг цахим дарамтын асуудлаа нуух, дотроо хадгалах хандлага руу түлхэж байна. Тиймээс хүүхдийг ашиглах, мэдээлэл өгснөөр хүүхэд золиос болохгүй байх, хүүхдийн зургийг оруулахгүй байх, нэрийг нь өөрчилж нийтлэх зэрэг хүүхдийн асуудлаарх ёс зүйн зарчмын талаарх мэдлэг олгох.</p>
---	--	--	--	---

	<p>программыг суурилуулах. Шаардлагатай тохиолдолд Wifi -ийн сүлжээ унагагч байршуулах. о Насанд хүрэгчдэд зориулсан аним, манга үзэх хандлага байна. Тиймээс энэ төрлийн сайтуудад хяналт тавих. о Эцэг эхчүүдийн мэдээлэл технологийн хэрэглээний мэдлэг, соёл төлөвлөөгүй, мөн англи хэлний мэдлэгээс шалтгаалан хамгаалах программ хангамжийг ашиглаж чадахгүй байна. Тиймээс эх хэл дээрх хамгаалалтын программ хангамжийг боловсруулах, түүнийг хэрхэн суурилуулах, хэрхэн хэрэглэх талаар сургалт, зөвлөгөөг цогц байдлаар зохион байгуулах.</p>					
8	<p>“Монгол улс дахь хүн худалдаалах гэмт хэргийн шалтгаан, нөхцөл, хүн худалдаалах гэмт хэрэгт өртөх эрсдэлийн үнэлгээ” суурь судалгаа, 2021, ОУШХБ, IRIM</p>	<p>ХХГХ-ийн хөдөлмөрийн мөлжлөгийн хэлбэрүүд, салбарын онцлогтой холбогдон гарч байгаа асуудлаар тандалт судалгаа хийх; 1.2 ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр кампанит ажил, нөлөөллийн ажил зохион</p>	<p>х 4.1 Сэтгэл зүйчид, зөвлөгөө өгөх төвүүдийг ХХГХийн хохирогчтой ажиллах чиглэлээр чадавхжуулах, мэргэжлийн сургалтуудыг зохион байгуулах, хохирогчид туслалцаа үзүүлэх чиглэлээр орон нутгийн сургуулиуд болон ТББ-тай хамтран ажиллах байдлыг дэмжих;</p>	<p>3.1 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны практикт нэгэнт нэвтэрсэн “Хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах аргачлал”-ын дагуу болон олон улсын сайн туршлагыг таниулах чиглэлээр</p>	<p>, эдийн засгийн боломж тааруу иргэд ХХГХ-т илүү өртөж байна. Богино хугацаанд 1. ХХГХ-т эрсдэл өндөр 14-25 насны иргэдийн хүний наймааны талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх Ялангуяа эрэгтэйчүүдийн хувьд</p>	<p>2. Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөрт 153 ХХГХ-т өртөх эрсдэлтэй залуучуудыг хамруулах Хот руу шилжин ирсэн иргэдэд орлого олох боломжуудыг нэмэгдүүлэх 2.1 2020 оны 6 сард</p>

<p>судалгааны хүрээлэн</p> <p>Санхүүжүүлэгч: Нидерландын Засгийн газар</p>	<p>байгуулах, ялангуяа Хууль сахиулах байгууллагын албан хаагчдад эрэгтэйчүүдийн энэ төрлийн гэмт хэрэгт өртөх эрсдэлийг таниулах агуулгыг тусгах</p> <p>2.1 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 5.9-д Мэргэжлийн хяналтын байгууллага нь аж ахуйн нэгж, байгууллагад ажиллагсдыг албадан хөдөлмөр, боолчлол, боолчлолтой ижил төстэй нөхцөлд ажиллуулж, байлгаж байгаа эсэхэд өөрийн бүрэн эрхийнхээ хүрээнд тавих хяналтыг тасралтгүй сайжруулах, иргэдийг хөдөлмөр мөлжлөгт өртүүлсэн кейс, тохиолдлуудад дүн шинжилгээ хийн хяналт шалгалт хийх стандарт, хяналтын хуудсыг шаардлагатай тохиолдолд шинэчлэн боловсруулдаг байх;</p> <p>2.2 Гадаадын иргэн харьяатын газар, Цагдаагийн байгууллага, Хөдөлмөр, халамж, үйлчилгээний газар,</p>	<p>.1 Гэртээ хараа хяналтгүй хүүхэд үлдээдэг гэр бүлд энэ талын эрсдэлийг таниулах мэдлэг, мэдээлэл олгох үйл ажиллагаа зохион байгуулах; 1.2 Гэртээ хараа хяналтгүй үлдэж буй хүүхдүүдэд чиглэсэн олон нийтийн дэмжлэг тусалцааг ашиглах, хөршүүдийн холбоо, хяналтыг сайжруулах төслүүд санаачилж, хэрэгжүүлэх;</p> <p>Үйлдвэрлэл, үйлчилгээ, мал аж ахуй эрхлэгчдэд үйл ажиллагаагаа сэргээхэд чиглэсэн барьцаагүй, хүүгүй, эргэн төлөгдөх нөхцөлтэй санхүүгийн дэмжлэг болон санхүүгийн бус дэмжлэг, ажлын байр бий болгох, хадгалах, хамгаалах санаачилгыг дэмжих, зорилтот бүлгийн иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд чиглэсэн үйл ажиллагааг шуурхай зохион байгуулах</p> <p>3.1 Эмнэлгийн тусламж үйлчилгээ авч чадахгүй байгаа иргэдийн судалгааг гарган хэрэгцээг тодорхойлох, шаардлагатай тусламж үйлчилгээг хүргэх, мэргэжлийн ёс зүйн алдаа гаргахаас урьдчилан сэргийлэх зорилгоор эмч мэргэжилтнүүдийн ХХГХ-ийн талаарх ойлголт мэдлэгийг нэмэгдүүлэх, өвчтөн болон эмнэлгийн аюулгүй байдлыг хангах ажлуудыг зохион байгуулах; 3.2 Зорилтот бүлгийн иргэдэд санхүүгийн бүтээгдэхүүний талаарх ойлголт мэдлэгийг дээшлүүлэх, иргэд өөрийн онцлог хэрэгцээнд тохирсон санхүүгийн зөв бүтээгдэхүүнийг сонгон авах,</p>	<p>хууль сахиулах, прокурор, шүүх эрх мэдлийн алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах; 3.2 Хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа хангалтгүй явагдахад хүргэж буй Хөдөлмөр мөлжлөг, албадан хөдөлмөрлүүлэх гэмт хэргийг илрүүлэх, хянан шийдвэрлэх, ял шийтгэл онооход тулгарч буй хүндрэл бэрхшээлийг тодруулах хуулийн шинжилгээ хийх; 3.3 Нотолгоонд суурилсан стратегиар хөдөлмөр мөлжлөгийн хэргийн илрүүлэлт, мөрдөн байцаалт, хэрэг хянан шийдвэрлэх үйл ажиллагааг явуулах чиглэлээр хууль сахиулах байгууллагууд, прокурор, шүүхийн алба хаагчдад сургалтын стандарт хөтөлбөрт суурилсан чадавх бэхжүүлэх үйл ажиллагааг зохион байгуулах, сургагч багш нар бэлтгэх; 3.4 Ажлын орчин дахь ХХГХ-ийн эрсдэлийг илрүүлэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хөдөлмөрийн</p>	<p>хөдөлмөр мөлжлөг, албадан хөдөлмөрийн талаарх мэдлэг, ойлголтыг нэмэгдүүлэх 1.1 Хороо/багийн түвшинд оршин суух албан ёсны бүртгэлгүй, амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, өрөөсгөл гэр бүлтэй (өрх толгойлсон, салсан, бэлэвсэн), оюутан, улирлын чанартай болон хагас цагаар ажилладаг залуучуудын судалгааг нарийвчлан гаргах, зорилтот бүлгийн иргэдэд чиглэсэн кампанит ажил, аян, нэвтрүүлэг, подкаст, шторк бүтээх замаар ХХГХ-ийн талаарх ойлголт, мэдлэгийг нэмэгдүүлэх; 1.2 Хөдөө аж ахуй, барилга, уул уурхай зэрэг хөдөлмөр мөлжлөгийн эрсдэл өндөр салбарт ажилладаг эрэгтэйчүүдэд чиглэсэн мэдээлэл олгох үйл ажиллагааг ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх урт хугацааны үйл ажиллагааны</p>	<p>батлагдсан Оюутны цагаар хөдөлмөр эрхлэх журмын хэрэгжилтийг хангах замаар оюутан, залуучуудыг цагийн ажилд зуучлах, орлого олох боломжийг нэмэгдүүлэх; 2.2 Урт хугацаанд хөдөлмөр эрхлээгүй залуучуудыг ажлын дадал, туршлага эзэмшүүлэх туршилтын хөтөлбөрүүдэд хамруулах; 2.3 Хот уруу хөдөлмөр эрхлэх зорилгоор шилжин ирсэн иргэдэд Улаанбаатар хотод бүртгэлтэй эсэхээс үл хамааран мэргэжлийн боловсролын сургалтад хамрагдах боломжийг бий болгох</p> <p>Орон нутаг бүрд ямар төрлийн ажлын байрууд нээлттэй байгаа, эсвэл цаашдаа хөгжүүлэх боломжтойг тодорхойлж, тэдгээр ажлын байранд шаардагдах ур чадварыг тодорхойлж, орон нутгийн иргэдийн</p>
--	--	--	--	--	---

<p>МХЕГ зэрэг төрийн байгууллагуудын уялдаа холбоог сайжруулж, дүн мэдээ, мэдээлэл судалгаа солилцох, цахим мэдээллийн системтэй болох, хамтран хяналт шалгалт хийх боломжийг бүрдүүлэх; 2.3 Оролцогч талуудын хүлээх үүрэг, тооцох хариуцлагыг тодорхой болгох. Ялангуяа эрүүл мэнд, боловсролын салбарын ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хүлээсэн үүргийн биелэлтийг сайжруулахад анхаарах; 2.4 Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах, соёлын өвийн эсрэг гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн орон тоог нэмэгдүүлэх, орон нутаг ажиллах, ялангуяа Өмнөговь, Дорноговь, Дорнод аймгууд дахь мөрдөгчдийг нэмэгдүүлэх; 2.5 ХХГХ-тэй тэмцэх Дэд зөвлөлийн бүх гишүүд байгууллагуудад ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, тэмцэх үүрэг бүхий бие</p>	<p>санхүүгийн залилан мэхлэлтээс урьдчилан сэргийлэх, хадгаламжийг бүрдүүлэх, өр багасгах, хөрөнгийн зах зээлд оролцоход дэмжлэг үзүүлэх арга хэмжээг зохион байгуулах;</p> <p>6.1 Үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын чадавхад тулгуурлан хохирогч хамгааллын үйлчилгээ үзүүлж буй байгууллагуудад төсөв хуваарилах боломжийг судлах; 6.2 Үйлчилгээний стандартад нийцсэн төрөлжсөн хамгаалах байрнуудыг байгуулах. Тух: эрэгтэй хохирогчид, насанд хүрээгүй хүнийг тусад нь байрлуулах байрыг бий болгох. Үйлчилгээ үзүүлэх болон үйлчилгээний арга зүй, стандартыг тогтоохдоо олон улсын жишиг арга зүйд нийцүүлэн боловсруулах, боловсруулах; 6.3 НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийг чадавхжуулах, шаардлагатай нөөцөөр хангах, санхүүжилт олгох замаар ХХГХ-ийн хохирогчдод үйлчилгээ үзүүлэх хувилбарыг судлах; 6.4 ХХГХ үйлдэгдэх эрсдэл өндөр бүс нутаг, ялангуяа хилийн орчмын бүс нутагт хохирогч хамгааллын үйлчилгээг хөгжүүлэх</p>	<p>байцаагч нар болон цагаачлалын албаны мэргэжилтнүүдийг чадавхжуулах, сургагч багш нар бэлтгэх; 3.5 Хохирогчдод төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг про-бонo өмгөөлөгчдийн жагсаалтыг гаргах, хөдөлмөр мөлжлөгийн хохирогчдод өмгөөллийн туслалцаа үзүүлэх чиглэлээр чадавхжуулах; 3.6 Хуулийн чиглэлээр их, дээд сургуульд суралцаж буй оюутан нарт ХХГХ-ийн талаар ойлголт мэдлэг олгох хөтөлбөрийн агуулгыг сайжруулах, судлах боломжоор хангах; 3.7 Хөдөлмөр мөлжлөг, эд эрхтэний наймаа, зуучлалын захиалгат гэрлэлт зэрэг ХХГХ-ийн бусад төрөл хэлбэрийг илрүүлэх, таних чиглэлээр төр болон төрийн бус байгууллагын алба хаагчдыг мэргэшүүлэн сургах, сургагч багш нар бэлтгэх; 3.8 Хууль сахиулах, прокурор, шүүхийн албан хаагчид болон хөрш улс орнуудын ижил төстэй албан</p>	<p>төлөвлөлттэй уялдуулан, үе шаттай зохион байгуулах .1 ЕБС-ийн Нийгмийн тухай мэдлэг хичээлийн агуулгад ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх сэдвийг тусгах (үндсэн ойлголт, жишээ гэх мэт); 3.2 Их дээд сургуулийн ерөнхий суурь хичээлүүдийн хөтөлбөрийг (Хүний эрх, Нийгмийн ажил, Социологи, Сэтгэл судлал зэрэг мэргэжлийн) ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх агуулгаар баяжуулах;</p> <p>2.1 ХХГХ болон гэр бүлийн хүчирхийлэл хоорондын холбоо хамаарлыг хүлээн зөвшөөрч, ГБХ-ээс (бие махбодын сэтгэл санааны, бэлгийн, эдийн засгийн) урьдчилан сэргийлэх, өртсөн тохиолдолд хаанаас, хэрхэн тусламж дэмжлэг авах талаар мэдээллийг хэвлэл мэдээлэл, олон нийтийн мэдээллийн хэрэгслүүдээр дамжуулан түгээх</p> <p>3.1 Гэр бүлийн хүчирхийлэлтэй,</p>	<p>хэчнээн хувь нь эдгээр ажлын байруудад оролцох боломжтой зэргийг тодорхойлох орон нутгийн хөдөлмөрийн зах зээлийн шинжилгээ хийх; 1.2 Нутаг дэвсгэрт нь үйл ажиллагаа явуулж буй аж ахуй нэгж байгууллагад орон нутгийн иргэдийг түлхүү ажиллуулах, ажлын байранд шаардлагатай ур чадварыг олгох сургалтуудыг Мэргэжлийн боловсролын байгууллагатай хамтран зохион байгуулах</p> <p>4.1 Орон нутаг дахь гэмт хэргийн гаралтын бүсийг тогтоон иргэдэд мэдээллийг олон талт эх сурвалжуудаар өгөх, хяналт шалгалт хийх, гэмт хэргийг гаралтад нөлөөлж буй хүчин зүйлсийг тогтоох, тэдгээрийг бууруулах арга хэмжээг хорооны түвшинд идэвхжүүлэх; 4.2 Орон нутгийн</p>
---	---	--	---	--

<p>даасан бүтэц, нэгж бий болгоход анхаарах</p> <p>2.6 Хилийн чанадад ХХГХ-ийн хохирогч болсон иргэдийг түргэн шуурхай, аюулгүй буцаан татахтай холбоотой олон талын хамтын ажиллагааг сайжруулахын тулд хилийн чанад дахь хохирогчийг илрүүлэх, эгүүлэн татах үйл ажиллагааг зохион байгуулах журам боловсруулах; 2.7 Албан бус харилцааны механизмыг бий болгох замаар төр, төрийн бус байгууллагуудын мэдээллийн урсгал, солилцоог сайжруулах, уялдаа холбоог нэмэгдүүлэх; 2.8 ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх дэд зөвлөлийн бүрэлдэхүүнд Эс, эд эрхтэнийг шилжүүлэн суулгах үйл ажиллагааг зохицуулах албаны төлөөллийг оруулах;</p> <p>4.1 Цагдаа, шүүх, тагнуул, хилийн шалган нэвтрүүлэх алба зэрэг талуудыг оролцуулан ХХГХ-ийн урсгал чиглэлийг гэмт</p>	<p>хаагчдын дунд үндэстэн дамнасан мөрдөн шалгах ажиллагааны чиглэлээр хамтарсан сургалт зохион байгуулах;</p> <p>3.9 Сэтгэлзүйн зөвлөгөө дэмжлэг үзүүлэх, заслын үйлчилгээ үзүүлэх чиглэлээр үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудыг чадавхжуулах сургалтыг тогтмол зохион байгуулах, мэргэшсэн хүний нөөцийг нэмэгдүүлэхэд анхаарах, хамгаалах байр, НЦҮТ-ийн мэргэжилтнүүдийн ХХГХ-ийн хохирогчтой ажиллах чадавхыг дээшлүүлэх; 3.10 Зүүн Өмнөд Азийн орнууд дахь Монголын дипломат, консулын алба хаагчид, өргөмжит консулуудад ХХГХ-ийн хохирогчийг таних, илрүүлэх, нутаг буцаах, дамжуулах чиглэлээр чадавхжуулах сургалт зохион байгуулах</p> <p>5.1 ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх, ХХГХ-ийн бусад</p>	<p>амьжиргааны баталгаажих түвшнээс доогуур орлоготой, албан ёсны бүртгэлгүй, нийгмийн үйлчилгээ авахад хязгаарлагдмал нөхцөл байдалд байгаа гэр бүлд зөвлөн туслах, нийгэмшүүлэх сургалт зохион байгуулах, хөршийн холбоог сайжруулах, мэргэшсэн хүний нөөцөөр хангах, үйлчилгээнд шаардлагатай зардлыг жил бүрийн улсын төсөвт суулгах;</p>	<p>хөгжлийн сангаар хэрэгжих хөрөнгө оруулалт, төсөлд иргэдийн оролцох боломжийг нэмэгдүүлэх, иргэдийн саналд тулгуурлан аюулгүй, таатай орчныг бий болгох (гэрэлтүүлэг, дэд бүтэц); 4.3 Орон нутагт хэрэгжиж буй төсөл, хөтөлбөрийн үр нөлөөг дээшлүүлэх</p> <p>8.1 ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр олон улсын болон бүс нутгийн хамтын ажиллагааг сайжруулах, дэмжлэг үзүүлэх 8.2 ХХГХ-тэй тэмцэхэд чиглэсэн олон улсын байгууллагуудын Монгол Улсад өгсөн зөвлөмжүүдийг хэрэгжүүлэхэд чиглэсэн нөлөөллийн ажлыг иргэдийн оролцоонд тулгуурлан хийх</p> <p>9.1 Монгол Улсын иргэд ХХГХ-ийн хохирогч болсон Норвеги, Швед, Бельги, Камбож, Герман, Хонконг, Япон, Малайз, Филиппин, АНУ зэрэг</p>
--	--	---	--

	<p>хэргийн төрөл хэлбэрүүдээр нарийвчлах криминологийн судалгаа хийх; 4.2 ХХГХ-ийн шалтгаан, нөхцөл, эмзэг байршил, урсгал чиглэлийн мэдээллийг жил бүр шинэчлэн боловсруулж, энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээг төлөвлөж, Дэд зөвлөлд танилцуулан, тодорхой шийдвэр гаргуулж байх; 4.3 Цагдаа, шүүх, хил хамгаалах байгууллага, болон үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудын мэдээлэлд үндэслэсэн ХХГХ-ийн кейсүүдийн мэдээллийн нэгдсэн санг үүсгэх, тогтмол шинэчлэх, хохирогчдын хувийн мэдээллийн аюулгүй байдлыг хангахад онцгой анхаарах;</p> <p>Эрүүгийн хуульд дараах нэмэлт, өөрчлөлтийг оруулах: 7.1 Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах замаар ХХГХийн төрөл, хэлбэрийг бие даасан гэмт хэрэг</p>		<p>төрлүүд болох хөдөлмөр мөлжлөг, эд эрхтэний наймаа, хуурамч гэрлэлт, хүүхдийг худалдаалах гэмт хэргүүдийг таниулах кампанит ажил, аян, хэлэлцүүлэг, сургалт сурталчилгаа зэрэг нөлөөллийн ажлыг нийгмийн бүх түвшинд бүлгийн онцлогт тохируулсан арга аргачлалаар үе шаттай зохион байгуулах (залуу охид, эрэгтэйчүүд болон хөдөлмөр мөлжлөгийн хохирогч болох эрсдэлтэй бүлгийг чиглэх); 5.2 ХХГХ-ийн эмзэг байршил, урсгал чиглэлийн мэдээлэлд тулгуурлан урьдчилан сэргийлэх ажлыг нэгдсэн бодлоготойгоор хэрэгжүүлэх; 5.3 Хоол, энтертаймент, зочид буудал зэрэг үйлчилгээний салбаруудад тавих хяналтыг сайжруулах замаар ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх мэдээлэл түгээх ажлыг зохион байгуулах; 5.4 Хилээр нэвтрэх, буцах цэгүүдэд ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх</p>	<p>улсуудтай Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг байгуулах; 9.2 Хилийн чанадад ХХГХ-ийн хохирогчид илэрсэн тохиолдолд эх орондоо эгүүлэн авчрах ажлыг удирдан зохион байгуулах, салбар дундын уялдааг хангах;</p> <p>10.1 ОУШХБ-аас гүйцэтгэсэн “Улаанбаатар хотын шилжилт хөдөлгөөний хязгаарлалтын үр нөлөө болон шилжин суурьшигчдын эмзэг байдлын судалгаа” болон түүнтэй ижил төстэй судалгааны үр дүнд тулгуурлан дотоод шилжилт хөдөлгөөнийг үр дүнтэй зохицуулах урт хугацааны шийдлүүдийг боловсруулж хэрэгжүүлэх; 10.2 Бүртгэлгүй шилжин ирэгсдийн эмзэг байдлыг бууруулах, тэдгээр иргэдэд чиглэсэн хорооны түвшний хяналт, сургалт, холбон зуучлах үйлчилгээг</p>
--	---	--	--	--

<p>болгож хуульчилсан байдлыг залруулж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй байдлыг бий болгохгүй байхын тулд хуулийн зүйл заалтуудыг тодорхой болгох; 7.2 Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хууль дахь “хохилогч”-ийн тодорхойлолтыг хохирогч төвтэй хандлагад үндэслэн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн тодорхойлолттой нийцүүлэх; 7.3 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчид анхан шатны туслалцааг хэн, хэрхэн үзүүлэх асуудлыг тодорхой зааж оруулах, оролцогч талуудын үүрэг, хариуцлагыг тодорхой болгох; 7.4 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 17 дугаар зүйлд уг хуулийг зөрчсөн хүн, хуулийн этгээдэд Эрүүгийн хууль, эсхүл Зөрчлийн тухай хуульд заасан хариуцлага хүлээлгэх тухай заасан</p>		<p>санамж, зөвлөмж хэвлүүлэн тараах</p>		<p>чиглүүлэх, шинээр ирсэн газраа дасан зохицох хөтөлбөрийг хэрэгжүүлэх, хөршийн холбоог сайжруулах.</p>
--	--	---	--	--

	<p>хэдий ч Зөрчлийн тухай хуульд энэ талаар огт тусгаагүй байгаа тул Зөрчлийн тухай хуулийн 6 дугаар бүлэгт “Хүн худалдаалахтай тэмцэх хууль зөрчих” бие даасан зөрчлийг нэмж, хуулиар үүрэг хүлээсэн этгээдэд хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг бий болгох; 7.5 Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заагдсан хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг боловсруулан батлуулах; 7.6 Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нарын ААНБ, ажлын байранд гэнэтийн хяналт шалгалт хийх эрхийг Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 162.2.1 дэх заалттай уялдуулан Төрийн хяналт шалгалтын тухай хууль болон холбогдох журамд тусгах; 7.7 Албадан хөдөлмөрийг тодорхойлсон хуулийн тодорхойлолтыг эргэн харж зөрчилтэй, буруу ойлголт төрүүлэхүйц</p>				
--	--	--	--	--	--

	<p>найруулга, агуулгыг сайжруулах 7.8 Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулга 2018 оны 01 дүгээр сарын 19-нд батлагдсантай холбоотойгоор Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд “эд, эрхтэнийг авах...” гэсний өмнө “эс” гэж нэмэх; 7.9 Хохирогчид үнэ төлбөргүй хууль зүйн туслалцаа авах эрхийг зохицуулсан журмыг боловсруулах; 7.10 Хууль эрх зүйн орчныг боловсронгуй болгоход чиглэсэн олон улсын гэрээ конвенцод нэгдэн орох чиглэлээр хамтран ажиллах, судалгаа хийх. Тухайлбал, “Олон Улсын хэмжээнд хүүхэд хулгайлахтай холбогдон үүсэх иргэний асуудлын тухай конвенц” хэрэгжилтийг хангахын тулд үндэсний эрх зүйн баримт бичгүүдийг уялдуулахад хамтран ажиллах;</p>				
<p>9 “Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчдод туслалцаа үзүүлэх үндэсний механизмын</p>	<p>Төр болон ТББ-ууд хамтран хохирогчийг илрүүлэх, тогтоох, тодорхойлох нэгдсэн аргачлал, удирдамж боловсруулах,</p>	<p>Хохирогчид үзүүлэх үйлчилгээний хүрээнд: - Хохирогчдод үзүүлэх үйлчилгээний тогтолцоог боловсронгуй болгож, үйлчилгээг үнэ төлбөргүй болгох; - Үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ажиллаж буй</p>			

<p>зураглал, Азийн сан, Хүйсийн тэгш эрх төв, 2021</p> <p>Санхүүжүүлэгч: Бадамлянхуа сан</p>	<p>батлуулах, хэрэгжүүлэх; - ХХГХ-ийн хохирогчид үзүүлсэн туслалцаа, үйлчилгээний талаар нэгдсэн мэдээллийн сан үүсгэх; - Хохирол нөхөн төлүүлэх, нөхөн олговор олгох тогтолцоо бүрдүүлэх; - Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийг дагаж гарах журмуудыг засан сайжруулах, яаралтай батлах, хэрэгжилтийг хангах.</p>	<p>төрийн болон ТББ-ын нийгмийн ажилтан, сэтгэл зүйч, эрх зүйч, хуульчдыг тогтвортойгоор сургах, чадавхжуулах, туршлага солилцох замаар хамтран ажиллах боломжийг бүрдүүлэх. 3. Хохирогч хамгаалал, үйлчилгээний чанар, хүртээмжийн хүрээнд: - Төрөөс ТББ-д олгох ХХГХ-ийн хохирогчдод урт хугацааны үйлчилгээ үзүүлэх хангалттай санхүүжилтийг тусгах, хуваарилах; - Эрсдэл өндөртэй орон нутагт хохирогчдод үйлчилгээ үзүүлэх ТББуудыг бий болгож, хүний нөөцийг чадавхжуулах, орон нутгаас санхүүжилт авах боломжийг бүрдүүлэх; - Эрсдэл өндөртэй, гэрч, хохирогчийг хамгаалах байрыг ЦЕГ-ын Гэрч, хохирогчийг хамгаалах газрын дэргэд байгуулах; - Хүн худалдаалахтай тэмцэх, урьдчилан сэргийлэх, ялангуяа насанд хүрээгүй хохирогчдод үйлчилгээ үзүүлэх хөтөлбөрийг бусад орны туршлага дээр тулгуурлан боловсруулж, турших, хэрэгжүүлэх. 4. Хохирогч хамгааллын үйлчилгээний санхүүжилтийн хүрээнд: - Төрийн байгууллагаас хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн үйлчилгээнд зориулсан тогтмол төсөв, санхүүжилт хуваарилах</p>			
<p>10 Хүүхэд хамгааллын компакт гэрээ"-ний төслийн суурь судалгаа,</p>	<p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн хэрэгжилтийн судалгааг хийх замаар энэ төрлийн гэмт хэрэгтэй тэмцэх</p>	<p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогч хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хохирогч хамгааллын үйлчилгээнд хамруулах зохицуулалтыг тусгах; · Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн</p>	<p>Иргэд олон нийтийг хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд</p>		<p>Төрийн байгууллагын хамтын ажиллагааны чиг үүргийг тодорхой болгож, хамтын ажиллагааны механизмыг</p>

<p>ГХУСАЗЗ, Дэлхийн зөн, IRIM, 2021</p> <p>Санхүүжүүлэгч: АНУ-ын Төрийн Департамент</p>	<p>чиглэлээр хэрэгжиж буй эрх зүйн баримт бичгүүдийг уялдуулах; · Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль болон Гэрч хохирогчийг хамгаалах тухай хуулийг илүү хохирогч төвтэй хандлагад үндэслэн Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн тодорхойлолттой нийцүүлэх; · Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлж буйг илрүүлэхэд анхаарлаа хандуулах, түүнтэй холбоотой эрх зүйн орчин сайжруулах ажлыг эхлүүлэх; · Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчид үзүүлэх нийгмийн үйлчилгээнд тавих нийтлэг шаардлага MNS 6418:2013 стандартыг судалгааны үр дүнд үндэслэн шинэчлэх талаар холбогдох байгууллагад нь мэдэгдэх.</p>	<p>мөлжлөг, хүн худалдаалах гэмт хэрэгт өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний нэгдсэн удирдамжийг боловсруулах, хэрэгжүүлэх; · Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хүүхдийг илрүүлэх, таньж мэдэх удирдамж боловсруулан батлах, хэрэгжилтийг хангах; · Хохирогчийг илрүүлэх, таньж тогтоох, хохирогчдод үзүүлэх үйлчилгээний нэгдсэн удирдамжийг таниулах зорилгоор хүүхэд хамгааллын оролцогч талуудын мэргэжилтнүүдийг мэргэшүүлэх сургах тогтолцоог бий болгох; · Хохирогч хамгааллын үйлчилгээнд зориулсан санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт суулгах, батлуулах; · Хүүхдэд зориулсан төрөлжсөн, нас харгалзахгүй, тусгай хэрэгцээт хүнийг байрлуулах боломжтой хамгаалах байрыг бий болгох Хүн худалдаалах болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг хянан шийдвэрлэх ажиллагааны оролцогч тал болох эрүүгийн мөрдөгч, мөрдөгч, прокурор, шүүгчийн хүн худалдаалах болон хүүхэд хамгааллын чиглэлийн мэргэжлийн мэдлэг олгох сургалтыг тасралтгүй зохион байгуулах; · Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах замаар хүний наймааны төрөл, хэлбэрийг бие даасан гэмт хэрэг болгож хуульчилсан байдлыг засаж, эрүүгийн хариуцлага гарцаагүй байх зарчмын дагуу гэм буруутай этгээдэд эрүүгийн хариуцлага хүлээлгэх, хэрэг хянан</p>	<p>татан оролцуулах, ойлголт мэдлэгийг дээшлүүлэхийн тулд сургалт болон нөлөөллийн ажлуудад хамруулах, соён гэгээрүүлэх энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй төр, төрийн бус байгууллагын хамтын ажиллагаа, уялдаа холбоог сайжруулахад төслийн үйл ажиллагааг чиглүүлэх; · Төслийн хүрээнд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хариу үйлчилгээ үзүүлэх чиглэлээр ИНБ-ын сайн туршлагыг сурталчлах, туршлага хуваалцах сургалтын үйл ажиллагаа зохион байгуулах, орон нутгийн хэмжээнд үйл ажиллагаа явуулдаг ИНБ-ыг чадавхжуулж, улмаар төрийн байгууллагатай хамтран ажиллахад дэмжлэг үзүүлэх; · Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлсэн үйл ажиллагааны үр дүн, үр нөлөөнд тогтмол,</p>	<p>бүрдүүлэх: ямар асуудлыг шийдвэрлэхэд, чухам аль түвшинд, төрийн ямар байгууллага, хэрхэн хамтарч ажиллах ёстойг нарийвчлан журамлах (журмын төсөл боловсруулах) · Төр, ТББ хооронд салбар дундын мэдээлэл солилцох сүлжээг бий болгох замаар нэгдсэн ойлголттой болгох, уялдаа холбоог сайжруулахад дэмжлэг үзүүлэх, хамтын ажиллагааг бэхжүүлэх, оролцогч байгууллагууд хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиглэлээр хамтын ажиллагааны гүйцэтгэлээ жил бүр үнэлж хэвших</p>
---	---	---	--	--

		<p>шийдвэрлэх ажиллагаанд эргэлзээтэй байдлыг бий болгохгүй байх нөхцөлийг хангах чиглэлээр эрх бүхий байгууллагад нь зөвлөмж хүргүүлэх; · Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлд заагдсан хохирогчийн сэтгэл санааны хохирлыг тооцох аргачлалыг яаралтай боловсруулан батлах талаар эрх бүхий байгууллагад зөвлөмж хүргүүлэх; · Төлбөрийн чадваргүй насанд хүрээгүй хохирогчийн өмгөөлүүлэх эрхийг баталгаатай хангах чиглэлээр эрх зүйн орчныг бүрдүүлэх талаар эрх бүхий байгууллагад нь зөвлөмж хүргүүлэх;</p>	<p>төлөвлөгөөт мониторинг үнэлгээ хийх аргачлалын талаар холбогдох төрийн ба ТББ-уудад дэмжлэг үзүүлэх, сургалт зохион байгуулах;</p> <p>Эцэг эх, асран хамгаалагчдад хүүхдийн эсрэг ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх мэдлэг, мэдээллийг түгээх, сурталчлах, ялангуяа зорилтот бүлгийн өрхөд (ажилгүй, орлогогүй, ядуу, олон хүүхэдтэй, эмзэг г.м) хүрч ажиллах, мэдээллээр хангах, нөлөөллийн стратеги боловсруулах; · Хүүхдийн эсрэг үйлдэгдэж буй ХХГХ-тэй тэмцэхдээ эцэг эх, асран хамгаалагчдад зөвхөн урьдчилан сэргийлэх төдийгүй хариу үйлчилгээ үзүүлэх мэдлэг, ойлголтыг хамтад нь цогц хэлбэрээр хүргэх, мэдээлэл өгөх сургалт зохион байгуулах, цахим сурталчилгаа явуулах, аян, нөлөөллийн арга хэмжээг явуулахдаа</p>		
--	--	---	---	--	--

			тухайн чиглэлээр туршлагатай, чадавхтай ТББ-уудын давуу талд тулгуурлан төслийн хүрээнд хамтарч ажиллах.			
11	<p>Хүүхдийн хөдөлмөрийн чанарын судалгаа” ОУХБ, Хүний эрхийн үндэсний комисс</p> <p>Санхүүжүүлэгч: Олон улсын хөдөлмөрийн байгууллага</p>	<p>Засгийн газрын 2016 оны 204 дүгээр тогтоолоор баталсан “НҮБ-ын Хүний эрхийн зөвлөлөөс гаргасан зөвлөмжүүдийг 2016-2019 онд хэрэгжүүлэх арга хэмжээний ерөнхий төлөвлөгөө”-ний 82 дахь хэсэгт “2012-2016 онд 2 үе шаттайгаар хэрэгжүүлсэн Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх, үр дүнд тулгуурлан шинэчлэн батлах” гэсний дагуу хөтөлбөрийн хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээг нарийвчлан боловсруулж, батлах;</p> <p>2. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгах, хориглох чиглэлээр батлан мөрдүүлж буй бодлогын баримт бичиг, хөтөлбөр, арга хэмжээг боловсруулахдаа</p>	<p>Уяач нь хурдан морь унаач хүүхэд, түүний эцэг эхтэй 3 талт гэрээг заавал байгуулдаг байхаар зохицуулах; 2. Хууль тогтоомж болон дээр дурдсан гэрээгээр унаач хүүхдийн хөдөлмөрийн нөхцөлийг нарийвчлан тодорхойлох; 3. Унаач хүүхдийн жишиг цалинг насны ангиллаар тодорхойлж тогтоох; 4. Унаач хүүхдийн цалингийн зарцуулалтыг хянах эрх зүйн зохицуулалтыг бий болгох; 5. Боловсролын үйлчилгээнд хамрагдах талаар уяач болон эцэг, эх, асран хамгаалагчид тодорхой үүрэг хүлээлгэх, энэ үүргээ зөрчсөн тохиолдолд эрүүгийн болон зөрчлийн хуулиар шийтгэл хүлээлгэх зохицуулалт тусгах; 6. Унаач хүүхдийн хамгаалах хэрэгслийн чанарыг сайжруулах, холбогдох стандартад нэмэлт, өөрчлөлт оруулах. Тухайлбал өвлийн улиралд каскны дотор өвлийн малгай өмсөх боломжтой байх, каскны оосор хүүхдийн хоолойгоор боохгүй, татахгүй байх, түүнчлэн каскаа авч, морь үргээхэд ашиглах боломжгүй болгох, комбинзоны чанарыг тодорхойлох, гутлын шаардлагыг тусгайлан тогтоох, стандартчилах; 7. Бүрэн хамгаалах хэрэгсэлтэйгээ барианд ирсэн эсэхэд шалгуур тавьж Үндэсний их баяр наадмын</p>	<p>ГБХЗХГ-ын Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын мэдээллийн сангийн мэдээлэл цуглуулах аргачлалыг аймаг, орон нутаг бүрд нэг ижил мөрдүүлж, судалгаанд үндэслэлтэй, бодит мэдээллээр хангах; 2. ГБХЗХГ-ын Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын санд мэдээллийн санд хуулиар зөвшөөрсөн хэлбэрийн ажил, хөдөлмөр эрхэлж байгаа хүүхдийн тухай мэдээллийг оруулдаг болох; 3. Хөдөлмөрт өртөх эрсдэлтэй хүүхдийн тухай мэдээллийн санг хөтлөх чиг үүргийг холбогдох байгууллагуудад хуулиар хүлээлгэх; 4. Техникийн болон мэргэжлийн сургалтын байгууллагад хүүхдүүдийг дадлага хийлгэх нэрээр хөдөлмөрийн мөлжлөгт өртүүлж</p>		

	<p>хэрэгжилтийг үнэлэх шалгуур үзүүлэлт, хэрэгжүүлээгүй тохиолдолд хүлээлгэх хариуцлагын тогтолцоог бий болгох, хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардагдах санхүүжилтийн эх үүсвэр, хэмжээг тодорхой тусгах; 3. Монгол Улсын хууль тогтоомж, бодлогын баримт бичигт хүүхдийг тэвчишгүй хөдөлмөр эрхлэхээс урьдчилан сэргийлэх, энэ төрлийн хөдөлмөрөөс хүүхдийг хөндийрүүлэх, нөхөн сэргээх арга хэмжээ маш бага тусгагдаж байгаа нь урьд баталж хэрэгжүүлсэн хөтөлбөр, арга хэмжээнээс харагдаж байна. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулга болон Эрүүгийн хуулийн шинэчилсэн найруулгад хүүхдийг тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлсэн этгээдэд оногдуулах ял, шийтгэлийн зохицуулалтыг тодорхой хэмжээнд тусгасан боловч энэ төрлийн гэмт хэргийг бууруулах, зогсооход</p>	<p>морин уралдааны дүрэм, Монголын хурдан морины уралдааны дүрэмд тодорхойлж заах; 8. Үсэргээ, сунгаа, морины ажлыг өвөл хүүхдээр хийлгүүлж байгаа асуудлыг нарийвчлан судалж, эрх зүйд зохицуулалтыг бий болгох; 9. Унаач хүүхдээс гадна “Уяачийн туслах” гэх ажил, хөдөлмөр эрхэлж байгаа 18 нас хүрээгүй хүний эрхэлж байгаа ажлын онцлог, аюул занал, хөдөлмөрийн нөхцөлийн талаар тусад нь судалгаа хийж, дүгнэлт хийх.</p>	<p>байх магадлалтай байгаа тул энэ асуудлыг хянах, шалгах чиглэлээр судалгаа хийж холбогдох байгууллагууд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 5. Ажил, хөдөлмөр эрхлэхийн зэрэгцээ гэрийн ажил, өрхийн үйлдвэрлэлд цалин хөлсгүй ажиллаж байгаа хүүхдийн хувьд эдгээрт зарцуулах нийт цаг тухайн хүүхдийн настай харьцуулахад хэт их байгаа тохиолдлыг хянаж, шалгах үйл ажиллагааг төлөвлөн хэрэгжүүлж хэвшүүлэх; 6. Эцэг, эхийнхээ өрийг төлөх, орон гэрийн түрээсийг төлөхийн тулд цалин хөлсөө зарцуулж эсвэл цалин хөлсгүйгээр хамжлагын хэлбэрээр ажил, хөдөлмөр хийж байгаа хүүхдийг тусгайлан илрүүлж зохицуулах арга хэмжээ авах; 7. Хүүхэд ажиллаж байгаа газраа орхиж явах эрхгүй, боломжгүй болох, бусдын дарамт, шахалтаас болж</p>		
--	--	--	---	--	--

	<p>шаардлагатай хамгийн том нөлөөлөл бол урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх ажиллагаа юм. Иймд Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх тухай хуулийн хэрэгжилтийг сайжруулах, цаашид хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэрийг устгахад урьдчилан сэргийлэх, соён гэгээрүүлэх талаар хөтөлбөр боловсруулж хэрэгжүүлэх; 4. Хүүхэд хамгааллын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1 дэх хэсэгт заасан “эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд” гэх нэр томъёонд “тэвчишгүй хөдөлмөрт өртсөн хүүхэд” гэж нэмж тусгах; 5. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 84 дүгээр зүйлд “13- 15 насны хүүхдийн ажиллах цагийн хязгаар”-ын талаар нэмж тусгах; 6. Циркийн үзүүлбэр, уран нугаралт, акробат зэрэг урлаг, спортын үзүүлбэрийг хүүхдээр хийлгэхэд хөдөлмөр, хамгаалал, аюулгүй байдлыг хангах чиглэлээр ажлын</p>		<p>хүсээгүй байхдаа ажил, хөдөлмөр эрхлэх нөхцөлд хүрсэн тохиолдолд хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр гэж үзэж хариуцлага хүлээлгэх зохицуулалтыг хууль тогтоомжид нэмж тусган, хүүхэд бусадтай харилцах, холбогдох боломж хязгаарлагдмал ажилладаг байгууллага, ажлын байранд тогтмол хяналт, шалгалт хийж хэвшүүлэх; 8. ОУХБ-аас гаргасан хөдөлмөрийн мөлжлөгийн 9 шалгуур үзүүлэлтийн дагуу ажил эрхэлж байгаа хүүхдийн ажиллах нөхцөл, ажил гүйцэтгэх үйл явцад хөдөлмөрийн мөлжлөгийн шинж чанар байгаа эсэхийг шалгаж шийдвэрлэх талаар удирдамж, зааврыг хүүхдийн эрхийн улсын байцаагч, хөдөлмөрийн улсын байцаагч, цагдаагийн байгууллагын холбогдох алба хаагчдад хэвлүүлэн өгч, шаардлагатай</p>		
--	--	--	---	--	--

<p>байрны нөхцөл, шаардлагыг тодорхойлох; Эрүүгийн хуульд “өрийн төлөөс, хамжлагын албат” болгох үйлдлийг гэмт хэрэгт тооцож, эрүүгийн хариуцлага оногдуулахаар нэмж тусгах; 8. Эрүүгийн хуулийн 13.13 дугаар зүйлд “Насанд хүрээгүй хүнийг албадан хөдөлмөрлүүлсэн” үйлдлийг гэмт хэргийн хүндрүүлэх бүрэлдэхүүнд оруулж, оногдуулах ял, шийтгэлийг чангатгах; 9. Дайны байдлын тухай хуулийн 26 дугаар зүйлд “Дайны байдлын үед цэргийн дайчилгаанд 18 нас хүрээгүй хүүхдийг оролцуулахгүй байх” талаар нэмж тусгах; 10. Эрүүгийн хуулийн 12.6 дугаар зүйлийн тайлбар хэсэгт “Энэ гэмт хэргийг үйлдэхдээ арван найман насанд хүрээгүй хүний биеийг үнэлүүлсэн...” гэсний дараа “, биеэ үнэлэхэд зуучилсан” гэж нэмж тусгах; 11. Эрүүгийн хуулийн 20.7 дугаар зүйлийн Мансууруулах эм, сэтгэцэд нөлөөт бодисыг хууль бусаар</p>		<p>сургалтыг тогтмол зохион байгуулж байх; 9. Ажил, хөдөлмөр эрхлэлтэд өртөх эрсдэлтэй хүүхдүүдэд ажлын байрны дарамт, хүчирхийлэл болон ажлын байрны бэлгийн дарамтаас урьдчилан сэргийлэхтэй холбоотой заавар, зөвлөмжийг тогтмол хүргэх арга хэмжээг авч хэрэгжүүлэх; 10. Үл хайхрах хүчирхийлэлд өртсөн хүүхэд нь ажил, хөдөлмөр эрхлэлтэд өртөх, ёс суртахууны доголдолтой болох, гэмт хэрэг, зөрчилд холбогдох, хохирох, мансууруулах болон сэтгэцэд нөлөөт бодист донтох өндөр эрсдэлтэй болохыг анхаарч хүүхдийг үл хайхрах хүчирхийлэлтэй тэмцэх үйл ажиллагааг эрчимжүүлэх; 11. Хүүхэд ажил, хөдөлмөр эрхлэлтийн хүрээнд гадаа ажилладаг хүнд ачаа өргөж, зөөдөг, уртасгасан, шөнийн цагаар ажиллуулах зөрчил бүх төрлийн ажилд нийтлэг байгааг</p>		
--	--	---	--	--

	<p>ашиглах гэмт хэргийн хүндрүүлэх нөхцөл байдалд “энэ гэмт хэргийг үйлдэхдээ насанд хүрээгүй хүүхдийг ашигласан, татан оролцуулсан” гэж нэмж тусгах; 12. Эрүүгийн хуулийн 16.10 дугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Хүүхдээр аюултай ажил, эрүүл мэнд, бие бялдар, оюун санаанд нь хохирол учруулахуйц хориглосон ажил, үйлчилгээ зориуд эрхлүүлсэн бол...” гэсний “зориуд” гэснийг хасах; 13. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад “хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр ажил олгогчийн байранд хашигдан хийх ажил”-ыг хориглох заалтыг нэмж тусгах; 14. Зөрчлийн тухай болон Эрүүгийн хуульд хүүхдийг хуульд зөвшөөрснөөс бусад тохиолдолд албан томилолтоор ажиллуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг нэмж тусгах; 15. Насанд хүрээгүй хүнийг ажиллуулахыг хориглосон ажлын байрны жагсаалтад</p>		<p>анхаарч төрийн алба хаагч, эцэг, эх, асран хамгаалагч, багш, сурган хүмүүжүүлэгчид, төрийн бус болон иргэний нийгмийн байгууллагууд зэрэг бүх талын оролцоотойгоор хяналтыг сайжруулах; 12. Хориглосон ажлын байр, хориглосон хөдөлмөрийн нөхцөлд насанд хүрээгүй хүнийг ажиллуулсан тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг чангатгах; 13. Ажил, хөдөлмөр эрхэлтэд өртсөн хүүхдэд үзүүлэх хариу арга хэмжээний талаар холбогдох байгууллагуудад сургалт, мэдээллийн ажлыг тогтмол зохион байгуулах; 14. Хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн найруулгад заасан “урлаг, спортын үзүүлбэр, зар сурталчилгаа” гэснийг хэрхэн ойлгох талаар хуулийн тайлбар хийж хууль хэрэглээнд нэг мөр ойлголтыг бий болгох; 15. Ажил, хөдөлмөр эрхэлж цалин хөлс авч байгаа хүүхдийг нийгмийн</p>		
--	--	--	--	--	--

	<p>техник, технологийн дэвшил, хурдацтай хөгжиж буй өнөө үетэй нийцүүлэн “хүүхдийг бэлгийн хүчирхийлэлд өртүүлэхүйц ажил болон хүүхдийн сэтгэхүй, ёс суртахуунд нөлөөлөхүйц ажлыг нэмж тусгах; 16. Хүүхдийн хөдөлмөрийн тэвчишгүй хэлбэр оршиж байгаа газрыг тогтоох, олон нийтийн болон төрийн захиргааны байгууллагын хяналт, Хүүхэд хамгааллын тухай хуульд заасан хүүхэд хамгааллын хариу үйлчилгээ үзүүлэх эрх бүхий албан тушаалтнуудын үйл ажиллагааг уялдуулан зохицуулах, сайжруулах;</p>		<p>даатгалд хамруулах эрх зүйн болон төрийн үйлчилгээний тогтолцоог нарийвчлан тодорхойлж ач холбогдлыг нийтэд таниулан сурталчлах;</p>		
<p>12 Хүн худалдаалах, түүнтэй төстэй хэргийг хянан шийдвэрлэх ажиллагаанд хийсэн дүн шинжилгээ, ГХУСАЗЗ, Азийн сан, Хүйсийн тэгш эрх төв, 2022 он</p> <p>Санхүүжүүлэгч: АНУ-ын Төрийн Департамент</p>	<p>Хэдийгээр Монгол Улс хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэгтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх, хохирогч хамгааллын чиглэлээр 12 олон улсын баримт бичигт нэгдэж, олон улсын өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаа ч энэ төрлийн гэмт хэрэг үйлдэгддэг, үйлдэгдэж болзошгүй улс</p>	<p>Аливаа гэмт хэрэг, ялангуяа энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн эмзэг байдал, ялгаатай байдлыг дээд зэргээр мэдэрч, мөрдөн шалгах ажиллагааны явцад хохирогчийг буруутгахаас зайлсхийж, үйл ажиллагаандаа хохирогч төвтэй мөрдөн шалгах аргачлалыг нэвтрүүлэх</p> <p>Хохирогчийн эрх, үүргийг тайлбарлахын зэрэгцээ ЭХХШТХ-д заасан хууль ёсны эрх, ашиг сонирхлоо хамгаалуулах, гэмт</p>	<p>Хариуцсан нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй энэ төрлийн зөрчил үйлдэгдэж болзошгүй газруудад тавих хяналтаа сайжруулж, зөрчилд холбогдож болзошгүй иргэдэд чиглэсэн урьдчилан сэргийлэх ажил арга хэмжээ зохион байгуулах</p>	<p>Зөрчил шалгаж шийдвэрлэх тухай хуулиар хүлээсэн үүргээ биелүүлж, цагдаагийн байгууллагаас шалгасан энэ төрлийн зөрчлийн шинжид хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн шинж байгаа эсэхэд тавих хяналтаа сайжруулах</p>	<p>Хохирогч төвтэй мөрдөн шалгах ажиллагаа явуулах аргачлалд суурилан цагдаа, прокурорын байгууллагын алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах. Сургалтыг зохион байгуулахдаа цагдаагийн алба хаагчдад, прокуроруудад гэж ангилахаас илүүтэй</p>

<p>орнуудтай эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг байгуулах шаардлагатай байна</p> <p>Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг /ХХГХ хамаарна/ ихээр үйлдэгдэж буй Норвеги, Швед, Арабын Нэгдсэн Эмират, Камбож, Япон, Малайз, Филиппин, АНУ зэрэг гадаадын улсуудтай Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг яаралтай байгуулах</p> <p>Хууль зүй, дотоод хэргийн яам болон Гадаад харилцааны яамнаас өмнө нь байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэх</p> <p>ууль тогтоомжийн тухай хуулийн 51 дүгээр зүйлийн 51.1 дэх хэсэгт заасан үндэслэлээр Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн</p>	<p>этгээдийн зүгээс үзүүлж буй аюул заналаас хамгаалагдах боломжийн талаар тайлбарлаж өгч хэвших</p> <p>ЭХХШТХ-д заасан хохирогчийн мэдээллээр хангуулах эрхийг баталгаатай эдлүүлж, хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааны явц болон бусад мэдээллийг хохирогчид өгч байх</p> <p>Энэ төрлийн гэмт хэрэг хууль ёсны төлөөлөгчөөр оролцож буй хүүхдийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын мэргэжилтнүүдэд чиглэсэн сургалтыг зохион байгуулж, чадвар эзэмшүүлэх</p> <p>Хохирогчдод төлбөргүй хууль зүйн туслалцаа үзүүлдэг про-боно өмгөөлөгчдийн жагсаалтыг гаргах, хохирогчдод өмгөөллийн туслалцаа үзүүлэх чиглэлээр чадавхжуулах сургалтад хамруулах</p> <p>Энэ төрлийн гэмт хэргийг шалгах, шийдвэрлэх ажиллагаанд сэтгэл зүйчийг аль болох байлцуулж байх /насанд хүрээгүй бол заавал оролцуулах/</p>	<p>Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэг болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг шалгах, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийн албан хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр тогтмол сургалтад хамруулж байх</p> <p>Хүүхдийн эсрэг үйлдэж буй хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн талаар хийсэн судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа ашиглаж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчлэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх</p> <p>Хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэргийн талаарх ойлголт, мэдээллийг сурагчдад түгээх, тэднийг энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр тодорхой арга хэмжээ авч хэрэгжүүлэх</p> <p>Хохирогч төвтэй хэрэг хянан шийдвэрлэх аргачлалд суурилан</p>	<p>Биеэ үнэлэх зөрчилд шийтгэл оногдуулахдаа бусдын биеийг үнэлж төлбөр төлсөн этгээдэд мөн шийтгэл оногдуулж байх талаар цагдаагийн байгууллагад шаардлага хүргүүлэх, хяналт тавих</p> <p>Биеэ үнэлэх, бусдын биеийг үнэлэн бэлгийн харьцаанд орох зөрчлийг илрүүлэн шалгахдаа хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн шинж байгаа эсэхийг тогтоох зорилгоор ЗШШТХ-д заасан бүхий л ажиллагааг хийж байх</p> <p>Энэ төрлийн зөрчлийг аль болох хялбаршуулсан журмаар шийдвэрлэхээс татгалзах</p> <p>Энэ төрлийн зөрчил нуугдмал байдалд шилжсэн байж болзошгүй тул түүнийг илрүүлэх талаар идэвх, санаачилгатай ажиллах</p> <p>Цагдаагийн болон прокурорын</p>	<p>хамтарсан байдлаар, ур чадварт суурилсан сургалтын хөтөлбөрийн хүрээнд явуулах</p> <p>Судалгааны үр дүнгээс харвал 2017-2021 онд цагдаагийн байгууллагад хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэг нийт 241 бүртгэгдэж, 3 хэрэг хэрэгсэхгүй болж, 137 хэргийн хэрэг бүртгэлтийг хаасан нь нийт гэмт хэргийн 58% нь мөрдөн байцаалтын болон прокурорын хяналтын шатанд дуусгавар болж байгааг анхаарч, хэрэг бүртгэлтийн хэргийг хаасан, хэрэгсэхгүй болгосон хэргийн үндэслэл бүрэн нотлогдсон эсэх, шаардлагатай мөрдөн шалгах ажиллагаа явагдсан эсэх талаар судалгаа хийх</p>
--	---	--	---	--

	<p>хэрэгжилтийн үр дагаврын үнэлгээг хийж, цаашид хуулийн зохицуулалтыг боловсронгуй болгох чиглэлээр шат дараалсан арга хэмжээ авах;</p> <p>ЭХХШТХ-д нэмэлт оруулах замаар гэмт хэргийн талаарх гомдол мэдээллийг шалгах ажиллагааны явцад мөн хуульд заасан мөрдөн шалгах нууц ажиллагаанаас бусад бүх ажиллагааг явуулах боломжтой байхаар хуульчлах /одоо 6 төрлийн ажиллагаагаар хязгаарлагдсан байгаа/</p> <p>Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.3 дугаар зүйлд заасан Бэлгийн мөлжлөг 12.3.2, 12.3.3 дахь хэсэг, 13.13 дугаар зүйлд заасан Албадан хөдөлмөрлүүлэх, 15.3 дугаар зүйлд заасан Хүний цус, эс, эд, эрхтэнийг хууль бусаар авах, 16.4 дүгээр зүйлд заасан Хүүхдээр гуйлга гуйлгах, 16.6 дугаар</p>		<p>шүүх эрх мэдлийн байгууллагын алба хаагчдыг бэлтгэх, давтан сургах ур чадварт суурилсан сургалтын хөтөлбөрийг боловсруулж, хэрэгжүүлэх</p>	<p>байгууллагын бүтцэд бий болсон хүн худалдаалах болон хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөх, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийг бэхжүүлэх, орон нутагт ажиллах орон тоо, бүтцийн асуудлыг шийдвэрлэх, Эдгээр бүтцийн нэгжид ажиллаж буй алба хаагчдыг тогтвор суурьшилтай ажиллуулах талаар бодлогын шийдвэр гаргаж, хэрэгжүүлэх</p> <p>Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэргийн талаарх гомдол, мэдээллийг хүлээн авсан бол аль болох хэрэг бүртгэлтийн хэрэг нээхээс татгалзахгүй байх чиглэлд анхаарах.</p> <p>Шаардлагатай бүхий л ажиллагааг явуулж, үйл баримтыг хангалттай нотолсны дараа эрүүгийн хэрэг үүсгэх эсэх асуудлыг шийдвэрлэж байх</p> <p>Энэ төрлийн гэмт хэргийг аль болох Эрүүгийн хуулийн тусгай ангийн 13.1 дүгээр зүйлд зааснаар</p>	
--	---	--	---	---	--

<p>зүйлд заасан Хүүхэд худалдах, 16.8 дугаар зүйлд заасан Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дүгээр зүйлд заасан Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10 дугаар зүйлд заасан Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг хүчингүй болгож энэ төрлийн гэмт хэргийг мөн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан Хүн худалдаалах гэмт хэрэг үйлдсэнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх ;</p> <p>Донорын тухай хуулийн шинэчилсэн найруулга батлагдаж, хэрэгжиж байгаатай уялдуулан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд 1 дэх заалтад “цус, эс” ... гэж нэмэх</p> <p>Эрүүгийн хуулийн тусгай ангид заасан хүн худалдаалах болон түүнтэй төстэй хэргийг хэрхэн зүйлчлэх талаар тайлбар гаргах</p> <p>Хууль зүйн туслалцааг ялгаварлалгүй эдлэх эрх зүйн орчныг</p>		<p>эрүүгийн хэрэг үүсгэж, мөрдөн шалгах ажиллагаа явуулж, цугларсан нотлох баримтад тулгуурлан шийдвэрлэх /зүйлчлэл өөрчлөх гэх мэт</p> <p>ЭХХШТХ-д заасан зарчим, журмыг ягштал биелүүлж байх</p> <p>Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчийн нэхэмжилсэн нэхэмжлэлийг аль болох хавтаст хэргийн хамт шийдвэрлэхэд анхаарах</p> <p>Энэ төрлийн гэмт хэргийн хохирогчид учирсан сэтгэл санааны хохирлыг нотлох баримтыг өөрөөр нь гэхээсээ илүүтэй мөрдөн шалгах тодорхой ажиллагаа явуулах замаар баримтжуулж, шүүхийн шийдвэрийн үндэслэл болгоход анхаарах</p> <p>Мөрдөн шалгах ажиллагаа хэрэгжүүлж буй мөрдөгч, хяналт тавьж буй прокурорыг аль болох солихгүйгээр мөрдөн шалгах</p>	
--	--	---	--

<p>бүрдүүлэх зорилгоор Хууль зүйн туслалцааны тухай хуулийг батлах.</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэгт хууль зүйн туслалцаа үзүүлэх журмыг хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага батлахаар зохицуулсан тул журмыг баталж, хэрэгжилтэд хяналт тавих</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт хохилогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө гэж заасан хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс “Сэтгэл санааны хохирол тооцох” аргачлалыг яаралтай боловсруулж, практикт нэвтрүүлэх</p> <p>Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийг бүртгэх, хэргийн хөдөлгөөнийг хянах, хохирогчид үзүүлж буй</p>		<p>ажиллагааг явуулах. Шаардлагатай тохиолдолд ЭХХШТХ-д заасан мөрдөгчдийн ажлын хэсэг байгуулах асуудлыг хэргийн нөхцөл байдал, оролцогчдын тооноос хамаарч зохион байгуулах</p> <p>Мөрдөн шалгах ажиллагааг аль болох хуулийн богино боломжит хугацаанд явуулах, ингэхдээ хэргийн нөхцөл байдлыг тал бүрээс нь бүрэн бодитой тогтооход анхаарах</p> <p>Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж, прокурор яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлсэн 3 хэрэг тутмын нэг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байгаад анхаарч, цаашид хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, шүүхэд хуулийн хамгийн боломжит богино хугацаа зарцуулж, хэргийг шийдвэрлэж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах</p>	
--	--	--	--

	үйлчилгээний талаарх бүх мэдээллийг нэгтгэсэн мэдээллийн санг бий болгох Эрүүгийн хуульд энэ төрлийн гэмт хэрэгт оногдуулахаар заасан ялын интервалыг Палермогийн протоколын зорилгыг хангахуйцаар тогтоосон байдлаар нийцүүлэн өөрчлөх			Хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэрэгт ял оногдуулахдаа харилцан адилгүй ял шийтгэл оногдуулахгүй байхад анхаарч, нэгдсэн ойлголттой болох чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах, нэгдсэн бодлого боловсруулж, хэрэгжүүлэх	
13	Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийн нэр төр, аюулгүй байдлыг хамгаалах талаарх олон улсын туршлага, ГХУСАЗЗ, Азийн сан, 2022 Санхүүжүүлэгч: АНУ-ын Төрийн Департамент	Нэгдмэл, цогц байдал, олон талын оролцоо Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын үйл ажиллагаа нэгдмэл, цогц шинжтэй олон салбарын огтлолцол дээр явагддаг үйл ажиллагаа болохыг харгалзан үзэх хэрэгтэй. Зөвхөн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг түлхүү авч хохирогчийн бие махбод, сэтгэл зүйн эмзэг байдлыг эс хайхарвал бүрэн үр дүнд хүрэхгүй бөгөөд эсрэгээрээ хохирогчийг хууль хяналтын байгууллагаас зугтах, зайлсхийх байдалд хүргэх, мөрдөн шалгах ажиллагааны дүнд	3. Хохирогчийг таньж тогтоох ажиллагаа Хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчийг аль болох эрт таньж тогтоох нь аюулгүй байдлыг хангах арга хэмжээний урьдач нөхцөл болдог. Гэсэн хэдий ч Монгол Улс хохирогчийг таньж тогтоох нэгдсэн аргачлалгүй, хууль сахиулах байгууллагаас өөр салбарын ажилтан албан хаагчид хохирогчтой тааралдсан ч таньж мэдэх, тогтоох мэдлэг, мэдээлэлгүй байгаа юм. Иймд энэхүү судалгаанд заасан туршлагыг харгалзан хүн худалдаалах гэмт хэргийн хохирогчтой ажиллаж болохуйц боловсрол, эрүүл мэнд, хууль сахиулах байгууллагын зэрэг алба хаагчдын гүйцэтгэх үүргийг тусгасан нэгдсэн аргачлал гаргах шаардлагатай. Аргачлалыг Хууль зүй, дотоод хэргийн яамнаас манлайлж, хүн худалдаалахтай тэмцэх чиглэлээр ажилладаг бусад төрийн болон төрийн бус байгууллагатай хамтран	2. Арга барил, хандлага Хүн худалдаалахтай тэмцэх, энэ төрлийн гэмт хэргийн хохирогч хамгааллын чухал хэсэг нь хууль сахиулах болон бусад байгууллага, албан хаагчдын хандлага, арга барил юм. Энэ чиглэлээр аливаа арга хэмжээг авч хэрэгжүүлэхдээ хохирогчийн эрх, нэр төрийг хүндэтгэн үзсэн байна. Хохирогч төвтэй, жендэрийн мэдрэмжтэй, хохирогчид учирсан сэтгэцийн гэмтэл, эмгэг зэргийг харгалзан үзсэн хандлага нь гол суурь болно.	Хохирогч хамгаалалтай холбоотой эрх бүхий байгууллагын хүлээх үүрэг, уг ажиллагаанд оролцох оролцооны талаарх Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн зарим зохицуулалт тунхаглалын шинжтэй байгааг өөрчилж, үйл ажиллагаа, дэс дараалал, журам хэлбэртэй болгох шаардлагатай. Энэ хүрээнд хохирогчийг таньж тогтоох, тусламж, үйлчилгээнд холбон зуучлах, хамгаалах, Түүнчлэн эдгээр байгууллага хооронд мэдээлэл, статистик, бусад шаардлагатай

	<p>нөлөөлөх эрсдэлтэй. Юуны өмнө хүн худалдаалахтай тэмцэх үүрэг хүлээсэн субъектүүд чиг үүргийнхээ талаар нэг мөр ойлголттой, хоорондын үйл ажиллагааны уялдаа холбоог хангах үүднээс хуулиар тодорхойлсон үйл ажиллагааны зарчмыг нарийвчилж гаргах хэрэгтэй. Түүнчлэн хүүхдийн дээд ашиг сонирхлыг хамгаалах зарчмыг хуульд тусгах шаардлагатай. тусламж үйлчилгээ үзүүлэх зэрэг одоогийн хуульд заасан үйл ажиллагаанд хууль сахиулах, хил хамгаалах, прокурор, боловсрол, эрүүл мэндийн болон сэтгэл зүйн үйлчилгээ үзүүлдэг байгууллагууд хэрхэн оролцох талаар журамласан зохицуулалт бий болгох хэрэгтэй.</p>	<p>боловсруулах нь зүйтэй. Түүнчлэн эрүүгийн хэрэг үүсгэх эсэхийг шийдвэрлэх ажиллагаа нь тодорхой цаг хугацаа, баримт нотолгоо шаарддаг бөгөөд энэ хооронд хохирогч хамгааллын үйл ажиллагаа алдагдах эрсдэлтэй тул “хохирогч байж болзошгүй” гэж таньж тогтоон хамгаалалтын арга хэмжээг авах шаардлагатай байдаг.</p> <p>4. Хохирогчийг мэдээллээр хангах Хохирогчийн сэтгэл зүйн байдлыг тогтворжуулж хамгаалах үйл ажиллагааны салшгүй чухал хэсэг нь түүнд шаардлагатай мэдээллийг цаг алдалгүй, ойлгомжтой тодорхой хэлбэрээр өгөх явдал юм. Гэвч хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогчид мэдээлэл өгөхтэй холбоотой нарийвчилсан зохицуулалт тусгагдаагүй. Иймд шинээр боловсруулах журамд хохирогчид өгөх мэдээллийн жагсаалтыг тусгаж болох юм. Үүнд:</p> <ul style="list-style-type: none"> - Төрийн болон төрийн бус байгууллагаас үзүүлдэг тусламж, үйлчилгээ - Эрүүгийн болон захиргааны шинжтэй процессын үе шат, үйл явц - Хууль зүйн үнэ төлбөргүй эсхүл бага хэмжээтэй туслалцаа авах боломж - Хохирогчийг болон гэр бүлийн гишүүдийг хамгаалах арга хэмжээ - Хувийн нууцлалаа хангуулах эрх - Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаанд мэдээлэл авах эрх 		<p>Энэ хүрээнд эдгээр хандлагыг алба хаагчдын түвшинд нэг мөр ойлгох, сургалтад заавал хамруулах зэрэг асуудлыг Хууль зүй, дотоод хэргийн яам, Улсын Ерөнхий прокурорын газраас хамтран батлах журамд тусгах боломжтой</p> <p>5. Хамгаалалтын арга хэмжээ авах журам Юуны өмнө эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагааг эхлүүлж, хохирогчоор албан ёсоор тогтоосон эсэхээс үл хамаарч хүн худалдаалах гэмт хэргийн улмаас хохирсон байж болзошгүй гэж үзсэн бол шаардлагатай хамгаалалтын арга хэмжээг цаг алдалгүй авах талаар журамд тусгах хэрэгтэй. Мөн аливаа арга хэмжээг заавал хохирогчийн дагуу явуулах талаар журамд тодорхой тусгаж өгөх хэрэгтэй. Учир нь хамгаалалтын ажиллагаа өөрөө албадлагын арга хэмжээ биш тул сайн дурын оролцоонд</p>	<p>мэдээллийг цаг алдалгүй солилцож байх зарчмыг тогтоох нь зүйтэй. Ингэснээр хохирогч хамгаалах чиглэлээр ажилладаг байгууллага, албан тушаалтны үйл ажиллагааны уялдаа холбоо хангагдана.</p> <p>6. Хууль сахиулах байгууллагуудын хамтын ажиллагаа Судалгаанд дурдсан зарим улс төрийн болон төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг цахимаар мэдээлэл солилцож, шийдвэр гаргах хувилбарыг нэвтрүүлэх боломжтой.</p> <p>Ийм сувгийг ашиглан хохирогчийг таньж тогтоох, шаардлагатай тусламж үйлчилгээ үзүүлэх, хамгаалалтын арга хэмжээ авах ажиллагааг тасралтгүй явуулж, ажиллагааг хөнгөвчилж болно. Үүний тулд цахим платформ хөгжүүлэх бөгөөд хохирогчийг таньж тогтоох, байгууллага хооронд</p>
--	---	--	--	--	--

		<p>- Хохирол нөхөн төлүүлэх асуудал - Гадаадын иргэн, харьяалалгүй хүний хувьд оршин суух зөвшөөрөл, орогнол, оршин суух эрх хүсэхтэй холбоотой зохицуулалт</p> <p>Мөн хохирогчид ойлгомжтой, тодорхой байдлаар шаардлагатай гэсэн бүхий л мэдээллийг ойлгомжтой, тодорхой байдлаар өгөх үүргийг хууль сахиулах болон прокурорын байгууллагын алба хаагчдад хүлээлгэх нь зүйтэй.</p> <p>7. Насанд хүрээгүй хохирогчийг хамгаалах Хохирогч хамгааллын арга хэмжээ дотор насанд хүрээгүй хохирогчийн онцлогт тохирсон арга хэмжээ чухал ач холбогдолтой байна. Эдгээрт аюулгүй байдлыг нэн даруй хангах, гэмт хэрэг үйлдэгчээс тусгаарлах (гэр бүлийн гишүүн нь уг гэмт хэрэгт оролцсон бол мөн адил тусгаарлах), нас, бие хөгжлийн онцлогт тохирсон хамгаалах байранд байрлуулах, мэдүүлгийг мэргэшсэн, адил хүйсийн ажилтнаар, аль болох тайван орчинд авхуулах, нас, гэр бүл зэрэг нөхцөл байдлыг нь харгалзан үзэх, өөрөө сайн дураар ярих боломжийг бүрдүүлэх, аль болох цөөн удаа мэдүүлэг авах, хамгийн итгэлтэй гэсэн хүнийг байлцуулах зэрэг арга хэмжээг авах нь зүйтэй байна. Түүнчлэн хохирогчийг насанд хүрсэн эсэхийг шууд тодорхойлох боломжгүй байгаа бол насанд хүрээгүй хүнтэй адилтган авч үзэж, албан ёсоор нас тодорхойлох</p>		<p>тулгуурлах хэрэгтэй. Мөн хохирогчийн аюулгүй байдалд үүсэж болох эрсдэлийг тогтмол үнэлэх үүргийг тухайн хэргийг шалгаж буй мөрдөгч, прокурорт өгөх шаардлагатай. Ингэснээр хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээг цаг алдалгүй авах, хохирогчийн бодит нөхцөл байдлын талаар мөрдөгч, прокурор мэдээлэлтэй болох ач холбогдолтой. Хохирогчийн аюулгүй байдлыг хангах арга хэмжээ өөрөө зардал өндөртэй. Харин Тайваньд аюулгүй байдлыг хангах арга хэмжээнд гарсан зардлыг буруутай этгээдээр төлүүлдэг механизм байгаа бөгөөд үүнийг судалж нэвтрүүлэх боломжтой.</p>	<p>шуурхай холбоо тогтоох, ажиллагааны бүртгэл-хяналт хэрэгжүүлэх, тусламж үйлчилгээ, хамгаалалтын арга хэмжээнд холбон зуучлах, тайлан мэдээлэл гаргах зэрэг функцийг эхний ээлжид хөгжүүлэх ёстой. Ингэснээр хүн худалдаалах гэмт хэргийн хохирогч хамгааллын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллага хоорондын харилцаа сайжрахаас гадна уялдаа холбоо нь хангагдах, нэгдсэн бүртгэл статистик хийх, улмаар шаардлагатай тусламж, үйлчилгээг нэг ч хохирогч үлдээлгүй жигд хүргэх нөхцөл бүрдэнэ.</p>
--	--	---	--	---	---

		хүртэл хамгаалалтын арга хэмжээ авах хэрэгтэй талаар олон улсын баримт бичгүүдэд зөвлөмж болгосныг журамд тусгах нь зүйтэй.			
14		<p>ГБХЗХГ-аас холбогдох байгууллагатай хамтран ХХГХ-т өртөж хохирсон хүүхэд болон тусгай хэрэгцээт хүнийг хамгаалах, үйлчилгээ үзүүлэх стандартыг баталж, хэрэгжүүлэх. Ингэснээр хамгаалах байрны бүтэц, зохион байгуулалт, үйл ажиллагааг журамлах боломжтой болно.</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуульд хохирогч хүүхдийн нас, сэтгэхүйн онцлогт тохирсон хохирогч хамгааллын үйлчилгээнд хамруулах зохицуулалтыг тусгах;</p> <p>Бэлгийн хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, ХХГХ-т өртсөн хүүхдэд үзүүлэх үйлчилгээний нэгдсэн удирдамжийг боловсруулах, хүүхдэд урт хугацаанд цогц үйлчилгээ үзүүлэх механизм бий болгох, хэрэгжүүлэх;</p> <p>Хохирогч хамгааллын үйлчилгээнд зориулсан санхүүжилтийг улсын болон орон нутгийн төсөвт суулгах, батлуулах;</p>	<p>ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажилд зарцуулагдаж буй төсвийг нэмэгдүүлэх, энэ төрлийн аливаа үйл ажиллагааг олон улсын санхүүжилтийг татах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах;</p> <p>ОУБ, ТББ-ын ХХГХ-ээс урьдчилан сэргийлэх чиглэлээр амжилттай хэрэгжсэн ажлуудыг хүний нас, хүйс, бэлгийн чиг баримжаа (ЛГБТ), нийгмийн ялгаатай бүлгүүд (хөгжлийн бэрхшээлтэй иргэд), амьдран суугаа газрын онцлогт тохируулан хүргэх, давтамж, цаг хүрээг нэмэгдүүлэх, төрийн байгууллагуудын төлөвлөгөөтэй уялдуулах,</p>	<p>ХЗДХЯ болон ГХЯ хамтран өмнө нь байгуулсан эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээний хэрэгжилтийг дүгнэх;</p> <p>Үндэстэн дамнасан зохион байгуулалттай гэмт хэрэг /ХХГХ хамаарна/ ихээр үйлдэгдэж буй Малайз, Норвег, Швед, Арабын Нэгдсэн Эмират, Камбож, Япон, Филиппин, АНУ зэрэг гадаадын улсуудтай Эрүүгийн хэргийн талаар эрх зүйн туслалцаа харилцан үзүүлэх гэрээг яаралтай байгуулах;</p> <p>Монгол Улсын Эрүүгийн хууль /шинэчилсэн найруулга/-ийн 12.3 дугаар зүйлд заасан</p>	<p>ХХГХ-ийн чиглэлээр бэлтгэгдсэн, чадавхжуулсан албан хаагчдыг тогтвор суурьшилтай ажилуулахад төрийн байгууллагууд хүний нөөцийн бодлогоо чиглүүлэх;</p> <p>Эрсдэлт нөхцөлд байгаа хүүхэд, хохирогч байж болзошгүй хүмүүсийг эрт илрүүлэх, хохирогчдод үйлчилгээ үзүүлэх чиглэлд төрийн байгууллагууд нь ОУБ-тай Техникийн зөвлөгөө өгөх, зөвлөн туслах, санхүүжүүлэхэд, ТББ-тай хохирогчдод үйлчилгээ үзүүлэхэд хамтран ажиллах;</p> <p>ХХГХ-ийн талаар мэдээллийн санг бий болгох ажлыг</p>

			<p>санхүүжилтийг нэмэгдүүлэх;</p> <p>Нутаг дэвсгэр хариуцсан цагдаа, прокурор, шүүх, хилийн шалган нэвтрүүлэх алба, боловсрол болон эрүүл мэнд байгууллагуудын албан хаагчдын ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр кейсэд болон асуудалд суурилсан үр дүнтэй сургалтуудыг энэ чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг байгууллагатай эсвэл мэргэшсэн эрдэмтэн судлаачдын багтай хамтран холбогдох төрийн байгууллага зохион байгуулах;</p> <p>ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий байгууллагуудын хуулиар хүлээсэн үүргийг холбогдох салбарын журам, зохицуулалтын баримт бичигтэй уялдуулах ажлыг эрчимжүүлэх, үйл</p>	<p>Бэлгийн мөлжлөг 12.3.2, 12.3.3 дахь хэсэг, 13.13 дугаар зүйлд заасан Албадан хөдөлмөрлүүлэх, 15.3 дугаар зүйлд заасан Хүний цус, эс, эд, эрхтнийг хууль бусаар авах, 16.4 дүгээр зүйлд заасан Хүүхдээр гуйлга гуйлгах, 16.6 дугаар зүйлд заасан Хүүхэд худалдах, 16.8 дугаар зүйлд заасан Хүүхдэд садар самууныг сурталчлах, уруу татах, 16.9 дүгээр зүйлд заасан Хүүхэд оролцуулж садар самууныг сурталчлах, 16.10 дугаар зүйлд заасан Хүүхдээр тэвчишгүй хөдөлмөр эрхлүүлэх гэмт хэргийг хүчингүй болгож энэ төрлийн гэмт хэргийг мөн хуулийн 13.1 дүгээр зүйлд заасан ХХГХ үйлдсэнд тооцож эрүүгийн хариуцлага хүлээлгэх;</p> <p>Донорын тухай хуулийн шинэчилсэн</p>	<p>эрчимжүүлэх, тогтвортой ажиллуулах төлөвлөгөөг гаргах, холбогдох зардлыг шийдэх, ХХГХ-тэй тэмцэх чиглэлээр ажилладаг байгууллагууд өөр хоорондоо ил тод, мэдээлэл солилцох тал дээр нэгдсэн ойлголтод хүрэх;</p> <p>ХХГХ-тэй тэмцэх чиглэлд төрийн байгууллагуудын оролцоог нэмэгдүүлэхийн тулд албан хаагчийн, ялангуяа хүүхдийн эрхийн байцаагч, хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч, хүүхдийн эрхийн хууль зүйн хорооны гишүүн, баг/хороо болон сургуулийн нийгмийн ажилтны ажил үүрэгт нь тодорхой тусгах, үйл ажиллагааны зардлыг нэмэгдүүлэх, цалин хөлс, урамшууллыг олгох, чадавх бэхжүүлэх болон мэргэжлийн дэмжлэг тусалцааг холбогдох</p>
--	--	--	--	---	---

			<p>ажиллагаанд шаардагдах төсвийг тусган, хэрэгжүүлэх, хяналтыг тавих; Тухайлбал, Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөт нэвтрэх заалтыг хэрэгжүүлэхийн тулд бусад хууль тогтоомжийг уялдуулах;</p> <p>Хүүхэд хамгааллын түншлэлийн компакт төслийн хүрээнд байгуулагдсан ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ажлыг уялдуулан</p>	<p>найруулга батлагдаж, хэрэгжиж байгаатай уялдуулан Эрүүгийн хуулийн 13.1 дүгээр зүйлд 1 дэх заалтад “цус, эс” ... гэж нэмэх;</p> <p>Цагдаагийн болон прокурорын байгууллагын бүтцэд бий болсон хүн худалдаалах болон хүүхдийн эсрэг үйлдэж буй гэмт хэрэгтэй тэмцэх, мөрдөх, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийг бэхжүүлэх, орон нутагт ажиллах орон тоо, бүтцийн асуудлыг шийдвэрлэх³⁷;</p> <p>Хүн худалдаалах, түүнтэй төстэй гэмт хэрэг болон хүүхдийн эсрэг үйлдсэн гэмт хэргийг шалгах, хяналт тавих чиг үүрэг бүхий нэгжийн албан</p>	<p>байгууллагуудаас үзүүлэх;</p>
--	--	--	--	---	----------------------------------

³⁷ Эрүүгийн цагдаагийн албаны Зохион байгуулалттай гэмт хэрэгтэй тэмцэх хэлтсийн Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх тасгийн алба хаагчдын хүний нөөц, орон тоо хангалтгүй, алба хаагчдын шилжилт хөдөлгөөн байнга явагддагтай холбоотой хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх чадавх суларч илрүүлэлт буурдаг. Жишээлбэл: Тус тасаг 2021 онд нийт 5 алба хаагч ажиллахаас 2 алба хаагч шилжиж, шинээр хоёр алба хаагч томилогдсон, шинээр томилогдсон алба хаагчдыг сурган дадлагажуулах хугацаа шаарддаг. Энэ онд 2 алба хаагч томилогдон ажиллаж байгаад 1 алба хаагч өөр албанд шилжин томилогдсон. Цаашид алба хаагч нарын ажлын ачааллыг тэнцвэржүүлэх, тогтвор суурьшилтай ажиллуулах, орон тоог нэмэгдүүлэх хэрэгцээ шаардлага тулгарч байна.

		<p>зохицуулах үүрэг бүхий салбар дундын хамтарсан багт оролцогч талуудын оролцоо, үүрэг, хариуцлагыг тодорхой болгох, үйл ажиллагааг нь цаашид тогтвортой үргэлжлүүлж, шаардлагатай санхүүжилтийг бий болгох зорилгоор салбар дундын хамтарсан багийн ажиллах эрх зүйн орчныг бүрдүүлэх;</p> <p>ГХУСА33-өөс ХХГХ-тэй тэмцэх, урьдчилан сэргийлэх чиг үүрэг бүхий төрийн болон төрийн бус байгууллагын албан хаагч, мэргэжилтнүүдэд зориулж, ХХГХ-ийн хохирогчийг таньж илрүүлэх удирдамжийн бичиг баримтыг батлан гаргаж, хэрэгжилтийг хангах;</p> <p>Төрийн байгууллагуудын ХХГХ-ээс урьдчилан</p>	<p>хаагчдын мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх чиглэлээр тогтмол сургалтад хамруулж байх;</p> <p>Хүн худалдаалах гэмт хэрэгтэй тэмцэх хууль, Хүүхэд хамгааллын тухай хуулиар үүрэг хүлээсэн оролцогч талууд нь хүүхдийн эсрэг үйлдэж буй хүн худалдаалах болон түүнтэй төстэй гэмт хэргийн талаар хийсэн судалгааны үр дүнг үйл ажиллагаандаа ашиглаж, энэ төрлийн гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нэг бүрчлэн арга хэмжээг авч хэрэгжүүлэх;</p> <p>Хүн худалдаалахтай тэмцэх тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2 дахь хэсэгт хохирогчийн сэтгэл санааны хохирлыг мөнгөн хэлбэрээр нөхөн төлнө гэж заасан хуулийн хэрэгжилтийг хангах үүднээс “Сэтгэл санааны хохирол</p>	
--	--	---	---	--

			<p>сэргийлэх үйл ажиллагаанд шаардагдах төсвийг тусган, хэрэгжүүлэх, хяналтыг тавих;</p> <p>Хөдөлмөрийн тухай хууль /шинэчилсэн найруулга/-д хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч хяналт шалгалт явуулах аж ахуйн нэгж, байгууллага, ажлын байранд урьдчилан мэдэгдэхгүйгээр чөлөөт нэвтрэх заалтыг хэрэгжүүлэхийн тулд бусад хууль тогтоомжийг уялдуулах ажлыг салбарын эрх бүхий хүмүүс цаг алдалгүйгээр хариуцан хийх;</p> <p>Хөдөлмөрийн хяналтын улсын байцаагч нарыг сургалтад хамруулах, хүний нөөц болон санхүүжилтийг нэмэгдүүлэх, гэнэтийн шалгалт хийх эрхтэй болгох замаар</p>	<p>тооцох” аргачлалыг яаралтай боловсруулж, практикт нэвтрүүлэх;</p> <p>Цагдаагийн байгууллагаас мөрдөн шалгах ажиллагаа явуулж, прокурор яллагдагчаар татаж шүүхэд шилжүүлсэн гурван хэрэг тутмын нэг нь шүүхээр эцэслэн шийдвэрлэгдсэн байгаад анхаарч, цаашид хэргийг түргэн шуурхай шийдвэрлэх, шүүхэд хуулийн хамгийн боломжит богино хугацаа зарцуулж, хэргийг шийдвэрлэж байх талаар зохион байгуулалтын арга хэмжээ авах;</p>	
--	--	--	---	---	--

			<p>ААНБ-уудад хийх шалгалтыг сайжруулах, хөдөлмөрийн мөлжлөгийн шалгуур үзүүлэлтээр таньж, илрүүлэх, үнэлгээ өгөх;</p> <p>Насанд хүрээгүй хүүхдийг садар самуунд уруу татах, секс аяллыг зохион байгуулах, хүүхдийг цахим бэлгийн мөлжлөгөөр ашиглах асуудлыг гүнзгийрүүлэн судлах, дүн шинжилгээнд суурилсан урьдчилан сэргийлэх ажлыг холбогдох төрийн байгууллагууд (ХЗДХЯ, ХНХЯ, ЦЕГ ба бусад), ХХГ-тэй тэмцэх чиглэлээр үйл ажиллагааг явуулдаг ТББ-уудтай хамтран зохион байгуулах, үр дүнг танилцуулах;</p> <p>ХХГХ-ийн хохирогчид нь уг гэмт хэргийн элсүүлэх үйл явцад оролцож байгаатай холбоотой тэдний хууль, эрх зүйн мэдлэгийг</p>		
--	--	--	--	--	--

			дээшлүүлэх, ажил мэргэжлийн чиг баримжаа олгох, хорт зуршлаас (архи, мансууруулах бодис, сэтгэцэд нөлөөлөх эм бэлдмэл) сэргийлэх, нийгмийн харилцаанд идэвхтэй оролцоход чиглэгдсэн олон талт сургалт, хөтөлбөрийг төрийн болон төрийн бус байгууллагууд санаачлан хэрэгжүүлэх, холбогдох зардлыг шийдэх;		
--	--	--	---	--	--